

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY



УИХ-ын гишүүдийн нэр хүнд  
унасны учир

Хууль шиг хуультай больё


Шинэ Засгийн газрыг ямар орчин  
хүлээж байна вэ?

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2012. 07 сар. №13 (023)

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

## ЭНГИЙН АГААД ЭРХЭМСЭГ ХАТАГТАЙ





# TRAVERSE



## ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Хөдөлгүүрийн багтаамж	1500сс
Цилиндрийн тоо	4
Хөдөлгүүрийн чадал	100 /морины хүчтэй/
Хурдны хайрцаг	5-шатлалт автоматик
Шатахууны төрөл	Бензин АИ-92
Хөтлөгчийн байрлал	FWD
Тоормосны систем	ABS
Дугуйн хэмжээ	185x75x16
Баталгаа	1 жил 25.000км

RioTinto



RioTinto

Монголын Үндэсний  
Олимпын хороо  
АЛТАН ТҮНШ



# Оюу Толгой төсөл, Олимпийн багийн амжилт Рио Тинтогийн бахархал

[www.riotinto.com/london2012](http://www.riotinto.com/london2012)  
[www.ot.mn](http://www.ot.mn)

уурхайн гүнээс  
аваргың энгэрт



# Бид КАТ-ын машинуудаас гадна бусад брэндүүдийг ч түрээслэнэ!



## ВАГНЕР АЗИ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХХК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК -аас та өөрт хэрэгцээтэй бүхий л тоног төхөөрөмжийг сонгон түрээсээр хэрэглэх боломжтой. Зөвхөн КАТ-ын машин, тоног төхөөрөмжөөс гадна бусад брэндүүдийн компрессор, гагнуурын аппарат, гэрлийн цамхаг, халаагуур, агаарын тавцан, усны шахуурга, дизель генератор болон бусад төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээг Монголдоо хамгийн сайн үйлчилгээтэй баг хамт олон танд хүргэх болно.



Баруун Үйлдвэр-133, Баянгол дүүрэг,  
Улаанбаатар-16030, Монгол Улс.  
Утас: 976-11-687588, Факс: 976-11-687587  
[www.wagnerasia.com](http://www.wagnerasia.com); <http://catrentalstore.com/wagnerasia>

WAGNER ASIA





# ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

**ТАНЫ ЗЭЭЛИЙГ БОГИНО ХУГАЦААНД ШИЙДВЭРЛЭНЭ**



**ШИНЭ АМЬДРАЛД  
ХАМТДАА ТЭМҮҮЛЬЕ**

**ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА**



**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК**

Хаяг: Жуулчны гудамж 7, Бага тойруу 12, Улаанбаатар хот, Монгол улс  
Утас: +976 11 312362, 1977 (24 цаг) Факс: +976 11 327028 [www.tdbm.mn](http://www.tdbm.mn)

# MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ВЭБ РЕДАКТОР

Б.Энхмарт

ОРЧУУЛАГЧ:

Б.Үүрийнтуяа

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Б.Ууганбаяр

Х.Хулан

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР:

Ш.Оюундарь

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ МЕНЕЖЕР:

Ж.Алтантуяа /9905-1914/

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Баранжав /8880-0825/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш

“ECONOMY” ТВ СТУДИ

ДЭД ЗАХИРАЛ:

Ц.Буянбат /8811-2885/

ЗУРАГЛААЧ:

Ц.Бат-Отгон

ГРАФИК ДИЗАЙН

Г.Буянбаатар

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,

Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

ΑΙΘΕΡΟΕΛΑΘ ΟΥΑΪ Α:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall"



Шинэ УИХ бүрэлдлээ. 22 настай Арчилсан нам сонгуульд давуу эрх эдэлж, төр, засгийг эмхлэн байгуулах ажилдаа орлоо. Өөрөөр хэлбэл, монголчууд 22 жилийн дараа ардчиллаар овоглосон намд итгэл хүлээлгэхээр шийдсэн юм. Эдийн засгийн хөгжлийн гараан дээр ирсэн энэ үед ард түмэн өөрчлөлт шинэчлэлийг хүсэж ийм сонголт хийсэн.

Ардчилсан нам шинэ засгийг аль нэг нам, эвсэлтэй хамтран байгуулах санал санаачилга гаргаж буй энэ цаг мөчид жинхэнэ ардчиллын түүх болсон их гүрний Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон манай улсад нэг өдрийн айлчлал хийгээд буцсан билээ. Тэрбээр сонгуулийн үр дүнд ардчилсан засаглал бүрэлдэж байгаад талархаж буйгаа илэрхийлээд Монгол Улсыг эмэгтэй Ерөнхийлөгчтэй болох таатай мэдээг хүлээн байх болно хэмээсэн нь иргэдэд нэгийг бодогдуулж, хоёрыг тунгаахад хүргэсэн болов уу. Дэлхий даяараа андахгүй америк эмэгтэйчүүдийн үлгэр жишээ болсон Хиллари Клинтоньг “Mongolian Economy” сэтгүүл тэргүүн нүүрэндээ онцлон буйдаа баяртай байна. Тэр бол зөвхөн АНУ бус дэлхийн төдийгүй монгол эмэгтэйчүүдийн үлгэр жишээ болсон улстөрч юм.

Харин энэ удаагийн дугаарынхаа онцлох материалаар шинэ УИХ-д хандсан нийтлэлүүдийг сонгож байна. Хөгжлийг урагшлуулах, шинэчлэлийн салхи сэвэлзүүлэх итгэл хүлээлгэсэн энэ Парламент эхнээсээ ёс зүйтэй, жудагтай яваасай гэсэн итгэл найдварын үүднээс нийтлэлүүдээ шинэ Парламентад хаяглаж бичлээ. Тухайлбал, Монголын тулгын гурван чулуу, монгол сэтгэхүйн эргэн тойронд ярилцсан редакцийн уулзалт таны сонирхлыг татна гэж бодож байна. Бид шинэ засаг төр байгуулагдаж байгаа ийм үед монгол сэтгэхүүд тулгуурлаж улс орон хөгжинө, иргэдийнхээ уламжлалт монгол сэтгэлгээг сэргээн хөгжүүлэх хэрэгтэй байгааг энэхүү ярилцлагаар гаргаж ирэхийг хичээсэн болно.

Мөн манай сэтгүүлчид хилийн дээс алхан улс орнуудын хөгжлийн асуудлаар сурвалжлага, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн уншигчдадаа хүргэж эхэлж байгаад Эрхлэгчийн хувьд үнэхээрийн баяртай байна. Сэтгүүлч Х.Хулан, Ц.Бат-Отгон нарын Германы компаниудын нийгмийн хариуцлагын туршлагатай танилцсан аяллын сурвалжлагыг уншаарай.

Эрхлэгч Д.БЭХБАЯР


**УИХ-ын гишүүдийн нэр хүнд унасны учир**



Парламентаас зоригтой шинэчлэл, өөрчлөлтийг хүсэж байгаа, олон нийт. Өмнөх гишүүдийн алдааг давтахгүй, жинхэнэ төрийн хүний, УИХ-ын гишүүний ёс зүйтэй ажиллана гэж итгэж байна, бид. ...14

**Эрхэм гишүүнийг шинжихүй**

Тэнэг толгойтой гишүүн маш ховор. Хөөрхийг бусад нь хочилж нүд үзүүрлэдэг учраас “тэнэг толгой” гэх нэр үүссэн гэлцдэг. Ийм шинжийн гишүүд тэнэг учраас өөрийгөө мартаж, дан ганц таны төлөө чин сэтгэлээсээ зүтгэдэг. Тэгэхээр ийм толгойтонтой учирвал тэнгэрийн умдаг атгалаа л гэсэн үг...20



**Залуучуудынхаа оюун, сэтгэлгээний эх оронч үзлийн замыг засъя**



Нийтлэлч Н.Баабарын хэлдгээр “Бидний үе үхээд, тэрний дараагийн, дараагийн үеэс л монгол сэтгэхүй бий болж, социалист сэтгэхүй устгах байх” гэдэг үнэн болоод байх шиг...26

**Ц.Батсох:  
Өохийн төсөвт хэт анхаарвал улсын төсөвтэйгээ хамт “шороодно” шүү**

Магадгүй ирэх есдүгээр сард улсын төсөвт тодотгол хийнэ байх. Дөнгөж байгуулагдаж буй Засгийн газар, УИХ амлалт биелүүлэхээс илүүтэй хариуцлага бодож, төсөвт тодотгол оруулна гэж харж байна. Зарлагаа нэмнэ гэхээсээ илүүтэй, танасан байдлаар төсөвт хандах болов уу...39



10 **Энгийн агаад эрхэмсэг хатагтай**

e

- 14 **УИХ-ын гишүүдийн нэр хүнд унасны учир**
- 16 **Ёсыг сахиж, төрийг төвшитгэе**
- 20 **Эрхэм гишүүнийг шинжихүй**
- 22 **Нэр алдраас илүү хүн чанарын тухай бод**
- 24 **Хууль шиг хуультай больё**
- 26 **Залуучуудынхаа оюун, сэтгэлгээний эх оронч үзлийн замыг засъя**

- 34 **Шинэ Засгийн газрыг ямар орчин хүлээж байна вэ?**
- 35 **Далд эдийн засаг 76-д ч хамаатай**
- 39 **Ц.Батсох:  
Өохийн төсөвт хэт анхаарвал улсын төсөвтэйгээ хамт “шороодно” шүү**

- 44 **Германы компаниудын нийгмийн хариуцлагатай танилцлаа**
- 50 **Гурвалсан түншлэл**
- 52 **Чимээгүй мөхөл**

## ЗАСГИЙН ГАЗАР

2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг Засгийн газраас баталлаа. Монгол хүнийг хөгжүүлэх, ажиллаж, амьдрах аюулгүй, таатай орчин бүрдүүлэх нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийн нэг юм. Мөн хүнд ээлтэй засаглалыг төлөвшүүлж, эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, хариуцлагатай уул уурхай, хүнд аж үйлдвэрийн суурийг тавих, боловсруулах, аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэх, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг дэмжсэн дэд бүтцийг хөгжүүлэхийг тэргүүлэх чиглэлээ болгож байна. Үүнтэй холбогдуулан жил бүрийн улсын төсвийн төлөвлөлт, төсвийн тодотголд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт заасан төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгийн болон урсгал зардлын санхүүгийн эх үүсвэрийг тусгахаар боллоо.

## БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Эрдэнэт-Мөрөн-Овоотын чиглэлд 628 км төмөр зам барихаар боллоо. Шинэ төмөр зам барихад ойролцоогоор 2.2 тэрбум ам.доллар шаардлагатай аж. Төмөр зам нь Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Мөрөн, Цагаан-Уул, Бүрэнтогтох, Хатгал, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Рашаант, Их-Уул, Тариалан, Булган аймгийн Хутаг-Өндөр, Бугат, Орхон аймгийн Баян-Өндөр сумын

нутгаар дайрч өнгөрнө. Тус төмөр замаар жилдээ Овоот-Мөрөнгийн чиглэлд 13.5 сая тонн, Мөрөн-Эрдэнэтийн чиглэлд 22.2 сая тонн ачаа тээвэрлэх бөгөөд хоногт 11-18 хос галт тэрэг нэвтэрнэ хэмээн төлөвлөжээ.

## ХОТ

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор европ технологи нэвтрүүлэх гэж байна. Бага болон дунд эрчим хүчний хэрэглээний



чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх БНЧУ-ын “Бакро” нь Монголын “Ган хийц” компанитай хамтран “Бакро хийц” хэмээх хамтарсан компани байгуулж, үйлдвэрлэлээ эхлүүлсэн агаад төвлөрсөн халаалт эхлэх үе буюу ес дүгээр сарын 15 гэхэд бүтээгдэхүүнээ нийлүүлэхээр төлөвлөн ажилдаа оржээ. Тус компани нь хоёр жилийн өмнөөс манайд эрчим хүчний хэмнэлт, дулааны алдагдлыг бууруулах, утааг бүрэн шаталтад оруулах судалгааг хийж эхэлсэн байна.


## ХӨДӨӨ АЖ АХУЙ

“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолоор өнгөрсөн онд малчдын

бэлтгэсэн ноосыг үндэсний үйлдвэрлэгчдийг төлөөлөх “Итгэмжлэгдсэн төлөөлөгч”, түүхий эд бэлтгэлийн хоршоодоор дамжуулан үндэсний үйлдвэрлэлд тушаах ажлыг улсын хэмжээнд хэрэгжүүлж, үндэсний 85 үйлдвэрт тушаасан 21 аймгийн 231 сумын 32977 малчны 4924 тонн ноосонд 9.8 тэрбум төгрөгийн урамшуулал олгожээ.

## ГАДААД ХУДАЛДАА

Манай улс энэ оны эхний хагас жилд дэлхийн 123 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5575.6 сая ам.долларт хүрлээ. Үүнээс экспорт 2262.3 сая ам.доллар, импорт 3313.3 сая ам.долларын бараа бүтээгдэхүүн эзэлж байна. Үүнд импортын өсөлт экспортынхоос 8.1 хувир илүү байгаа нь нөлөөлсөн байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 857.2 сая ам.доллар буюу 18.2 хувь, үүний дотор импортын хэмжээ 587.7 сая ам.доллар буюу 21.6 хувь, экспортын хэмжээ 269.5 сая ам.доллар буюу 13.5 хувиар өсчээ. Экспортын 98.6 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, нэхмэл



бүтээгдэхүүн, авто ба агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги эзэлж байна.

## АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний хагас жилд 1018.8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 81.8 тэрбум төгрөг буюу 8.7 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд зэсийн баяжмал, металл агуулгаараа, молибдений баяжмал, металл агуулгаараа, цайрын баяжмал, газрын тос, төмрийн хүдэр зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.6-63.8 хувь голлон нөлөөлжээ.

## ЭРҮҮЛ МЭНД

Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийн шавийг тавилаа. Монгол Улсын Засгийн газар БНСУ-ын Засгийн газартай хамтран ажилласны үр дүнд 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээр байгуулав. Уг хөнгөлөлттэй зээлийн хүрээнд эхний ээлжинд Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийг барих бөгөөд нийтдээ 55.4 сая ам.долларын удаан хугацааны хөнгөлөлттэй зээл олгож,

Монгол Улсын Засгийн газраас нэмж 10.5 сая ам.долларын санхүүжилт гаргах юм. Энэхүү төв нь хамгийн сүүлийн үеийн тоног, төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдох бөгөөд дүрс оношилгоо, лаборатори, дотор, мэс засал, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасагтай байхаас гадна зайн оношилгоог улсын хэмжээнд явуулах хүчин чадалтай томоохон төв байх ажээ.

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**



Хонконг, Лондонд байрладаг олон улсын судалгааны “ECA international” байгууллагын судалгаагаар аялал жуулчлал, бизнес аялал, цагаачлал зэргээр эх орноосоо гарсан хүмүүст хамгийн таатай буюу амьдралын өртөг багатай хотоор Улаанбаатар шалгарчээ. Тус байгууллагын хийсэн судалгаагаар дэлхийн болон Азийн хамгийн өндөр өртөгтэй хотуудын жагсаалтыг ЯпоныТокио тэргүүлсэн байна.

**БИЗНЕС**

МҮХАҮТ-ын Бизнесийн итгэлийн индекс судалгааны энэ оны эхний хагас жилийн дүн гарлаа. Тус судалгаанд оролцогчид манай бизнесийн орчинд


дунд гэсэн үнэлгээ өгчээ. Үүнийгээ бизнесийн орчныг сайжруулахын тулд бизнес дэхь төрийн оролцоог багасгах, авилга, хүнд суртлыг бууруулах, хуулиа хэрэгжүүлж даган мөрддөг болгох, шударга өрсөлдөх орчин нөхцлийг бүрдүүлж өгөх шаардлагатай хэмээн онцолжээ.

**ХЯТАД**

Гадаад зах зээлээ өргөжүүлэхээр зэхэж байсан Хятад улсын эдийн засгийн өсөлтийн хурд улам удааширч буйг CNN агентлаг мэдээлж байна. Тус улсын Үндэсний статистикийн хорооноос өнгөрсөн баасан гаригт мэдээлснээр 2011 оны мөн үетэй харьцуулахад энэ оны хоёр дахь улиралд 7.6 хувийн өсөлттэй гарсан

нь 0.5 хувиар буурсан үзүүлэлт аж. Хэдийгээр АНУ-ын дөнгөж хоёр хувийн өсөлттэй харьцуулахад чамгүй өндөр тоо боловч урд хөршийн хувьд энэ нь 2009 оноос хойш гарсан хамгийн муу үзүүлэлт юм байна. Сүүлийн 30-аад жилийн турш Хятадын эдийн засгийн дундаж өсөлт жилийн 10 хувьтай байсан юм. Тус улсын Засгийн газар дотоодын үл хөдлөх хөрөнгийн зах зээл болон инфляцийн өсөлтөө хазаарлах зорилгоор эдийн засгаа барьж байсан нь уналтын гол шалтгаануудын нэг болсон хэмээн шинжээчид хэлж байна. Гэсэн ч Хятадын Засгийн газрын хэрэгжүүлсэн бодлого өгөөжөө өгчээ. Учир нь тус улсын инфляци сүүлийн хоёр жилд байгаагүйгээр

буураад байна. Харин дэлхийн эдийн засгийн хямралтай уялдаад Хятад улсын экспорт болон үйлдвэрлэлийн салбарын эрэлт буурчээ.



ХӨМСӨГ

## ЭНГИЙН АГААД ЭРХЭМСЭГ ХАТАГТАЙ

Б.ЭНХЦЭЦЭГ

Нэг мэдэхнээ цэлмэг тэнгэрийг бараан үүлс дайран эзэлж юу юугүй бороо шаагих нь уу гэлтэй аянга, цахилгаан дуу хадаан хэн хүнийг цочоон сүрдүүлнэ. Зуны хурц нарыг аадар бороо зөөллөж, энд тэнд гүйлдэх нимгэн хувцастай хүмүүсийг том том бороон дуслууд хайр найргүй цохилон норгож, гудамж талбайг угаах нь тэр. Хувьтай хүн хур борооноор гэдэг нь болов уу эсвэл өндөр дээд тэр хатагтайг өнгөлөг угтах гэсэндээ ч тэрүү айхтар ширүүн бороо гэнэт орсон шигээ гэнэт зогсож, нар гийв.

Үдийн 13:30 цаг. Талбайг хав дөрвөлжилж хаасан цагдаа нар мөрөө цэхлэн, цээжээ төмбийлгөж, хотын хөл, хөдөлгөөн хэсэгтээ намжиж, нам зогсох нь дэлхийн хүн Улаанбаатар хотын төв талбайд ойртон ирж байгааг зарлах мэт. Гялалзсан хар машинууд өдрийн цагаар урдах гэрлээ гялтгануулсаар энхтайвны гүүр даван нааш хурдалж харагдлаа.

Төрийн ордны зүүн талаар хүүе хаая гэхийн завдалгүй салхи татуулан орж ирэх машинуудад хурдаа хасах ч завдал өгөлгүй хар хувцастнууд чадамгай үсрэн бууж ийш тийш хараагаа гүйлгэж, сонор сэрэмжээ дээд цэгт хүргэнэ. Бие хамгаалагчид нь Америк кинон дээр гардаг шиг бие биедээ дохио өгөхөд сая нэг гүн цэнхэр өнгийн жийпнээс цайвар цэнхэр өнгийн нүдтэй, цагаан сор татсан шаргал үст эмэгтэй бууж ирэв.

Энэ эмэгтэй бол АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон юм. Дэлхийн долоон тэрбум хүн бүгд түүнийг танина даа бараг. Өдгөө 65 настай ч ануухан харагдах түүний царайнаас инээмсэглэл огтхон ч хөндийрөхгүй ажээ. Алтан шаргал судалтай бараан өнгийн хүрэм, хар өмд, намхан шаргал шаахай,

алтан ээмэг болоод бэлзэг Клинтон хатагтайн өнөөдрийн энгийн агаад эрхэмсэг гоёл байлаа.

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатарар газарчлуулан Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлэхээр улаан хивсэн дээгүүр алхах түүний төрх цаанаа л намбалаг агаад сүртэй.

### Хамгаас дээгүүр харц

Одоогоос 17 жилийн өмнө буюу Билл Клинтоньг АНУ-ын Ерөнхийлөгч байх үед Монгол Улсад анхлан зочилсон Хиллари хатагтай энэ удаад Их гүрний Төрийн нарийн бичгийн даргын хувиар Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн IV хуралдаан, Эмэгтэйчүүдийн манлайллын асуудлаарх олон улсын форумд оролцохоор ирж буй нь энэ юм. Түүний хаа яваа газрыг дэлхий сонордож байдаг болохоор мэдээллийн хэрэгслүүдийн дуранд Монгол өртөж, дэлхийгээр цацагдлаа.

Ардчиллын эцэг орны Төрийн нарийн бичгийн даргыг монголчууд бид ардчилсан гавьяагаар угтав. Өөрөөр хэлбэл, АН сонгуульд ялалт байгуулж, 10 эмэгтэй Парламентад суухаар болохын зэрэгцээ ардчиллын дээрх олон улсын хурлууд манай оронд болж байгаа нь нэр хүндийн хэрэг боллоо.

Хиллари Клинтон хамгийн түрүүнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж бараалхсан билээ. Үүний дараагаар орон орны эмэгтэй тэргүүлэгчдийн дунд зохион байгуулсан Эмэгтэйчүүдийн манлайллын асуудлаарх олон улсын форумд оролцсон. Манай Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ч тус хуралд үг хэлсэн юм. Тэрбээр “Ардчилал тогтох ▶



► боломжгүй гэж үзэж байсан газруудад ардчилал ялж болдгийн жишээг Монгол Улс харууллаа. Ардчилалд эргэлзэгчид Монголд ирцгээ гэж хэлье” хэмээн Хиллари Клинтоны номын хэсгээс ишлэн ярихад нь Төрийн ордны Их танхимд цугласан олныг болон номын зохиогчийг ч инээд алдан, алга ташихад хүргэсэн юм.


АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон тайван тогтуун алхаагаар индэр дээр гарч ирлээ. Эмэгтэй хүнээс гарамгүй баргилдуу гэмээр хүчтэй хоолой танхимд цугласан зочид төлөөлөгчдийг цочоох шиг болов. Нэгдсэн Үндэстэн гэдэг үгийг онцлон өндөр өнгөөр олонтаа дуудах нь их гүрний сүр хүч гэлтэй. Урдаа байрласан микрофоноос ч өндөрт эрүүгээ өргөн ихэмсэг төрхөөр ярих тэрбээр хааяа нэг алдалсан гараа яриандаа хүч нэмэх мэт оруулж ирнэ.

Хиллари Клинтон “Ноён Ерөнхийлөгчөө таны Монгол Улс хэзээ нэгэн цагт эмэгтэй ерөнхийлөгчтэй болно гэдэгт итгэдэг” гэсэн үг надад их таалагдлаа. Тэгэхлээр Монгол, АНУ-ын аль нь тэр өндөрлөгт эмэгтэйчүүдээ түрүүлж сонгох вэ гэдэг уралдааныг бид үзэх нь” гэж хэлсэн нь зочдыг баясгасан юм.

АНУ ардчиллын 200 жилийн түүхэндээ 44 Ерөнхийлөгчийн нүүрийг үзсэн ч эмэгтэй хүнээр улс орноо харахан удирдуулаагүй байгаа билээ.

Харц ямагт бүхнээс дээгүүр Их гүрний Төрийн нарийн бичгийн дарга Монголд анхлан ирж байсан сэтгэгдлээсээ ийн хуваалцсан билээ.

“Улаанбаатар хот руу анхныхаа аяллыг хийсэн тэртээх 17 жилийн өмнө танай орны байгалийн гоо үзэсгэлэн, хүн ардын зочломтгой найрсаг зан тэр дундаа ардчиллын төлөөх чин хүсэл зоригийг үзээд үнэхээр их гайхан биширч байснаа мартдаггүй юм. Монголын ирээдүйн тухай өөр өөрийн бодол санааг өвөртөлсөн хүчирхэг хоёр хөрштэй Монгол Улсын иргэд тухайн үед хүсэл зоригоороо нэгдэж, нэг намын диктатураас олон намын тогтолцоот ардчилсан засаглал өөд эргэлт хийж чадсаныг хараад сэтгэл минь их хөдөлж байсан. Ардчиллын үнэ цэнийн тухай өдийд, энд ярих нь цагаа олсон хэрэг гэж үзэж байна. Учир нь Азийн олон улс орон засаглалын аль хэлбэрийг сонговол энэ бүс нутгийн хэдэн тэрбум хүний амьдрал зөв тийшээ эргэх вэ гэдэг асуултын хариулт ►



► эрцгээж байна.

Яагаад заавал ардчилал гэж? Яагаад гэвэл ардчилал хүмүүст нэр төртэй амьдарч, үр хүүхэддээ илүү сайхан амьдралыг бүтээх, аливаа маргаан мэтгэлцээнийг тайван замаар шийдвэрлэх боломж сонголт өгдөг учраас. Аль ч утгаараа ардчилал бол сонголт хийх эрх чөлөө юм. Азийн соёлын үнэт зүйлд ардчилал харшилдаг учир тус бүс нутагт тохирохгүй гэж хэлэх хүн цөөнгүй бий.

Гэвч сүүлийн таван жилд Азид гарсан олон том, жижиг улс төр, эдийн засгийн үйл явдал үүнийг үгүйсгэж байна. Тухайлбал, Тайланд, Тайвань, Филиппин, Энэтхэг улсын үлгэр жишээ үйлдлийг нэрлэж болно. Эдийн засгийн өсөлтийг нэн тэргүүнд тавьж ардчиллыг ардаа орхих нь богино хугацаанд амжилт авчирч болох ч урт хугацаандаа тогтворгүйдэл болон хувирдаг. Ардчиллын хөгжлийн явц эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэй шууд холбоотой. Ардчиллыг дэмжинэ гэвэл эмэгтэйчүүдийг хэрхэн оролцуулах талаар давхар ярилцах ёстой болж таарна. Монгол Улсын хувьд Парламент дахь эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн байна. Монгол Улс өнгөрсөн хугацаанд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиа баталж. Сонгуулиа олон улсын стандартын дагуу хийхийг хичээж байгааг харлаа.

Шинээр байгуулагдаж буй Засгийн газар ард түмнийхээ хүсэн хүлээсэн чухал шийдвэрүүдийг гаргаж, улс орноо хөгжлийн шинэ шатанд хүргэх төслүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлнэ гэдэгт итгэж байна. Саяхан археологийн чухал олдвор болох динозаврыг амжилттай эх орондоо эргүүлэн авчирсан шигээ авлига хэмээх аварга “динозаврыг” устгах тэмцлээ амжилттай өрнүүлж байгаа гэж бодож байна. Цаашид ч бид ардчиллыг дэмжиж ажиллана. Учир нь Ази тивд ардчиллыг хөгжүүлэх нь АНУ-ын гадаад бодлогын нэг хэсэг” гэдгийг Хиллари Клинтон

төрийн ордны Их танхимын индрээс хэлсэн билээ.

Эмэгтэйчүүдийн манлайллын олон улсын хуралд төр, хувийн хэвшил дэх эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх, эрчим хүч, эдийн засгийн тогтвортой хөгжил, мөн ядуурлыг бууруулах зорилгоор эмэгтэйчүүдийн бүтээлч бизнес сэтгэлгээг дэмжих стратеги, эмэгтэйчүүдэд байгалийн баялгийг болон сэргээгдэх эрчим хүч ашиглахад илүү өргөн боломж олгох асуудлыг голчлон хөндөж, зөвлөмж гаргахаар болсон юм. “Монгол Улсад зохион байгуулж буй энэ арга хэмжээнд хатагтай Хиллари Клинтон хүрэлцэн ирсэн нь хурлын ач холбогдлыг дэлхийн хэмжээнд хүргэлээ” хэмээн энэ удаагийн УИХ-д сонгогдсон эмэгтэй есөн гишүүний нэг Ц.Оюунгэрэл тэмдэглэсэн юм.

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон Азийн орнуудад хийх ажлын айлчлалынхаа маршрутыг Монголтой холбосон нь Монгол Улсад улс төр, эдийн засгийн олон үйл явдал, арга хэмжээ давхцаж буйтай давхар холбоотой байлаа. Тиймдээ ч тэрбээр УИХ-д шинээр сонгогдсон тэр дундаа эмэгтэй гишүүдэд баяр хүргэж, зургаа хамт татуулсан.

## Амжилтын эхлэл нь уналт

Хиллари Клинтон АНУ-ын энэхүү өндөр хариуцлагатай суудалд дардан замаар явж хүрээгүйг түүний ном гэрчилдэг. Хүнд хэцүү бэрхшээл бүхий олон даваа гүвээг туулан АНУ-ын Тэргүүн хатагтай, мөн Төрийн нарийн бичгийн даргын албан тушаал хүртэл дэвшсэн. Тэрбээр өөрийн амьдралын хамгийн хүнд хэцүү үеийг 30 жил ханилсан нөхөр АНУ-ын Ерөнхийлөгч асан Билл Клинтон Цагаан ордны дадлагажигч оюутан Моника Левинскитай далдуур харилцаатай байсан гэх асуудал үүссэн он ►►

► жилүүдийг гэдэг. Зарим талаар энэ шуугиан Хиллари дэлхийд нэртэй улстөрч болох гараа болж өгсөн гэх нь ч бий. Ямартай ч тэр энэ бүх эцэс төгсгөлгүй зөрчилдөөнийг тойролгүй дайраад өнгөрсөн гэдгээ хүлээн зөвшөөрдөг. Эмэгтэй хүнийхээ хувьд тэвчээрийн дээдийг гаргаж, нөхрөө уучилсныхаа хүчээр энэ хатагтай өнөөдөр дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн улстөрч эмэгтэй болж чаджээ.

Мөн “Хахир хатуу зантай аавынхаа ачаар бэрхшээлийг айж шантралгүй даван туулахыг сурсан” хэмээн тэрбээр “Миний амьдралын түүх” номондоо дурьдсан байдаг. Хэмнэж, гамнах ухааныг эцэг эхээсээ ясандаа тултал мэдэж авсан Хиллари одоо ч дутуу хэрэглэснээ цааш хийж, дундуур үлдээснээ хаялгүй хадгалдаг зуршилтай ажээ. Түүний ээж ч мөн адил хүүхдүүдээ хэнээс ч дутахгүй яваасай гэсэндээ чамгүй чанга хатуу ханддаг хүн байж.

Нэгэн сонирхолтой жишээ дурьдахад Хиллари дөнгөж дөрвөн настай байхдаа эсрэг талын айлын хүүхэд Сюзид шоглуулчихаад нүдэндээ нулимстай орж ирэх нь цөөнгүй байдаг байв. Үүнийг ажсан ээж нь нэг удаа түүнд хандан “Эргээд гар, тэр чамайг цохисон бол хариуг нь өг. Чи өөрийгөө хамгаалж чаддаг байх ёстой. Манайд хулчгар хүн хэрэггүй” гэж хэлжээ. Тэгэхэд Хиллари цээжээ цэхлэн,

зориг өвөртлөн гарсан бөгөөд хэдхэн хормын дараа гүйн орж ирээд “Би одоо хөвгүүдтэй тоглож чадна. Харин Сюзид миний хамгийн сайн найз байх болно” гэсэн гэдэг. Энэ нь түүнийг айдсаа дарахгүй бол хэтдээ муугаар нөлөөлнө хэмээн ээжийнх нь санаа зовсных байсан гэдгийг хожим ойлгожээ. Харин Хиллари Клинтон өнөөдөр сайн ээж гэдгээ батлан харуулж дэлхийн алдартай “Forbes”-ийн дэргэдэх “ForbesWoman” сэтгүүлээс энэ жилийн дэлхийн хамгийн нөлөө бүхий 100 ээжийн жагсаалтыг тэргүүлсэн байна.

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Монгол Улсад айлчлалаар ирсэн нэг хоногтоо Ерөнхий сайд С.Батболдтой уулзаж хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгааг цохон тэмдэглэж гуравдагч хөршийн харилцааг худалдаа, эдийн засгийн салбарт хөгжүүлэх боломж бүрэн байгааг илэрхийлсэн билээ.

Үүний дараагаар тэрбээр Монгол Улсын даргалж байгаа Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн хуралдаанд оролцоод нутгийн зүг жолоо залсан.

Хатагтай Хиллари Клинтон энэ удаагийн Ази тивийн айлчлал Япон, Вьетнам, Лаос, Монгол, Камбодж гэсэн орнуудыг хамарсан юм. ■



## ПАРЛАМЕНТ

## УИХ-ЫН ГИШҮҮДИЙН НЭР ХҮНД УНАСНЫ УЧИР

Парламентаас зоригтой шинэчлэл, өөрчлөлтийг хүсэж байгаа, олон нийт. Өмнөх гишүүдийн алдааг давтахгүй, жинхэнэ төрийн хүний, УИХ-ын гишүүний ёс зүйтэй ажиллана гэж итгэж байна, бид.

## Д.БЭХЭЭ

УИХ-ын гишүүн гэсэн эрхэм хүндтэй энэ нэр өнгөрсөн жилүүдэд тэнэг мангуугаараа дуудуулсан нэр болж хувирсан юм. Их Хурлын 76 мангуу хэмээн сонин хэвлэлээр олонтаа бичүүлсээр ирсэн УИХ-ын гишүүний халдашгүй нэр хүнд яагаад доош уруудах болов? Монгол Улсын хууль тогтоох хамгийн том байгууллагын нэр хүнд яагаад ийн унав аа? Та юу гэж бодож байна вэ?

Ардчилсан зах зээлийн эдийн засагтай болсноос хойш Монгол Улс зургаа дахь удаагийн УИХ-ын сонгуулийг зохион байгуулав. Чанарын хувьд улам л муудаад байгаа талаар иргэд ярьж байна. Учир нь УИХ нь өөрөө хууль тогтоох төрийн дээд байгууллага тул бүрэлдэхүүний хувьд гишүүдийн олонхийг хуульч, эдийн засагчид бүрэлдүүлж гэмээн сайн хууль төрөх ёстой гэж үздэг. Улс орны хөгжлийг тодорхойлох хууль дүрмийг эдийн засаг, хуулийн мэдлэг боловсролтой хүмүүс л зөв ярьж, хэлэлцэж шийдэж чадна гэж үзэж буй хэрэг л дээ. Тиймээс ийм мэргэжилтэй, мөн төрд тодорхой хэмжээнд бэлтгэгдсэн хүмүүсийг УИХ-д суулгавал зохилтой аж.

1992, 1996 оны УИХ-ын бүтцийг аваад үзвэл ажил мэргэжил, боловсрол, чадлын хувьд нэлээд шигшигдсэн, туршлагажсан хүмүүс байжээ. Хууль хэлэлцэж батлахдаа ч улс орны эрх ашгийг эн тэргүүнд тавьж, ярьж чаддаг бүрэлдэхүүн байсан байна. Тухайлбал, 1990 оны УИХ-ын гишүүний 12 хувь нь инженер, 28 хувь нь эдийн засагч, 22 хувийг хуульч эзэлж байжээ. Гэхдээ мэдээж

алдаа онооны асуудлууд байсан байх л даа. Харин сүүлийн жилүүдэд гарч ирсэн Парламентийн гишүүдийн нэр хүнд навс унаж байгааг олон янзаар тайлбарлах нь бий.

**Нэгдүгээрт**, баталж буй хуулиуд нь чанаргүй, амьдралд нийцэхгүй, цоорхойтой байдаг. Тэгээд л тэрхүү цоорхойгоор тоглогчид олон болж, хууль нь гууль болдог жишээ олон бий. Хамгийн гол нь ямар нэг хууль төрүүлэхийнхээ өмнө олон нийтийн болон хувийн хэвшлийнхний дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдний санаа оноог тусгадаггүйтэй холбоотой.

“Томоохон хуулийг өөрсдийн эрх ашигт нийцүүлэн батлахын тулд ямар нэг том баяр ёслолыг тааруулж байгаад, оройны 17.00 цаг орчимд гэнэт хурал зарлаад л баталчихдаг” хэмээн Парламентад хэд дараалан суусан нэгэн гишүүн ярьсан юм.

Нэгэн өглөөний нарнаар нэг хууль мэндэлчихсэн бизнесмэнүүдийг ихэд бухимдуулдаг билээ. Өөрөөр хэлбэл, хуулийн мэдлэг боловсролгүй хүмүүс тухайн хуульд мэддэг юм шиг хандсанаас болж, хөөрхийлөлтэй олон хууль төрдөгт мэргэжлийн салбарынхан ундууцах нь бий. Тухайлбал, өнгөрсөн зургаадугаар сард Ерөнхийлөгчийн Тамгын газраас зохион байгуулсан “Эдийн засгийн өгөөжийн өсөлт ба эрхзүйн шинэтгэл” олон улсын хурал дээр манай их, дээд сургуулиудын хуулийн багш нар “Бид оюутнуудад юу заахаа мэдэхээ байлаа. Бас ичиж байна. Нэг хуулийн талаар ярьж ярьж гартал нөгөө хууль маргааш нь шал өөр болоод гараад

ирнэ” хэмээн ярьж байсан юм.

**Хоёрдугаарт**, бизнесмэнүүд Их хуралд орж ирсэн явдал нөлөөлсөн. Тэд хувийн хэвшлийнхэнд халтай хууль баталдаг, үндэсний бизнесмэнүүдээ дэмжихгүй байна, ер нь л төр болохгүй, бүтэхгүй байна. Тиймээс баялаг бүтээсэн, хийсэн хэлсэн юмтай бид орж, зовлон жаргалыг мэдэх учраас амьдралд ойр хууль батлалцаж, хүнд наалдсан ажил хийнэ гэсээр улстөр өөд зүтгэдэг. Харин тэд улс төрд ороод ирэхээрээ дээрх мэт хэлсэн бүхэн нь талаар болж, эрх ашгийн зөрчилдөөн дунд уусаж, мөнөөх л хэцүү гишүүдийн нэг болж хувирдаг нь нууц биш ээ.

Мэргэжлийн сайн хуулийн төслийг бизнесийн салбараас гарсан гишүүд унагаж, өөрсдийн эрх ашгийн үүднээс ханддаг явдал буйг УИХ-ын гишүүд өөрсдөө хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал, бизнесмэн гишүүдийн хувийн ашиг сонирхол татвар мэтийн хуульд тусгалаа олж батлагддагийг татварын мэргэжилтнүүд хэлсэн юм.

Сүүлийн 3-4 удаагийн УИХ-д бизнес эрхлэгчид олноор сонгогдсон нь фракц үүсгэж, олигархийг төрүүлж, УИХ, ИХ хурлын гишүүн гэсэн нэр хүндийг сэвтүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байгаа гэнэ. Бизнесмэн хүн УИХ-д сууж болохгүй гэж хэлэх гээгүй шүү. Хамгийн гол нь баялаг бүтээж, компанийнхаа төлөө шаргуу дайчин чин сэтгэлээсээ зүтгэдэг шигээ улс орныхоо төлөө тэгж л шударга, идэвхтэй ажиллах хэрэгтэй байна гэдгийг л хэлэх гэсэн юм аа.

**Гуравдугаарт**, баталсан хуулиудынхаа хэрэгжилтэд хяналт ▶



Шог зургийг А.Амарсайхан

▶ тавьдаггүй. Чанартай, чанаргүй хуулиуд бөөндөөд л батлаад үйлдвэрлээд байдаг, тэр нь амьдралд хэрхэн хэрэгжиж буй, алдаа оноо нь юу байгааг ч мэдэхгүй араас нь дахин хууль гаргаад явдаг зураглал харагдана. Уг нь гишүүд хууль "төрүүлэх"-ээс гадна хяналтын үүрэг гүйцэтгэх ёстой. Энэхүү үүргээ мартсан гэж хэлж болох талтай.

Дөрөвдүгээрт, Монголын Парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байгаа явдал. Эмэгтэй хүмүүс УИХ-д суухад хэцүү гэдгийг улстөрчдийн төлөөлөл хэлж байна. Харин энэ удаагийн сонгуулийн дүнгээр 10-аад эмэгтэй Парламентыг чимэх болсон. Гэхдээ хувцас, өмссөн зүүснээрээ гоёх бус мэдлэг чадвар, хатан ухаанаараа чимэх хэрэгтэй юм. Дэлхий улс орнуудын хувьд эмэгтэйчүүдийг төрийн түшээгээр томилоход ихэд анхаарч байна. Бусад орны улстөрийн томилгоог харахад эмэгтэй ерөнхийлөгч, ерөнхий сайд, парламентийн гишүүд, сайдын суудалд сууж буй мэдээллийг та сонссон байх.

**Тавдугаарт,** УИХ-ын гишүүдийн ёс зүйн асуудал орно. Ер нь бол гишүүдийн нэр хүндийн доройтол

тэдний ёс зүйтэй шууд холбоотой. Олон нийтийн дунд биеэ зөв авч явж чадахгүй, мэдэмхийрсэн дүр төрхтэй, хоосон тархитай хүмүүсийн үг амьдралд буухгүй байна. Телевизийн камер харахаараа баахан худлаа ярьж, идэвхтэй царайлж сонгогчдооо харагддаг, хуурамч дүр эсгэсэн хүмүүс болсон, УИХ-ын гишүүд бол. Тэд гаднаа гяланцаг, дотроо паланцаг гэдгийн жишээ юм.

Уг нь УИХ-ын гишүүд бол ард түмний төлөөлөл, тэдний дуу хоолойг төрд хүргэх хүмүүс. Гэтэл тэд "Би та бүхнийг төлөөлж чадна" гэж гарч ирчихээд сонгуулийн маргаашаас дээгүүр харан сэвж, төрийн мөнгөөр зугаалж, сонгуульд зарцуулсан мөнгөө явал хэд дахин нугалж авах талаар бодож, хоорондоо хуйвалдаж эхэлнэ. Албаны машин унаж, тусгай нарийн бичигтэй болж, өндөр хамгаалалтад орж, орчин тойрноо танихаа болино. Эхнэрээ солих нь ч энүүхэнд. УИХ-ын гишүүн болонгуутаа эхнэрээ залуухан туслах, нарийн бичгээрээ сольсон тохиолдол нэлээдгүй бийг иргэд мэднэ.

Ёс зүйн асуудал нь гишүүдийн хамгийн түвэгтэй зүйлүүдийн нэг аж. Гишүүн гэсэн нэр зүүж, Төрийн ордонд

заларсан цагаасаа л асуудал үүсгэдэг гэнэ. Тухайлбал, саяын суудлаа өгсөн гишүүдийн хувьд ажлын өрөөгөө, сандал ширээгээ, өрөөний байрлалаа голох зэрэг эрхэм гишүүдийн хувьд нэр нүүрэнд инээдтэй гэмээр асуудал үүсгэдэг байжээ. Зарим гишүүн бүр өрөөгөө өөрийн дураар өөрчилж, дундуур нь хана хүртэл босгоод, өөрийн компанийн үнэтэй цайтай ширээ сандлаа авчраад суудаг байсан байна. За тэгээд архидах, шоудах, хүүхэн эргүүлэх зэрэг гишүүний ёс зүйд баймгүй асуудлууд гаргадаг байсан тухай Төрийн ордны ажилтнууд сэм шивнэсэн юм.

**Зургадугаарт,** насны ялгаа. Бусад улс оронд ахимаг насны хүмүүс Парламентад суугаа харагддаг. Тэд яаж ч бодсон, мэдлэг, болосвролтой, хал үзэж халуун чулуу долоосон туршлагатай хүмүүс байж таараа. Царайнаас нь илт харагддаг шүү дээ. Тухайлбал, Японы Парламентын гишүүд ихэнхдээ ахимаг насныхан байдаг аж. Тэд Японы телевизээр Парламентын танхимдаа унтаж буй мэт харагддаг нь цаанаа асуудлыг нүдээ анин, эргэцүүж тал талаас нь бодож буй дүр зураг гэнэ. Харин манайхан яадаг билээ, асуудалд ▶

► өнгөцхөн хандаж хууль баталдгийг хүмүүс хэлсээр, ярьсаар, анхааруулсаар одоо залхсан байдалтай болжээ.

Манай УИХ-ын гишүүдийн насны хувьд ихэнхдээ холимог, ахимаг, дунд, залуучуудын төлөөлөл байдаг. Монгол Улс залуусын орон гэдэг утгаар сүүлийн үед Парламентад залуучуудын төлөөлөл түлхүү ордог болсон. Уг нь ажил хийх ид насан дээрээ яваа тэднийг Төрийн ордонд хууль хэлэлцэх нэрийдлээр суулгах бус жинхэнэ амьдралд ойр ажил хөдөлмөр хийлгэж, мэдлэг чадвар олгож, туршлагатай болгох тал дээр анхаарвал илүү чухал юм шиг санагддаг. Үүнтэй олон хүн санал нэгддэг. Гэтэл намууд улс төрийн эрх ашгийн үүднээс сонгогдох магадлалтай залуусыг хүчээр нэр дэвшүүлж, УИХ-д оруулж ирж байна.

“Насаа бодсон ч энэ удаагийн сонгуульд нэр дэвшмээргүй л байх юм” хэмээн ярьж явсан залуу өнөөдөр УИХ-ын гишүүн болсон байна. Нөгөөтэйгүүр 2-3 Парламентын нүүр үзэж, жинхэнэ туршлагажсан,

ямар хуулийг яаж ярих, хэлэлцэх, батлах, юу нь болж, юу нь болддоггүйг сайн мэдэх ахимаг насны төлөөллүүд одоогийн УИХ-д ч сууж буй. Төрийн хууль тогтоох дээд байгууллагын залгамж халаа мэдээж байх ёстой.

Эцэст нь, эрх зүйт төр бус эдийн засаг, мөнгийг дээдэлсэн төр болж хувирлаа. Нийгэмд шударга ёс байхгүй байна. Авлигатай тэмцэх байгууллагууд нь тодорхой нэг хүчинд үйлчилж байна. Эдийн засгийн томоохон бүлэглэл бий болж, тэрхүү бүлэглэл гаднаас хамааралтай байна гэсэн мэссэжүүд нийгэмд явж байна. Иргэдийн ярилцах энэхүү мэссэжүүд шинэ засаг төрд хамаатай. Шинэхэн Парламентаас зоригтой шинэчлэл, өөрчлөлтийг хүсэж байгаа, олон нийт. Өмнөх гишүүдийн алдааг давтахгүй, жинхэнэ төрийн хүний, УИХ-ын гишүүний ёс зүйтэй ажиллана гэж итгэж байна, бид. Мөн нэр хүнд нь унаж яваа УИХ, УИХ-ын гишүүдийн нэг төрийг аврах эсэх нь одоогийн Парламентаас ихээхэн шалтгаалах билээ. ■

УИХ-ЫН ГИШҮҮНИЙ ЁС ЗҮЙ

## ЁСЫГ САХИЖ, ТӨРИЙГ ТӨВШИТГЭЭ

*“Улс төрчдийн 90 хувь нь бусад 10 хувьдаа муу нэр зүүж өгдөг”*

Б.ЭНХЦЭЦЭГ

Улс төр судлаач, Генри Киссингер

Монголын түүхэнд шилийн сайн эр гэх нэрээр түүхэнд мөнхөрсөн ардын баатар олон бий. Тэд мөлжигдөж, дарлагдсан ядуу ардыг төлөөлөн ноёд, баяд болон харийн түрэмгийлэгчидтэй тэмцдэг байсан гэдэг. Хүнийг хүндлэх, ядуу доройчуудыг тэтгэх, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгшдийг асрах, андын журмыг сахих, хэлсэн үгэндээ хүрэх, эдэд үл шунах, хатуужил тэсвэртэй байх нь сайн эрийн ёс ажгуу. Тэд эдгээр ёсыг чандлан сахина хэмээн тангараг хүртэл өргөдөг байжээ. Харин тангаргаа зөрчсөн хүнийг сайн эр гэж үзэхээ больж, хулгайчид тооцон жигшдэг байв.

Улс орон удирдан залах ухааныг шилийн сайн эрсийн энд авч үзэх нь оновчгүй байж мэдэх ч ардчилсан орны Парламентийн тангараг, засаглах эрх, үүрэг, захирагдах ёс горимд дээр үеийн Монголын шилийн сайн эрсийн тангарагтай ижил төстэй

тал нэлээдгүй байна. Дээр үеийн ардын баатруудад хуулиар олгосон эрх, үүрэг байгаагүй ч эх орноо гэсэн сайн дурын чин хүсэл, зориг байсныг тэдний бичилцсэн түүх гэрчилдэг. Тэгвэл энэ цаг үеийн ард түмний сонголтээр эрх нь зөвшөөрөгдөж, хуулиар батлагдсан иргэдийн төлөөлөл болсон УИХ-ын гишүүдийн бүрэн эрхтэй тэнцэх үүрэг, ёс зүй юу вэ? Энгийнээр хэлбэл, УИХ-ын сайн гишүүн байхын тулд ямар ёсыг чандлан сахих ёстой вэ?

“Үйл ажиллагаандаа нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах” нь УИХ-ын гишүүний нэн тэргүүний үүрэг болохыг “Улсын Их Хурлын гишүүний гарын авлага” номд бичсэнээс харж болно. Манай төрийн түшээд дөрвөн жилийнхээ хугацаанд бүрэн эрхээ хэрхэн эдлэхээ харьцангуй сайн мэддэг. Хууль болон бусад шийдвэрийн төсөл санаачлах, байр сууриа

илэрхийлэх, санал, дүгнэлт гаргах, албан тушаалтныг огцруулах аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч, хэнийг ч хүлээлгүй уулзах, тайлбар авах, төрийн давхар албан тушаал хаших гэх мэтээр үргэлжилнэ. Гэвч бүрэн эрх гэдэг нь дархан цаазат амьтан шиг байгальд дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэхтэй адил биш. Хуулиар УИХ-ын гишүүнд олгосон эрх бол ард түмний засаглах эрхийг хангахад зориулсан хариуцлага ажээ. Өөрөөр хэлбэл, гишүүн таны эрхийг ард түмний ардчилсан дээд эрх хязгаарлаж байгааг санагтун.

### Нэр хугарахаар яс хугар

Монгол Улсын Их Хурлын эрхэм зорилго нь “Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх, Монголын ард түмний засаглах эрхийг хангах” ►

гэжээ. Тэгвэл зарим үед гишүүд энэхүү хуулиар хүлээсэн эрхээ хэтрүүлчихдэг дутагдалтай тал нь өөр хоорондоо болоод өрөөлөөр чамгүй сайн шүүмжлүүлдэг. Тухайлбал, албаны ёс зүйгээ баримтлан, биеэ зөв авч явж, олон нийтэд үлгэр жишээ болох ёстой ч наад зах нь УИХ-ын танхимдаа хэлцэхийн оронд хэрэлдэж, ойлголцохын оронд бусад руугаа дайрч, давшилж, доромжлон хурлын дэгийг алдагдуулдаг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд ил тод, нээлттэй харагддаг.

УИХ-ын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль, гишүүний ёс зүйг чанд сахих ёстой бөгөөд тухайлбал, онцгой чуулган зарласан тохиолдолд уриулж, залуулж, олон дахин дуудуулаад байхгүйгээр нэн даруй ирэх, чуулганы хуралдааны дэгийг сахиж, үг хэлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд халдахгүй байх ёстой аж. Нөгөөтэйгүүр сонгуулийн үеэр гуйх нь холгүй саналыг нь хүртчихсэн атлаа эргээд мөнөөх иргэдийнхээ санал, гомдлыг чихнийхээ хажуугаар өнгөрүүлж, усанд хаясан чулуу шиг

алга болох гишүүн олон. Тиймээс ч иргэд эд юу хийсэн юм бэ гэж гомдоллох нэг шалтаг болдог. Харин энэ тухай “УИХ-ын гишүүний гарын авлага”-д зааснаар иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдлыг судалж үзэн шийдвэрлэж, зохих хариу өгөх, эсвэл хариуцсан байгууллагад нь шилжүүлэх нь гишүүний эрх, үүрэг юм байна.

Түүнчлэн УИХ-ын гишүүн байх нь албан үүрэг болохоос ашиг хонжоо олох бизнесийн үйл ажиллагаа биш болохыг хэлээд өгчээ. Тухайлбал, төрийн байгууллагын эд хөрөнгө, мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, өөрийн нэр хүнд, эрх мэдлийг ашиглан үнэт цаас, эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх эсвэл бусдад давуу байдал олгох, бусдад нөлөөлөхийг хориглодог болохыг онцолж байна. Төр, олон нийтийн холбоог бэхжүүлэхэд сөргөөр нөлөөлж, тэдний итгэлийг алддаг бас нэг асуудал нь хөрөнгө орлогоо тогтоосон журмын дагуу үнэн зөв гаргадаггүй гэсэн асуудал. Тэгвэл УИХ-ын гишүүд хөрөнгө орлогоо цаг тухайд нь үнэн зөв мэдүүлэх ёс зүйд сайн

суралцах хэрэгтэй. Түүний хажуугаар хууль, тогтоомжоор зөвшөөрсөн ажил үүрэг хавсран эрхэлсэн бол орлого нь гишүүний жилийн үндсэн цалингийн 40 хувиас дээш хэтрэхгүй байх, мөн ажил үүргээ гүйцэтгэсний төлөө шан харамж, бэлэг сэлт авч болохгүй нь. Учир нь энэ бол УИХ-ын гишүүний ажил үүрэг ажээ.

Эцэст нь, шинэ УИХ-ын гишүүдэд амжилт хүсэхийн ялдамд “УИХ-ын гишүүний гарын авлага” номд салхи оруулж, эрх, үүрэг, ёс зүйтэй дэлгэрэнгүй танилцаж, ухамсарлахыг хүсье.

Эрх үүргээ умартаж, эдийн жаргал хөөсөн төрийн түшээдэд иргэд “Үл хүндэтгэл” хэмээх үнэ хүндгүй шагнал гардуулдгаас хойш УИХ гээч эрхэм дээд атлаа энгүй хариуцлагатай суудалд заларсны учир юу болохыг эрх баригчид цаг ямагт санан ухамсарлаж байваас энэ орон мандан бадрах биз ээ.

*“Хэрэв улстөрч эхнэрийнхээ төлөө юу ч хийхгүй байвал эх орныхоо төлөө юм хийж байна гэсэн үг”*

**Эми Грант** ■

**KHATAN TUUL**  
*Pure Water*

Packaging quantity of Pure water:

0.35 L /bottled/	<b>Маркетинг: 99071655</b>
0.6 L /bottled/	<b>Захиалга авах утас: 70173386</b>
1 L /bottled/	<b>Факс: 976-11-70174494</b>
19 L /ballon/	

Produced and bottled by “Welmon Trade” Co., Ltd of Mongolia

## “MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

**-УИХ-ын гишүүн гэж хэн бэ?****-Сүүлийн үед УИХ-ын гишүүдийн нэр хүнд унах болсон нь юутай холбоотой вэ?****С.Ганбаатар** /УИХ-ын гишүүн/

-УИХ-ын гишүүн гэдэг бол төрийн түшээ. Төрийн түшээ нь өөрөө төр гэсэн үг биш. Өөрөөр хэлбэл, төрийг түшиж тулж, үйлчилдэг л хүн шүү дээ. Төр нь ард түмний эрх ашиг, ард олон. Жирийн хөдөлмөрч иргэдийг л төр гэж нэрлэж байгаа юм. Энэ хүмүүсийн эрх ашиг нь төр. Төрийн түшээ нь тэдний эрх ашгийн илэрхийлэл. Бид төлөөллийн ардчилалтай орон шүү дээ. Тиймээс УИХ-ын гишүүн өөрөө бүхнийг мэдэгч, өөрөө бүгдийг дангаараа шийдэгч мэтээр бодож андуурч байгаа нь төрийн түшээгийн нэр хүндийг асар их гутааж, унагаж байгаа.

Нэг ч товчлуур дээр дур мэдэн дарах эрхгүй хүн бол бид. Харин ард иргэддээ юу амлаж гарч ирсэн түүнийхээ дагуу л кнопоо дарна. Тэр бүгдэд дарах болгондоо ард түмнийхээ санаа бодлыг сонсох, судалгаа авах ёстой. Ард түмнээ зөв мэдээллээр хангаж, зөв шийдвэр гаргах боломжийг олгох хэрэгтэй. Үндсэндээ төрийн түшээ түмэн олонтойгоо харилцах харилцааны соёл, харилцаандаа онцгой анхаарахгүй бол энэ янзаараа байвал нэр хүнд нь улам л унана.

Төрийн түшээ түмний өмнөөс хариуцлага үүрч байгаа хүн. УИХ-ын гишүүдийн хамгийн том алддаг ёс зүйн алдаа бол хий хоосон шаардлагагүй хүндлэлд хэтэрхий хошуурч байна. Үүнийг зогсоох хэрэгтэй. Утга учиргүй хүндлэлээс татгалзаж сурах нь нэр хүндийг өсгөх эхний алхам. Өөрсдийгөө ийм утгагүй орчинд оруулснаараа тэд дараа нь энэ өндөр сэнтийгүйгээр амьдрах аргагүй болж байна. Үүнийг л өдөр бүр бодож явах ёстой. Би жирийн хүмүүсийн төлөөлөл гэдгээ л бодох хэрэгтэй. Энэ өөрөө том ёс зүй. Төрийн ажил бол чин сэтгэлийн ёс суртахууны ажил.

**Д.Хаянхярваа** /УИХ-ын гишүүн, Сангийн сайд/

-УИХ-ын гишүүн гэсэн тодорхойлолтыг хэлэхэд хэцүү. Яагаад гэвэл УИХ-ын гишүүнийг ард түмэн сонгодог. Тухайн хүнийг ард түмэн Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага, төрийн бодлого тодорхойлоход оролцож чадна гэсэн итгэл үнэмшлийнхээ дүнд сонгодог. Тиймээс олон нийтийн үнэлэмжээр төрд гарч байгаа хүн бол УИХ-ын гишүүн. УИХ-ын гишүүнд нэгэнт ард түмэн итгэл үзүүлээд сонгосон тохиолдолд ямар ёс зүйтэй байх нь арай өөр асуудал. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүн төр, улс орныхоо төлөө чин сэтгэлтэй, ямар асуудалд улс орныхоо язгуур эрх ашгийн үүднээс хандаж чаддаг, аливаад туйлшралгүйгээр хамгийн зөв, боломжтой гэсэн хувилбар дээр баттай зогсож чаддаг байх ёстой.

Сүүлийн үед УИХ-ын гишүүний нэр хүнд унах болсныг дөрвөн жил УИХ-ын гишүүнээр ажилласан хүний хувьд дүгнэж хэлье. **Нэгдүгээрт**, гишүүд өөрсдөө Парламент дотроо гаргаж байна. Нэг маргаан мэтгэлцээн болохоор бие биенээ элдэв янзаар хэлэх, уудаг, иддэг гэж олон нийтэд нотолгоотой, нотолгоогүй зарладаг. Энэ нь олон нийтийн дунд УИХ-ын гишүүдээс гадна төрийн нэр хүнд унахад нөлөөлж байна. Тиймээс УИХ-ын гишүүд ёс суртахуундаа анхаарах учиртай. **Хоёрдугаарт**, улсын төсөвт гишүүний тодотголтой мөнгө суусан гэж яриад байдаг. Үнэн хэрэгтээ гишүүний мөнгө гэж өгдөггүй. Тойрогт нь тулгамдсан асуудал юу байна, түүнийг шийдэхэд нь суулгаж буй хөрөнгө оруулалт. Гэтэл зарим гишүүн үүнийг өөрийнх нь мөнгө шигээ ойлгож, олон нийтэд миний мөнгө гэсэн сэтгэгдэл төрүүлсэн байна. УИХ-ын гишүүн хүн хөрөнгө захиран зарцуулах эрхгүй шүү дээ. Хэрхэвч аж ахуйн чиглэлийн ажилд оролцох ёсгүй. Өөрөөр хэлбэл, аймаг орон нутагтайгаа холбоотой асуудал дээр хөрөнгө оруулалт шаардлагатай ямар зүйл байгааг мэдэж байж УИХ-д тайлагнаж, шаардлагатай хөрөнгийг улсын төсөвт суулгах ёстой. Гишүүд төсөвт суулгасан хөрөнгө оруулалтдаа хяналт л тавих үүрэгтэй. **Гуравдугаарт**, Монголд бүхэлдээ төр болоод төрийн албаны нэр хүнд унаж байгаа нь үнэн. Тиймээс төр нь төр шиг, ард иргэд нь ард иргэд шиг байдаг ийм л зарчимтай байх хэрэгтэй. ►



### С.Эрдэнэ /УИХ-ын гишүүн/

- УИХ-ын гишүүн нь бүх ард түмний элч, төлөөлөгч мөн гэж Үндсэн хуульд заасан байдаг. Төрийн эрх барих дээд байгууллага УИХ-д хууль тогтоогч, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих хүнийг УИХ-ын гишүүн гэж хэлнэ. Ард түмний элч, төлөөлөгч гэдэг үүднээс төрийн эрх барих ард түмний эрхийг дамжуулан гүйцэтгэж байгаа, төр ард түмний хооронд гүүр болж байгаа төлөөлөгчийг УИХ-ын гишүүн гэж үздэг. УИХ-ын гишүүдийн нэр хүнд сэвтэх болсон шалтгааныг хоёр үндсэн зүйлээс харж байна. **Нэгдүгээрт**, УИХ-ын гишүүнээр сонгогдсон хүмүүсийн өөрсдийн хувь хүний ёс суртахуун, хүмүүжил, боловсролтой холбоотой. Хувь хүний гаргаж буй алдаанаас болоод УИХ-ын нийт гишүүдийн нэр сэвтэх, төрийн нэр хүнд унаж болохгүй. УИХ-ын гишүүн бол асар том хариуцлага.

**Хоёрдугаарт**, зохиомлоор УИХ-ын гишүүний нэр хүндийг унагаах гэсэн оролдлого болоод сонирхол байна. Болохгүй л бол баруун хойт талын хар овоохой гэдэг шиг бүх зүйлийг УИХ руу чихэж, харлуулах нь шударга биш. Нэгэнт л УИХ өнөөдрийн хэлж ярьж байгаа шиг тийм муу муухай газар юм бол хүмүүс яагаад УИХ-ын гишүүн болох гэж улайрдаг юм. Өнгөрсөн сонгуульд л гэхэд 700 гаруй хүн нэр дэвшиж, өрсөлдлөө шүү дээ. УИХ-ыг ард түмэн байгуулдаг. Тиймээс хэн дуртай нь бүдгэрүүлж, харлуулаад байдаг газар биш л дээ.

Төрийн ачааг үүрэх ноён нуруутай, ажлын ачаалал даах чадвар, боловсролтой, бэлтгэгдсэн олон түмний итгэл даасан хүн УИХ-ын гишүүн болдог гэж ойлгодог. Түүнээс төрийн ачааг үүрэлцэх хэмжээнд хүрч чадаагүй хүнд нэгдүгээрт, УИХ-ын гишүүн байх чадвар дутна, хоёрдугаарт, олон түмэн сонгохгүй байлгүй дээ. Төрд төрийн түшээ болж, хууль тогтоогчийн эрх эдэлж, ажиллах нь маш өндөр үүрэг хариуцлага. Тиймээс энэ үүрэг хариуцлагаа ухамсарлаж чадсан хүн л төрийн түшээ болдог. Зүгээр нэг харваад өнгөрдөг од шиг нэг удаа сонгогдоод боллоо гэж боддог хүмүүс байх шиг байна. Монголын ард түмэн, тэр дундаа өөрийг нь сонгосон сонгогч олондоо үнэлэгдэж чаддаг, тэднийхээ итгэл найдварыг дааж чаддаг ийм л төрийн түшээ байгаасай гэж хүсэж байна.



### С.Оюун /УИХ-ын гишүүн/

-УИХ, Парламент тов тодорхой гурван үүрэгтэй. Аль ч орны Парламент ийм л гурван үүрэгтэй байдаг. **Нэгдүгээрт**, хууль тогтоох, **хоёрдугаарт**, хяналтын буюу гүйцэтгэх засаглал болох Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, **гуравдугаарт**, иргэдээ төлөөлөх, тэдний эрх ашгийг хамгаалах.

УИХ-ын гишүүний тулгын гурван чулуу шиг гол гурван үүрэг нь энэ. Тиймээс нэгдүгээрт, төрийн гол бодлого хуулиар, УИХ-ын тогтоолоор дамжиж гардаг. Хоёрдугаарт, Засгийн газар, яам, агентлагууд ажлаа сайн хийж байна уу, төсвөө зөв зарцуулж байна уу. Төсвийг Их хурал баталж байгаа учраас төсвийн зарцуулалтад хяналт тавих эрхтэй, үүрэгтэй. Гуравдугаарт, ямар ч иргэн хүний эрх ашгийг хамгаалах ёстой. Тойргийн иргэд олон асуудал тавьдаг. Тэр бүх асуудлыг хуулийн хүрээнд холбогдох газруудад шилжүүлнэ. Боломжтой бол шийдвэрлэх үүрэгтэй.

Ний нуугүй хэлэхэд улстөрчдийн нэр хүнд унаж, төрд улс төрийн намуудад итгэх итгэл саарч байгаа нь Монгол Улсын хувьд сайн зүйл биш. Хамгийн түрүүнд хариуцлагагүй байдалтай л холбоотой. Улстөрчид тэр болгон хариуцлага хүлээхгүй, ямар зорилгоор улс төрд, УИХ-д орсон гэдгээ тодорхой ойлгохгүй байх шиг байна. Улс төрийн намууд зоригтой шинэчлэл хийж чадахгүй байна. Харин намууд ирэх дөрвөн жилд өөрчлөлт, шинэчлэлтээ зөв хийгээд яваасай гэж бодож байна.

Өнгөрсөн хугацаанд хууль эрх зүйн хувьд нэлээд дэвшилт гарсан. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийг өнгөрсөн тавдугаар сард баталлаа. Төрийн мэдээллийг нээлттэй болгох тухай хууль өнгөрсөн жил баталсан. Төрийн нууц л биш бол ямар ч мэдээлэл иргэнд нээлттэй байна гэсэн үг. Одоо эдгээр хуулийн зүйл, заалтыг хэрэгжүүлэн сахих чимхлүүр ажлыг хийх шаардлагатай байна. Нэг үеэ бодвол хууль чанга болж байгаа. Ер нь л ёс зүйтэй шударга ажиллахгүй бол хууль нэлээд хатуу чанга болж байна. Хамгийн гол нь үүнийг зөв тийш нь залж хандуулах л хэрэгтэй байна.



### А.Тлейхан /УИХ-ын гишүүн/

-УИХ-ын гишүүн гэдэг нийт ард түмнийхээ эрх ашгийг хамгаалж ажилладаг, төрийн түшээ. Энэ удаагийн УИХ-д 50 хувь нь шинэ гишүүн, 50 хувь нь хуучин гишүүн байна. Энэ нь төрийн залгамж чанар хадгалагдаж буй нь сайн хэрэг. Шинэ гишүүд төр түмнийхээ төлөө шударга, хариуцлагатай, зарчимтай ажиллах ёстой. Улс орныхоо язгуур эрх ашгийг умартаж болохгүй. Монгол Улсын хөгжлийн төлөө зүтгэх учиртай. ▶▶



▶ **Ч.Улаан /УИХ-ын гишүүн/**

-УИХ-ын гишүүн ард түмний элч, ард түмнээ төртэй холбож байх гүүр нь. Тиймээс нийт ард түмнийхээ эрх ашгийг УИХ-ын гишүүн дээдэлж ажиллана гэсэн үг. Иймээс УИХ-д хуулиа дээдлэн ажиллана гэж тангараг өргөдөг. Бүх зүйл хуулийн хүрээнд хуулиа дээдэлж ажиллавал ямар нэг таагүй асуудал үүсэхгүй. Хаана хууль зөрчигдөж байна, хаана ашиг сонирхлын зөрчил байна, тэнд хууль зөрчсөн, тангаргаасаа няцсан үйлдэл гардаг. Тиймээс УИХ-ын гишүүн хуульд үг дуугүй захирагдаж, ард түмний эрх ашигт үйлчилж ажиллах ийм л хүн.



▶ **Ц.Оюунгэрэл /УИХ-ын гишүүн/**

-УИХ-ын гишүүн олон хүний хүсэл зорилгын төлөөлөл. Нэг ёсондоо хүмүүсийн хүсэл зоригт үйлчлэх гүйцэтгэгч нь гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, олон хүний өмнөөс ажлыг нь хийж өгөх үүрэгтэй томилогдсон ажилчин нь. Зарим байгууллага чинь нэг даргатай байдаг бол УИХ-ын гишүүн бол олон даргатай, нэг ажилчинтай гэсэн үг.



▶ **С.Одонтуяа /УИХ-ын гишүүн/**

-УИХ-ын гишүүн гэж ард түмэн, төрийнхөө төлөө чин сэтгэлээсээ зүтгэхийг хэлж байгаа юм. Манай улс төрд сэтгэл дутаж байна. Тиймээс манай эмэгтэй гишүүд энэ орон зайг дүүргэж ажиллах ёстой. Мэдлэг, мөнгө, туршлага улс төрд дутаагүй, сэтгэл дутаж байгаа. Иймээс эмэгтэй гишүүний хувьд үгүйлэгдэж буй орон зайг дүүргэхийн төлөө ажиллана.

А.АМАРСАЙХАНЫ БУЛАН

## ЭРХЭМ ГИШҮҮНИЙГ ШИНЖИХҮЙ /фельетон/

Тэнэг толгойтой гишүүн маш ховор. Хөөрхийг бусад нь хочилж нүд үзүүрлэдэг учраас “тэнэг толгой” гэх нэр үүссэн гэлцдэг. Ийм шинжийн гишүүд тэнэг учраас өөрийгөө мартаж, дан ганц таны төлөө чин сэтгэлээсээ зүтгэдэг. Тэгэхээр ийм толгойтонтой учирвал тэнгэрийн умдаг атгалаа л гэсэн үг.




Зохиолч, шог зураач

Монголчууд эрт дээр үеэс хурдан морь, эрхэм гишүүн хоёрыг биеийн хэлбэр, галбираар нь шинжиж, таньж ирсэн сайхан уламжлалтай. Хурдан морийг толгой, шүд, туурай, сүүл, сагаг зэрэг 11 шинжээр таньдаг бол төрийн түшээдийг гүзээ, толгой, шүд, туурай, идэш, ууш гэсэн гадаад зургаан шинжээр нь таньж болдог ажээ.

Хурдан моринд гүзээ байдаггүй тул ийм зүйлээр шинждэггүй. Эртний сударт гүзээний хэлбэр галбир бол гишүүнийг ялгах хамгийн чухал шалгуур гэж өгүүлжээ. Босс болон мисс гэх хоёр төрлийн гүзээ бий. Босс гүзээ цүндгэр байдаг бол мисс гүзээ Мэнэнгийн тал мэт хавтгай байна. Босс гүзээтэй гишүүн хэвтрээсээ босож ч үл чадах тул таны төлөө хөнгөн шаламгай гүйж чадахгүй,

лазагнасаар дөрвөн жилийг бардаг. Мисс гүзээтэй гишүүн тоос татуулан сунаих хулан тахь мэт хурдан байдаг тул үг дуугүй сонговол зохино. Даанч тэд нэн ховор.

Хурдан морийг толгойгоор нь хонь, туулай, хүдэр, бар, мэлхий, хандгай гэж зургаа ангилж үздэг. Харин эрхэм гишүүдийн хувьд өмбүү толгой, өмбүү толгой, усан толгой, ухна толгой, тэнэг толгой гэх таван янзын толгойн шинжийг эртний мэргэд онцолж авч үздэг. Өмбүү толгойг сэгсэрч үзэхүл зоос цуглуулдаг вааран гахай мэт хангир жингэр дуугардаг бол өмбүү толгойд юу ч хэлээд нэмэргүй. С.Төмөр-Очир даргын үед өмбүү толгойтой гишүүд дийлэнх байсан. Харин Д.Дэмбэрэл даргын үед ухна толгойн хэв шинж Их хурал руу түрэн орж ирсэн ▶



► түүхтэй. Усан толгойтой гишүүн чуулган үймүүлж, элий балай бурдгаараа ялгардаг. Харин тэнэг толгойтой гишүүн маш ховор. Хөөрхийг бусад нь хочилж нүд үзүүрлэдэг учраас “тэнэг толгой” гэх нэр үүссэн гэлцдэг. Ийм шинжийн гишүүд тэнэг учраас өөрийгөө мартаж, дан ганц таны төлөө чин сэтгэлээсээ зүтгэдэг. Тэгэхээр ийм толгойтонтой учирвал тэнгэрийн умдаг атгалаа л гэсэн үг. Тэнэг толгойг нясалж үзэхэд болсон тарвас мэт пүдхийж дуугардгаараа ялгардаг.

Гишүүдийн шүдийг хол, хонин, сийрэг, шигүү шүд гэж ангилдаг. Эрхэм гишүүний шүд ойгүй хол зайтай байх тусам түүний завсраар том амлалт сийгэх нигуур буй. Эх орны хишиг, эрдэнийн хувь гэхчлэн хэдэн саяар сийгээд байх нь гишүүний шүд ямаршуу болохыг илтгэж буй хэрэг. Огт юу ч амлахгүй байгаа бол тэр шигүү шүдтэй гишүүн. Шигүү шүдтэнг сонгосноороо та хулхидуулахгүй. Юу ч амлаагүй юм чинь юундаа хулхидуулах вэ? Үнэнч, хурдан гишүүний соёо нь бууран тэмээнийх мэт агаад, зайгүй шигүү байдгийг анхаарч шинжих хэрэгтэй.

Хурдан түшээд идэш бага, морь харах нь бяцхан хол хэмээн сурвалж бичигт дурдсан байдаг. Тэгэхээр нэр дэвшигч тойрогт ирэхдээ сумын даргаар хорхог хийлгэж идэж буй эсэхийг сайтар ажиглаж шинжээрэй. Сумын ядруухан төсвөөс төлөг цохуулж, зажлахдаа сийхгүй байгаа этгээд улсын хөлгүй сангаас тэрбумыг гувчуулж, гудрахыг юман чинээнд бодохгүй гэсэн үг. Хорхог огт амсахгүй, морь огт харахгүй байх ахул гайхам хурдтайн шинж болно.

Хурдан түшээ архийг тагшаар ганц мөсөн хөтөрдөггүй. Эхэлж жаахан балгаад, тамшаалж амтлаад дахиж ууж амраад, мөн дахин бага зэрэг уух болой. Сөгнөсөн архийг огт уухгүй байвал их зантайн шинж. Гулгуулж орхивол архаг болохын шинж. Балгаад ярвайвал голлоо гэсэн үг. Ярвайхгүй бол донтох хандлагатай байж магадгүй.

Нэр дэвшигч уулзалт дээр үг хэлж зогсохуйд туурайн шинжийг сонждог. Туурайгаа үе үе цавчаад, байн байн солбиж тавиад байгаа бол гишүүн хурд муутай, худлаа хэлдгийн шинж. Ийм гишүүнийг сонговол хулхидуулна гэсэн үг.

Энэ бүхнээс үзвэл эрхэм түшээд хөнгөн шаламгай хурдтай чанараа бие галбиртаа агуулдаг байх юм. Хөлдөө салхитай, хүзүүндээ мөлжүүртэй, мисс гүзээтэй, луус духтай хурдан удмын гишүүнийг сонгоод хүсэл мөрөөдөл бүхнээ сэтгэлчлэн бүтээж, хүмүүнлэг ардчилсан нийгэмдээ тааваараа жаргах эсэх сонгогч танаас л шалтгаална. Шинжихүй тань ончтой, сонгохуй тань мэргэн байх болтугай.

*Зохиогч энэхүү фельетоноо сонгуулийн өмнө бичсэн юм. Гэхдээ та УИХ-д гарч ирсэн гишүүдийг дээрх шинжүүдээр нэг шинжиж үзээрэй.*

*Ард түмэн ямар сонголт хийсэн байна вэ? ■*

ТИТЭМ ҮГ

## НЭР АЛДРААС ИЛҮҮ ХҮН ЧАНАРЫН ТУХАЙ БОД

Сонгуульт алба хугацаатай. Эзний алба ээлжтэй гэдэг шиг өндөр нэр алдар мөн л хугацаатай, харин хүн чанар хугацаагүй. Хугацаа өндөрлөх хүртэл хүнээрээ үлдэх шаардлагатай. Өөрсдийнх нь төлөө хэн илүү санаа тавьж, сэтгэл гарган зүтгэж байна, тэднийг ард түмэн дэмжсээр байх болно.



Н.БАГАБАНДИ /Монгол Улсын Ерөнхийлөгч асан/

“Ард түмний сайн сайхан байдал хамгийн дээд хууль мөн” хэмээн маш эрт үед нэгэн ухаантан айлджээ. Хүн болгон өөрийн амьдралын эзэн байдаг ч ард түмний сайн сайхан байдал жинхэнэ ёсоор хангагдаж, хамгийн дээд хууль хэрэгжих, эсэх нь төрийн толгойд заларч байгаа эрхмүүдээс маш их хамааралтай. Амьдрал мэддэг, авьяас билигтэй, оюунлиг бөгөөд хүнлэг эрхмүүд төрийн толгойд байвал хүн ардын амьдралыг хөнгөвчилж өгөх нь тодорхой. Хүн бодлогынх нь төвд байдаг төр хүмүүнлэг төр.

Олон түмнийхээ дэмжлэгийг хүлээсэн, хүчирхэг хүмүүсээр удирдуулж байгаа төр хүчтэй. Ард олон төрийнхөө жолоон дээр билиг төгөлдөр, хүчирхэг хүмүүс сууж байхыг харан, тэдэндээ итгэн, тэднээрээ бахархахыг хүсдэг юм. Улсын Их Хурлын гишүүд ард түмний элч нар. Нийт иргэд, бүрэн эрхт улсынхаа ашиг сонирхлыг бүхнээс дээгүүр тавьж, эрхэмлэх үүрэгтэй тэд. Нийтийн эрх ашиг, нийгмийн ашиг сонирхлыг тугандаа мандуулж байна уу, уландаа гишгэж явна уу гэдэг нь тов тодорхой ив илхэн харагдах тийм цаг үед та бид амьдарч байна. Хувийн явцуу бодол, хэсэг бүлгийн давчуу сонирхолд автан, гадна дотнын бэл бэнчинтэй хүмүүсийн гутлын уланд наалдсан шавар шавхай мэт болж доош орон, төрийн түшээгийн өндөр нэр төрийг гутаан сэвтээх вий дээ гэж сонгогчид нь сэтгэл зовнин, сэрэмжлэн болгоомжлон ажиглана.

Ард түмний зүрхэн тольтод ил биш, далд мэдрэмж хэмээх агуу зүйл бий. Ард түмэн харахгүй, сонсохгүй байсан ч хэн нь хэн бэ гэдгийг маш сайн мэдэрч байдаг. Мэдээлэл хомс, хууль тогтоомжийн нарийн ширийнийг бүрэн мэдэхгүй ч тэд сайн муу, зөв бурууг мэдрэмжээрээ ялгаж салган, үнэлж дүгнэх төрмөл ухаантай, төрөлх чадвартай. Тиймээс сонгогч олондоо зөвөөр мэдрэгдэх, эерэг үнэлэгдэх сайн

үйлсийн төлөө, том эрх ашгийн төлөө чармайн зүтгэх нь төрийн түшээдийн эрхэм үүрэг. Дэлхий ертөнцөд даяарших үйл явц түргэсч байна. Эмээлээсээ өндөр даваа даваагүй, эхнэрээсээ өөр танилгүй гэх үг түүх болон үлдэж, үнэхээр хол хоцорчээ.

Төрийн бодлого тодорхойлж, хууль тогтоож байгаа УИХ-ын гишүүд дэлхийг харах нүдтэй, дэлхийн энтэй сэтгэх сэтгэлгээтэй, дэлхийн хэмжээний боловсролтой байх том шалгуур цаг үеийн шаардлага болон тавигдаж байна. Их хурлын гишүүд улс орны амьдралын бүх салбарыг хамарсан хууль баталж, дэлхийн улс орнуудтай харилцах бодлого тодорхойлох үүрэгтэй учир тэр бүхнээ төгс мэдэх, нарийн судлах шаардлагатай. Хэдийчинээ ихийг мэднэ, төдийчинээ ихийг чадах болохоор гишүүдэд тавигдах тэргүүн зэргийн шаардлага нь өндөр боловсрол, өргөн мэдлэг. Их хурал өөрөө амьдралын их сургууль, мэдлэг сэлбэх оюуны сан хөмрөг. “Хүрээнд суусан чавганцын чих гийнэ” гэдэг шиг өөрөө төдийлэн мэрийхгүй байлаа ч Их хуралд суугаа хүний чих онгойж, ухаан тэлж байдаг юм. Их хуралд сонгогдмогц өндөр боловсрол, өргөн мэдлэг өөрөө дагаад ирэхгүй нь тодорхой. Их хурлын гишүүд биеэ боловсруулах ажилдаа өдөр тутам, цаг үргэлж санаа тавьж байх ёстой. Мэдэх юмаар маруухан, тэгээд мэдэхийг оролддоггүй хүн хоёр давхар сул талтай гэдгээ үг дуугүй хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Аль нэг гишүүний мэдлэг боловсролын хэмжээ түвшин ямар вэ гэдгийг таньж мэдэх түвэгтэй биш.

“Тавхан үгэнд танигдана” гэдэг шиг хэлж байгаа үг ярианаас нь ив ил, тов тодорхой. Их хурлын гишүүд нийгмээ мэдлэг боловсролоороо үлгэрлэн хөтөлсөн, нийгмийн оюун ухааны цөм байх ёстой. Их хурлын гишүүдээс орчин ▶

► цагийн мэдлэг боловсролын сор болсон гэрэл гэгээ цацран гийж, түмэн олноо гэрэлтүүлж байгаасай гэж сонгогч түмэн нь харж хүлээж байдаг билээ. Төр төмбөгөр, ёс ёмбогор. Төрийн албанд зүтгэж байгаа хэн боловч төмбөгөр төрийн ёмбогор ёсыг сахин дагах нь зүй ёсны хэрэг. Төрийн хүний ноён нуруу цэх шулуун, бат тогтвортой, даамай даацтай байх учиртай. Төрийн хуулийг хэлбэрэлтгүй сахин хэрэгжүүлж, тогтсон зарчмыг тууштай баримтлан, төр түмний төлөө хоёргүй сэтгэлээр чин шударгаар зүтгэж байгаа түшээдэд түмэн олон итгэлээ өгч, дэмжсээр байх болно.

Шулуун шударга, хэлснээ хэрэгжүүлдэг, за гэвэл ёгүй, бүтээлч сэтгэлгээтэй, шинийг тусган авах торгон мэдрэмжтэй, эрсдэл хийн шийдвэр гаргах эр зоригтой, эргэж хургах, урваж шарвах муу зангүй, төлөв төвшин төрийн хүний шилдэг шинжүүдийг өвч шингээсэн хүмүүс төрийн эрхэнд заларч байгаасай гэж ард олон хүсэж байна. Төр эрхэмсэг. Төрийн эрхэмсэг шинжийг уламжлан тээгчид нь яах аргагүй Их хурлын гишүүд. Төрийн эрхэмсэг шинж Их хурлын гишүүдийн дотроос нь гэрэлтэж, гаднаас нь тодорч, төрийн хүн ийм л шинж төрхтэй, эрхэмсэг чанартай гэдгийг үлгэрлэж байх учиртай. Төрийн түшээдийн үг хэл, үйлдэл хөдлөл бүхнээс нь төрийн эрхэмсэг шинж ил тод мэдрэгдэж байхаар биеэ авч явбал зохино.

Төрийнхэрэгтсуралцахтайхамттөрийнэрхэмсэгшинжид суралцах хэрэгтэй. Төрийн эрхэмсэг шинж төрөө дээдлэх түмэн олны хүндлэлийг бадрааж байхуйцаар тод томруун харагдаж, ив илт мэдрэгдэж байх учиртай. Парламентын гишүүд мэтгэлцэх урлагийн мастерууд, илтгэх чадварын сорууд байх өндөр шаардлагыг өөртөө тавьж ажиллах хэрэгтэй. “Хамаатан садан чинь хаяж, нөхөд чинь урваж, албаны шатнаас унасан ч гэсэн илтгэх чадварыг эзэмшсэн л бол та хэнд ч давагдашгүй хэвээр үлдэнэ” гэх Уинстон Черчилийн хэлсэн үг парламентын гишүүдийн байнга санаж явах үгсийн нэг зайлшгүй мөн. Аливаа асуудалд хүлээцтэй, ухаантай ханд. Ухаантай байхыг хүсвэл бусдаас ухаалгаар асууж, бусдыг анхааралтай сонсож, тайван хариулж, цааш нь юу ч хэлэхээргүй бол ярихаа больж чаддаг арга барилд суралцах шаардлагатай. Амаа хамхихгүй чалчаа хүмүүстэй үгээр уралдан сөргөлдөх, хэрүүл өдөх, хэрүүлд оролцох хэрэггүй.

Хэрүүлд хоёроос доошгүй хүн хэрэгтэй. Хэзээ ч тэдний нэг болохгүй байхыг бод. Юм юманд хошуу дүрж, ийш тийш үсчсэн хэрүүлчид дуртай хүн үгүй. Маргаж, мэтгэлзэж байхдаа уур хилэнгээ барьж сур. Уурласан үедээ унагасан ухаангүй үг үзэн ядалт, гай зовлонгийн галыг өөр дээрээ дуудах осолтой. Үг яриаг хэн ч хэлж чадах бол ухаан цөөхөн хүнд заяадаг. Ухаан муутай үг хэлчихсэн бол эргэж бодон, бусдаас ичдэг шигээ өөрөө өөрөөсөө ичдэг бай. Өөрөөсөө ичсэн хүн ухаангүй үг барагтай л бол дахин хэлэхгүй. “Зогсолтгүй чалчиж айлгаснаас ухаалаг ганц хоёр үг хэлэх нь дээр”. Бусдыг тэвчээртэй сонс. Ялангуяа үнэнийг. Үнэн цөс мэт гашуун байлаа ч сонсох хэрэгтэй. Мэдэж байгаа бүхнээ ярих гэж битгий яар, харин ярьж байгаа зүйлээ төгс мэдэж бай.

Ухаанд оржирсэн болгоноо яаран тэвдэн урсган гаргах азна. Ухаанд чинь орж ирсэн зүйлийн талаар хоёр дахин, бүр гурав дахин бодож байж амнаасаа унага. Шийдвэр

гаргахдаа долоо хэмжиж, нэг огтлох алтан зарчмаар оролц. УИХ-ын танхимаас “Чихнү чимэгтэй аялгуут сайхан монгол хэл” сонсогдож байх ёстой.

Хэлж байгаа үг, илэрхийлж байгаа санаа бүхнээ эх хэлнийхээ аялгуут сайхнаар тодотгож, явцуухан ядруухан хэдхэн үгэнд эргэлдэх биш яруу тансаг, баялаг шигшмэл үгээр ярьж байх нь төрийн түшээдийн эрхэм үүрэг. УИХ улс төрийн соёлын хүндэт индэр байх ёстой. Их хурлын гишүүдээс боловсролтой хүмүүсийн соёлтой үг цоглог эрэмгий цуурайтаж байхыг түмэн олон хүсэмжилдэг юм. Хэлэх хэлэхгүй үгээр бие биенээ зүхэн доромжилж, хуруу гарын бүдүүлэг дохио зангаагаар өрсөлдөгчдөө чичлэн, төрийн хүний эрхэмсэг чанарыг шавар шавхайд хутгах ой гутам, олхиогүй үйлдэл гаргахыг түмэн олон хүлцэн тэвчихгүй. УИХ-ын гишүүд ард түмнийхээ уламжлал заншил, ёс суртахуун, үнэт соёлын хөтөч, үлгэрлэн дагуулагч байх ёстой. Ёс суртахууны дээд хөгжил болон ёс суртахууны дээд нөлөөллөөрөө танигддаг шилдэг хүмүүс байхыг төрийн түшээдээс шаардана.

Ёс суртахуун нь зөвхөн ил харагдах гадаад ёс зүй төдийгүй, санаа бодлын дотоод мөн чанарын илэрхийлэл. Их хурлын гишүүд цэвэр ариун ёс суртахуунтай байж өөрсдийн биеэр нийгмээ үлгэрлэн дагуулах үүрэгтэй. “Хүн оюуны болон ёс суртахууны хөгжлөөрөө хэдийчинээ өндөр байна төдийчинээ эрх чөлөөтэй байж, амьдрал түүнд төдийчинээ их баяр хөөр бэлэглэнэ”. “Ёс суртахууны төлөвшил нимгэн газар аугаа их хүн байдаггүй” учир УИХ үндсэн ажлын зэрэгцээ гишүүдийнхээ ёс суртахууны байдалд анхаарч байх нь зүйн хэрэг. УИХ-ын гишүүд хатуу зөөлний хайлш мэт байж, тэсвэр тэвчээрийг уян зөөлөн сэтгэлтэй сүлэлдүүлэн, онч мэргэн шийдвэр гаргахыг чухалчлан хичээх үүрэгтэй.

Нөхцөл байдал хэдийчинээ хүнд бэрх байна, төдийчинээ хатуу чанга чанар, шийдэмгий зоримог шийдэл хэрэгтэй. Сайн ёс зүй нь сайн хуулиас илүү их ач холбогдолтой гэх үг бий. Их хурлын гишүүд ямар ч үед ёс зүйн зарчмаа ёсчлон дагахыг эрхэмлэвэл зохино. Хэлэх амархан, хийх хэцүү. Хэцүүгийн жаргал, зовлонг эрх баригчид л үүрч эдлэх үйлтэй.

Жаргал нь түмэн олныхоо төлөө хийсэн ажилтай, бүтээсэн бүтээлтэй, хэлэх үгтэй нүүр бардам байдагт оршино. Хийх зүйл хязгааргүй их, хийх боломж нь цаг хугацааны хийгээд хөрөнгө санхүүгийн хязгаартай. Хүлээлт уул нуруу мэт том. Хүлээлтийг хугаслахаар хуруу хумсаа хуйхлан зовно. Хэчнээн сайн хийлээ ч мөнхийн сэтгэл дундуур шүүмжлэгчдийн үг хэлний бай болж зовно. Хийж амжаагүйн төлөөнөө зовно.

Бүгдийн сэтгэлд нийцэх бүрэн дүүрэн үйлийг бурхан ч гүйцэлдүүлэхэд бэрх гэж сэтгэлээ тайтгаруулан, хийхийн төлөө зүтгэж, хийсэн бүтээсэн ажлынхаа үр дүнг харж, бахархан омогших тун урамтай. Төрийн түшээд өндөр нэр алдрын эзэд мөн. Гэхдээ л нэр алдраас илүү хүн чанарын тухай бодох хэрэгтэй. Сонгуульт алба хугацаатай. Эзний алба ээлжтэй гэдэг шиг өндөр нэр алдар мөн л хугацаатай, харин хүн чанар хугацаагүй. Хугацаа өндөрлөх хүртэл хүнээрээ үлдэх шаардлагатай. Өөрсдийнх нь төлөө хэн илүү санаа тавьж, сэтгэл гарган зүтгэж байна, тэднийг ард түмэн дэмжсээр байх болно. ■



ХЭЛЗҮЙ

## ХУУЛЬ ШИГ ХУУЛЬТАЙ БОЛЬЁ

Гаднын оронд хууль боловсруулахдаа нийгэм, эдийн засгийн эрсдэл дагуулах эсэх, үндэслэл, судалгаатай хууль болж чадсан зэргийг эрдэмтэн, судлаачдаар хянуулж, засуулдаг байна.

### Б.УУГАНБАЯР

Бидний өдөр тутмын амьдралд УИХ-аас гаргаж буй хууль, тогтоомж шууд болон шууд бусаар нөлөөлдөг билээ. Сайн хууль батлавал улс орны хөгжлийг урагш нь татаж, иргэдийн амьдрал ахуйд нэмэр болдог бол судалгаа, нотолгоогүй боловсруулсан хууль иргэдийг мухардалд оруулдаг нь үнэн. Дээр нь хууль болон бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбоотой

журам байдаг ч түүнийг сайн мөрддөггүй явдал олонтаа тохиолддог. Ялангуяа наад захын шаардлага болох хуулийн төсөлд тавих хэлзүйн шаардлагыг хангадаггүй болохыг хэл зохиолын чиглэлийн судлаачид шүүмжилдэг. Хүн хуулийн агуулга утга учир нь ямар, юунд зориулж хэрхэн гаргасныг нь ойлгохгүй, нэр томъёог нь мэдэхгүй байж хэрэгжүүлнэ гэдэг тун хэцүү асуудал. ►

## ▸ Хууль зөрчсөн үгнүүд

Сүүлийн үед улстөрч, эдийн засагчид стратегийн ач холбогдолтой орд, аж ахуйн нэгж, салбар гэх мэтчилэн ярих болсон. Тэгвэл стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой дараах салбарыг үндэсний аюулгүй байдалд стратегийн ач холбогдол бүхий салбар гэнэ” хэмээн тодорхойлоод үүнд, эрдэс баялаг, банк санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарыг багтаажээ. Энэ тодорхойлолт нь стратегийн ач холбогдолтой салбарыг стратегийн ач холбогдолтой салбар гэнэ хэмээн тодорхойлсон нь ногоон өнгийг ногоон гэнэ гэсэнтэй ялгаагүй байгааг эдийн засагчид шүүмжилж байна.

Нөгөө талаас хүн амын үндсэн хэрэгцээнд эрдэс баялаг, банк санхүү, хэвлэл мэдээлэл гэхээсээ илүү хооллож, ундлах, орон байр, амьд явах хэрэгцээ л ордог. Тэгэхээр энэ тодорхойлолт нь өөр хоорондоо зөрчилдсөн тун чиг төвөгтэй сонсогдож байгаа юм. Шинжлэх ухааны хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтдийн судалснаар стратеги гэдэг үгийг ийнхүү хуульд ашиглах нь утгын хувьд тохиромжгүй тул хэтийн чиг бодлого, хэтийн бодлого, хэтийн төлөвлөгөө, холч бодлого зэрэг монгол үгийг ашиглах боломжтой хэмээн зөвлөж байна. Учир нь, стратеги гэдэг үг нь Грекийн *strategia* буюу ерөнхий удирдлага, команд гэсэн үгнээс гаралтай бөгөөд утгачилбал цэрэг дайны томоохон үйл ажиллагааг удирдан чиглүүлэх дайны арга техник, зохион байгуулах урлагыг хэлдэг аж. Мөн нийгэм, улс төрийн тэмцлийг удирдан зохион байгуулах урлаг гэсэн агуулга ч байдаг юм байна. Уг нь, Улсын их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын 13.1.4 монгол хэлд тохирох үг байвал гадаад хэлний нэр томъёо хэрэглэхгүй хэмээн заасан байдаг ч өнөөдөр энэ заалт хэрэгжихгүй, бүр ийм хуулийн заалт, тогтоомж байдгийг ч УИХ-ын гишүүд мэддэггүй юм шиг байна.

Тухайлбал, Концессийн тухай хууль гэхийн оронд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль гэж нэрлэж болох байжээ. Үүнтэй адил хуулийг иргэдэд ойлгомжтой болгохын тулд монгол хэлээр орчуулж болох үгсийг Шинжлэх ухааны академийн Хэлзүйн хүрээлэнгийн эрдэмтэд судалж байна. Үүний нэг жишээ нь Үнэт цаасны тухай хуульд, андерайт / *underwriter*/ гэсэн англи үгийг шууд авч ашиглажээ. Тус үгийн утга нь тусалж дэмжихийг зөвшөөрөх, эрсдэлийг тооцох, нэмэлт гарын үсэг зурах гэсэн агуулгатай аж.

Тэгвэл Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн доктор О.Шинэбаярын санал болгож буйгаар андерайт хэмээх харь гаралтай үгийг монгол хэлний хэллэгээр даан батлагч, даан батлаач, баталгаажуулагч, даагч гэх мэтээр оноож болох юм байна. Энэ мэтчилсэн иргэд, олон нийт нэгдсэн утгаар ойлгоход хүндрэлтэй, хоёрдмол утгатай ойлгомжгүй үгнүүдийг яаралтай цэгцлэх шаардлагатай Академич Л.Болд ярьсан юм. Тухайлбал, эрдэмтдийн тодорхойлсоноор стратеги нь тодорхой зорилгодоо хүрэх урт хугацааны төлөвлөлт гэж ойлговол стратегийн орд

гэж нэрлээд яриад буйг юу гэж ойлгох вэ. Урт хугацааны төлөвлөлтэй орд, урт хугацааны төлөвлөлттэй салбар гэх юм уу. Ингэж зэрэмдэг үг хэрэглэж, хэн хэнийхээ толгойг гашилгасан ойлгомжгүй, тодорхойгүй үг хэрэглэхийн оронд эрдэмтдийн судлаад, гаргаад ирсэн монгол үгийг ашигламаар байна.

Ер нь улстөрч аль болох иргэд, олон нийтэд ойлгомжгүй үгийг ашиглах гэж улайрдаг нь цаанаа далд бодлого явж байдаг юм байлгүй гэж таамаглах ч бий. Тиймээс энэ холион бантан шиг үгийн цуглуулагдаа анхаарч, улсаа хөгжүүлэхийн төлөө сэтгэл гарган ажиллах шударга улстөрч өнөө цаг үед, алтнаас үнэтэй буй гэхэд хилсдэхгүй. Тэгэхгүй бол хууль баталж байгаа хүмүүс ч өөрсдөө ойлгодоггүй, иргэд нь ч утгыг нь мэддэггүй үгтэй хууль бөөнддөг, түүнийг нь хагас дутуу мөрддөг хэцүүхэн гарч чадахгүй.

## Боломж

Гаднын оронд хууль боловсруулахдаа нийгэм, эдийн засгийн эрсдэл дагуулах эсэх, үндэслэл, судалгаатай хууль болж чадсан зэргийг эрдэмтэн, судлаачдаар хянуулж, засуулдаг байна. Мөн олон нийтийн санал бодлыг сонсож, хэлэлцүүлгүүд ч олноор хийдэг аж. Барууны зарим оронд тухайн хууль нь анхлан санаачилсан хүнийх нь нэртэй мөнхөрүүдэг туршлага ч байдаг аж. Хэрэв тухайн улстөрч “но”-той хууль санаачилж, тэр нь хүмүүсийн амьдралд сөргөөр байгаа бол олон нийтээрээ дургүйцдэг, харин сайн хууль санаачилсан бол нийтээрээ сайшаадаг байна. Ингэхлээр улстөрчид өөрсдийнхөө нэр хүндийг бодсон ч аливаа хуулийг санаачилж, хэрэгжүүлэхдээ хянамгай хандаж, нөгөө талаас олон нийтийн хяналт үүсдэг аж. Харин манайд аливаа хуулийг батлахдаа иргэдээр хэлэлцүүлж, санаа бодлыг нь сонсож тусгадаг байх, нөгөө талаас хэрэгжилтэд хөндлөнгийн, олон нийтийн хүчтэй хяналт өгүүлэгдэж буйг хүмүүс хэлж ярьсаар байгаа шүү дээ.

Өөр нэг төвөгтэй асуудал нь УИХ-ын гишүүн бүр л хууль санаачилж батлуулахыг зорьж, дээгүүр, доогуур гүйдэг. Үүнээс зарим нь өөрийн нэр хүндээ өсгөх далд агуулга бүхий “рекламны” шинж чанартай хууль ч байдаг гэдгийг Эрсдэлийн шинжээч Д.Ганбаяр шүүмжилсэн. Мөн бусад орны зарим хуулийг шууд бүрэн эхээр нь шахуу орчуулж хэрэглэх явдал байдаг байна. Ингэхдээ ойлголтын буруу, зөрүүг хайхралгүйгээр зэрэмдэг хууль төрүүлдэг тохиолдол цөөнгүйг эдийн засагчид толгой сэгсрэн ярьсан юм. МУИС-ийн Хуульзүйн сургуулийн багш Б.Тэмүүлэн хэлэхдээ “Өрсөлдөөний тухай хуулийн 90 орчим хувийг ОХУ-ын хуулиас шууд хуулж авсан учир сайн хууль болж чадаагүй. Яаж ч бодсон манай зах зээлийг ОХУ-ынхтай шууд харьцуулах боломжгүй” гэв.

Ер нь улстөрчид хууль баталдаг мэргэжлийн улсууд биш юмаа. Тэгэхээр шинээр гарч буй хуулийн утга, агуулга, хэл найруулга талаас нь хянаж, үнэлэлт өгч байдаг мэргэжлийн багийг бий бүрдүүлж, судалгаа, шинжилгээтэй хууль “үйлдвэрлэх”-ийг шинэ УИХ-д мэргэжлийн хүмүүс зөвлөж буй. Мөн бүх нийтийн эрх ашгийг хөндсөн хуулийг нийтээрээ хэлэлцэж, усыг нь шахаж чамбай хууль “төрүүлэх” эрхзүйн орчин үгүйлэгдэж буйг сануулъя. ■

РЕДАКЦИЙН ЗОЧИН

## ЗАЛУУЧУУДЫНХАА ОЮУН, СЭТГЭЛГЭЭНИЙ ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙН ЗАМЫГ ЗАСЬЯ



ФОТОГ Э.ЗОРИГТ

Зүүн гар талаас Б.Ганболд, А.Амарсайхан, Д.Жаргалсайхан

Нийтлэлч Н.Баабарын хэлдгээр “Бидний үе үхээд, тэрний дараагийн, дараагийн үеэс л монгол сэтгэхүй бий болж, социалист сэтгэхүй устах байх” гэдэг үнэн болоод байх ШИГ.

*Шинэ Их хурал нээлтээ хийж, шинэ төр, шинэ засаг бүрэлдэж байгаа энэ үед “Mongolian Economy” сэтгүүл “Монгол сэтгэхүй”, “Тулгын гурван чулуу” сэдвийн хүрээнд редакцийн уулзалт зохион байгуулсан юм. Сүүлийн үед Монголчууд герман маягаар хуралдаж, ажиллачихаад гэртээ монгол ахуйгаар амьдарч байна гэж ярих болсон. Яаж монгол сэтгэхүйгээ авч үлдэх вэ, хэрхэн хөгжүүлэх*

*вэ, ер нь монгол сэтгэхүй гэж чухам юу юм бэ, яагаад хэрэгтэй талаар УИХ-ын шинэ гишүүдэд санаа, оноо хүргэх зорилгоор энэхүү редакцийн уулзалтыг хийсэн билээ. Манай уулзалтад ГХЯ-ны Азийн газрын захирал Б.Ганболд, “FSCO Mongolia” компанийн ерөнхий захирал Д.Жаргалсайхан, шог зураач, кино зохиолч А.Амарсайхан нар уригдан оролцлоо.*

**-Монгол сэтгэхүй гэж юу болох, монголчууд бусад үндэстнээс юугаараа ялгардаг талаар яриагаа эхлэх үү?**

**Д.Жаргалсайхан:** -Би бол жирийн л инженер хүн. Гэхдээ Монгол Улсын иргэний хувьд хэлэх хэдэн зүйл байна. Ялангуяа шинэ Засгийн газар үүсэн бий болж, гишүүд тангаргаа өргөж буй түүхэн үед танай сэтгүүл ийм чухал сэдвийг хөндөж

байгаад талархаж байна. Оросын нэрт эрдэмтэн Гумилев “Тухайн ард түмэн оршин буй орчныхоо байгаль, цаг агаар, байршилтай шууд зохицсон бүтээгдэхүүн байдаг” гэж тодорхойлсон байдаг. Монголчуудыг хоёр гартай, хөлтэйгийнх нь хувьд бусад үндэстэнтэй харьцуулбал ялгараад байх юм гарахгүй. Харин амьдарч буй газар зүйн байрлал, эрс тэс уур амьсгалд зохицдог, байгальд

захирагдаж амьдардаг, амьдралд хандах хандлага, ухаан сэтгэхүйнх нь хувьд харьцуулбал том зөрүү харагдана.

Олон хүн амтай, эсвэл цөөн хүнтэй аль нэг улстай бид өөрсдийгөө сэтгэхүйн хувьд харьцуулах ёсгүй. Учир нь бид монголчууд. Хувьсгалаас өмнө Монгол Улс 100 хувь нүүдэлчин ард түмэн байсан. Нүүдэлчин ахуй гэдэг өөрөө монгол сэтгэхүй юм. ▶▶

## Нүүдэлчин ахуй гэдэг өөрөө монгол сэтгэхүй

► Харин хувьсгалаас хойш Европын соёл яах аргагүй хүч түрээд ороод ирсэн. Өнөөдөр бид Азийн нэг хэсэгт амьдарч буй мөртлөө Европын соёлыг нэвтрүүлж, бүр түүнээсээ гарах, салах тухай ярьж байна. Энэ дасан зохицох чадвар өөрөө монгол сэтгэхүйтэй зайлшгүй холбоотой.

**Б.Ганболд:** -Чухал сэдвээр чухал цаг үед ярьж байгаадаа баяртай байна. Энэ асуудал маш өргөн хүрээтэй. Гэхдээ өнөөгийн цаг үетэйгээ тохируулаад яривал хэд хэдэн зүйл байна.

Дэлхийн олон улс орноор явж байхад монгол хүний амьдрах ухаан бусад ард түмний сэтгэлгээ, амьдралын зовлон жаргалд хандах хандлага, чадвараас ихээхэн ялгаатай нь ажиглагддаг юм. Энэ нь манай ард түмний мах цусанд нь шингээстэй сэтгэхүйтэй шууд холбоотой. Үүнийг би нэгдүгээрт, монголчуудад удам угсаа, төр улсаа авч явах арга ухаан эрт үеэс төлөвшсөн. Жишээлбэл, дайн тулааны хүнд хэцүү үед эв эеийг хичээж, цөөн хүний холч ухаанаар олныг дийлж ирсэн түүх бидэнд бий. Таварван жилийн ашиггүй бусирээдүйг, тэрний цаадахыг харж, сэтгэдэг холч ухаан. Хоёрдугаарт, ахмад настнаа хүндлэх, эцэг эх, өвгөдийнхөө сүнс сүлдэд залбирч, сүслэж явдаг хүндлэлийн ухаан. Гуравдугаарт, байгаль, цаг уурын хатуу ширүүн нөхцөлд тохирч амьдарч чаддаг. Байгаль, эх дэлхийгээ хайрлаж, хамгаалах ухаанд үр хүүхдээ сургаж, байгальтайгаа ойрхон амьдардаг үндэстэн. Ийм гурван сэтгэлгээ нь нэг хүнд төлөвшсөн үндэстэн бол зөвхөн Монгол. Энэ гурвын аль нэг нь гээгдэх учиргүй. Учир нь энэ бол монгол сэтгэхүй. Энэ сэтгэхүй үеийн үед өвлөгдөж ирсэн. Харин үүнийгээ хадгалж, хамгаалж үлдэх нь маш чухал.

**А.Амарсайхан:** -Монгол хүн бүр бүх зүйлийг эдийн засгийн ухаанаар хардаг байсан байгаа юм. Яавал хэмнэлттэй амьдрах вэ гэж. Энэ ч утгаараа монголчуудын амьдрал маш хямд төсөр мөртлөө тохилог дулаахан, тав тухтай, зардал багатай

байсаар ирсэн. Монгол гэр, түлш түлээ, эрхэлж буй мал аж ахуйн хувьд эргээд бодоод үз л дээ. Дайн тулааны үед ч эдийн засгийн ухаанаар бусдыг ялан дийлдэг байжээ. Их хүчийг бага хүчээр яаж дарах вэ гэж. Тухайлбал, цасан шуурга болохыг хүлээж байгаад шуурга тавиад эхлэнгүүт 100 мянган цэргийг аравхан мянган цэргээр дарсан байх жишээний. Энэ бол эдийн засгийн хувьд хамгийн хэмнэлттэй монгол сэтгэхүй юм. Үүнийг бид өвлөсөн байх ёстой. Гэвч хаа нэгтээ гээчихээд байна.

**-Цаг үеэ дагаад хөгжиж буй энэ үед монгол сэтгэхүй чухам яагаад хэрэгтэй юм бэ. Яаж сэргээж, хэн хөгжүүлэх ёстой вэ?**

**Д.Жаргалсайхан:** -Монгол хүний сэтгэхүйг хөгжүүлэх гэхээс өмнө монгол хүний сэтгэхүй гэж чухам юу болохыг судалж, тогтоох хэрэгтэй. Түүний дараа монгол хүн чинь ийм сэтгэхүйтэй юм байна, үүнийг нь ингэж хөгжүүлбэл улс оронд ийм нэмэр болно, ирээдүйд хэрэгтэй гэдэг утгаар нь үе шаттайгаар авч үзэх хэрэгтэй. Түүнээс биш монгол сэтгэхүйг хөгжүүлж байна гээд л цээжээ дэлдээд байх нь чухал биш. УИХ-ын гишүүд Засгийн газрыг эрхийн дөрвөн жилээрээ л хэмжиж, ойлгоод байдаг. Тийм ч учраас тухайн хурал дээр онцгойрох, тодрохыг эрмэлзээд худал амлалт өгч, хувийн амьдралаа өөд нь татаад явдаг нь нууц биш. Гэтэл бид биш тэд яг энэ сэдвээр өнөөдөр биш бүүр өмнө нь ярилцаж, ямар нэг ажил хийх ёстой хүмүүс шүү дээ.

**Б.Ганболд:** -Түрүүний миний хэлдгээр бид дэлхийд хосгүй сэтгэлгээтэй нь үнэн. Харин өнөөдөр тэрийгээ ор тас мартчихаад одоо сэргээх гээд байна уу гэвэл үгүй. Өвөг дээдсээс уламжилж ирсэн тэр олон зүйлээс бидэнд авах юм бий. Мөн гээх ч юм байна. Дээрээс нь нийт хүн төрөлхтөний хөгжлөөс хамаарч хүний амьдрал ахуйд ч өөрчлөлт, шинэчлэл ордог. Тиймээс бид тэр өөрчлөлтийг авах л хэрэгтэй. Авто машин гарчихаад байхад үгүй ээ, би монголоороо байна, машин унахгүй,

мориор явна гэж болохгүй биз дээ. Харин хэд хэдэн суурь зарчмаа л монгол уламжлалаараа авч явах хэрэгтэй юм. Түүнийгээ л ялгаж салгаж ойлгох хэрэгтэй байх.

**А.Амарсайхан:** -Бид Манжийн үеэс л Монгол сэтгэхүйгээ алдах зам руу хальтарч эхэлсэн байх. Манжууд биднийг уусгахын тулд, засаг захиргааны нэгжээс нь эхлээд энгийн амьдралд нь хүртэл өөрчлөлт хийсэн. Дээрээс нь үндэсний бахархал, нийт ард түмний бахархлыг нь үгүй хийх ажлыг их хийдэг байсан байгаа юм. Сүүлд нь оросууд орж ирээд энд тэндхийн бүх зүйлийн байрыг нь солиод хаячихсан. Өнөөдөр бид монгол сэтгэхүйгээр хүүхдээ хүмүүжүүлэх гээд аргал түүлгэхээр явуулах нь утгагүй. Гэхдээ маш энгийн орчин ахуйдаа нийцсэн дадал зуршлаас эхэлж хүүхдээ хүмүүжүүлэх хэрэгтэй байх. Манай эцэг, эхчүүд барууны сэтгэлгээнд хэт автаад байна. Тухайлбал, эцэг, эх нь хүүхдээ заавал сургуульд нь хүргэж өгөх хэрэгтэй гэдэг ч юм уу. Угтаа бол хүүхдээ бие даалгахын тулд хэлэх, захиж зүйлсээ хэлж, захиад өөрөө сургуульдаа явах дадлыг бий болгох хэрэгтэй. Бид хүүхдээ насаар нь дагаж явахгүй. Тиймээс тухайн хүн нийгэмд өөрийн байр суурийг өөрөө бий болгох учиртай.

**-Шведийн хэсэг судлаач манай залуучуудын дунд судалгаа хийж “Танай улсын залуучууд энэ сэтгэлгээгээрээ байсаар байвал Монгол удахгүй мөхнө” гэсэн дүгнэлт хийгээд явжээ. Үүнийгээ тайлбарлахдаа “Танай орны ихэнх залууст шударга зан, үндэсний соёл, ажилсаг байх талаар нэгдсэн ойлголт алга. Монгол залуучууд том дарга таньдаг эсэх, ганган хувцас, унасан машинаараа хуваагдчихсан байна. Түүнээс биш үзэл бодлоороо хуваагдсан нь цөөхөн. Мөн залуучуудын хувьд секс бол хайр дурлал, харилцаа биш хэрэглээ болчихож. Үүнийг нь дагаад улс төрийн намууд ч үзэл бодлоороо бус хэрэглээгээрээ сэтгэдэг болж. Энэ нь танай улсын»**

► **сүйрэл” гэсэн байгаа юм. Үүн дээр та бүхэн ямар бодолтой байна вэ?**

**Д.Жаргалсайхан:** -Миний өмнө эрдэмтэн М.Төмөржав, Н.Эрдэнцогт нарын бичсэн “Монголын нүүдэлчин” гэсэн ном байна. Иймэрхүү дүгнэлтийг аль хэдийнэ манай судлаач, эрдэмтэд хийчихсэн байгаа юм. Тухайлбал, “Тухайн хүний сэтгэхүй, үйлдэл нь тухайн үндэстний сэтгэхүйн илрэл юм. Хүн төрөлхтөний соёлыг байршлаар нь ангилбал, Өрнөдийн хөгжингүй дөрвөлжин соёл, Дорнодын хөгжингүй бус дөрвөлжин соёл, Монголын өндөрлөгийн дугуйлжин соёл гэж ангилж болно. Дөрвөлжин соёлын орчинд энэрэнгүй хорвоо бөгөөд эд, материал, эрх тушаал ихтэй ч оюуны чадавхи, гэрлээр муутай хүмүүс оршино. Энэ бол зоостой хүн жаргах, зоосгүй хүн зовохын орчин. Чухамдаа дөрвөлжин соёлын орчинд өнгө мөнгө л бүхний хөтлөгч. Энэ орчинд эх хүн болсон нигүүлсэнгүй бүрэлбаа, хүний бие махбодийг бүтээгч, эмэгтэй хүнийг бишрэн хүндэтгэх үзэл устан харин ч мөнгөөр худалдан арилжаалж, нүцгэлэн тоглох тоглоом болгожээ. Энэ бүгдийг нөхөж чадах газар бол дугуйлжин соёлт газар буюу Монголын тал нутаг юм” гэсэн дүгнэлтийг Өвөрмонголын эрдэмтний хамт гаргасан байгаа юм. Маш хурц шүүмжлэл. Үүнийг бид аль хэдийнэ ойлгож, ухаарах ёстой байсан.

Гэхдээ одоо оройтох юу байна. Харин ч танай сэтгүүл үүнийг хөндөж гаргаж ирлээ. Хамгийн том асуудал бол Зөвлөлтийн үеэс орж ирсэн Европын гэгдэж буй соёл иргэншлээс бид салж чадахгүй байна. Нийтлэлч Н.Баабарын хэлдгээр “Бидний үе үхээд, тэрний дараагийн, дараагийн үеэс л монгол сэтгэхүй бий болж, социалист сэтгэхүй устгах байх” гэдэг үнэн болоод байх шиг. Гэхдээ төр, засаг монгол үндэстэн, монгол сэтгэхүйн төлөө нэгдмэл нэг санаагаар ажиллавал тийм ч хэцүү, хол зүйл биш юм.

**А.Амарсайхан:** -Залуу үе бол үндэстний гэсэн бүгдийг авч үлдэх, хойчид өвлүүлэх гол хүч. Тэдэнд монгол сэтгэхүй, бахархлыг уриалж, ухуулж бий болгох хэрэгтэй. Хуучин Марксизм, Ленинизм гэгч нь биднийг хэзээ нэг өдөр ямар нэг гэгээн зүйлд

хүргэнэгэхитгэлүнэмшлийгсуулгасан байсан. Ард нийтээрээ ямар нэг гэгээн зүйл рүү тэмүүлж байж. Гэтэл удалгүй шал худлаа, хоосон зүйл болж урмыг нь хугалчихсан. Гэхдээ тэр үед хүн бүр хүсэл тэмүүлэлтэй, зорих юмтай байсан байгаа юм.

Тиймээс одоо ямар нэг санаа, тэмүүлэл бий болгох хэрэгтэй. Түүний ачаар олон зуун залуу үндсэрхэг үзэл, үндэстний сэтгэхүйгээ авч үлдэнэ, өвлүүлнэ. Үүнийг би “Тусгай салаа” киног хийж байхдаа мэдэрсэн юм. Тэр киног гарсны дараа хэдэн зуун залуу цэргийн алба хаахыг

хүсдэг, тэмүүлдэг, мөрөөддөг, эх оронч сэтгэлгээтэй болсон. Тэгэхээр төр, засгаас ийм зүйлд анхаарлаа хандуулж, уран бүтээлчидтэйгээ хамжиж, дэмжээд жаахан мөнгөөр л бий болгох зүйл юм. Гаднын кино, уран бүтээлүүд бүгд цаанаа үндэстний бахархал, үндэстний соёлоо өөрийн болоод гаднын ард түмэнд сурталчилсан байдаг. Яг үүн шиг бид ажиллах хэрэгтэй. Ганцхан сэтгэхүй биш, өөр олон бахархлаа бид судалж гаргаж ирээд, ийм маягаар сурталчилах хэрэгтэй. Жил болгон л зам засаж байна гээд мөнгийг ►



Д.Жаргалсайхан: Ард түмэн нь намхан, төр засаг нь өндөрх байж болохгүй шүү дээ.

## Монголчуудын хүүхдээ эрхийг сурахаар бэрхийг сур гэж сургадаг ухаан хаачсан юм бэ

▶ тэрбум, тэрбумаар нь цацдаг. Дараа жил нь ахиад л засдаг. Тэгвэл тэр их мөнгөө байг гэхэд өчүүхэн хэсгээр нь залуучуудынхаа оюуны, сэтгэлгээний, эх оронч үзлийн замыг засъя л даа.

**Б.Г:** -Монгол сэтгэхүй нь шив шинэ зүйл биш шүү дээ. Монгол цустай хүн бүхэнд байгаа зүйл. Үүнийг уламжилж үлдээх л чухал. Тиймээс бага, дунд ангийн сурагчдад энэ талын үзэл баримтлалыг сурах бичиг, орчинд нь бий болгох хэрэгтэй. Уг нь бол бэлээхэн байна шүү дээ. Монгол ардын аман зохиол, үлгэр, тууж гээд. Хүүхдүүдийг уншуулж, сонсгож дадшуулах хэрэгтэй. Тэр бүхэнд бидний яриад буй монгол ухаан, сэтгэхүй ертөнцийг үзэх үзэл, зовлон жаргалыг тэнцүүлэх ухаан, байгалийн болоод бусад саад бэрхшээлийг туулах, харах ухааныг заасан байгаа.

Монгол хүүхдүүд болж өгвөл Монголдоо сурч, төгсдөг баймаар. Гаднын ихэнх улс бусад улсын томоохон сургуулийн салбарыг эх орондоо байгуулаад хүүхдүүдээ сургаж байна. Манайх энэ жишгийг нэвтрүүлэх хэрэгтэй. Энэ нь монгол сэтгэлгээг хадгалж, хамгаалж үлдэх нэг чухал арга юм. Дээр нь гаднын сургалт, технологийг монгол сэтгэлгээгээр сурч, эзэмших юм.

**-Үүнд бодлого тодорхойлогчид чухал үүрэг гүйцэтгэх нь тодорхой. Үүнийг яриа төдийхнөөр үлдээмээргүй байна. Төр, засгийн зүгээс чухам юу хийгээсэй гэж бодож байна вэ?**

**Д.Ж:** -Амараагийн хэлдгээр хүнийг хөтөлж, тэмүүлэлтэй байлгах нэг зүйл хэрэгтэй гэдэгтэй би санал нэг байна. Орос ах нарын зааж, зөвлөж байсан бүхнээс бид салж чадахгүй байна гэдэг ч үнэн. Суурь механизмууд нь бүгд хуучин хэвээрээ, гэхдээ удахгүй өөрчлөгдөнө. Тиймээс одоо л монгол сэтгэлгээ, холч ухаан, үндэсний гэгдэх бүхнээ залуучууддаа төлөвшүүлэх хэрэгтэй байна. Энэ тохиолдолд Монгол айх юмгүй болно. Монгол ахуйгаас шууд тусгаад

авах нэг нь тулгын гурван чулуу гэх ойлголт. Хөрөнгөжсөн хүмүүс, ядуу иргэд, Монголын төр энэ гурав гурван биедээ өстөн, дайсан биш шүү дээ. Харин ч тулгын чулуу юм. Тэд тулгын чулуу шиг эн тэнцүү байх ёстой. Ард түмэн нь намхан, төр, засаг нь өндөр байж болохгүй. Бие биеэ дэмжиж, ижил хэм хэмжээтэй, эрх үүрэгтэй, эн тэнцүү байж л улс орон хөгжиж, тэр гурав дээр цайгаа чанаж ууж чадна шүү дээ. Үүнийг л шинэ Засгийн газар баримтлах хэрэгтэй болов уу.

**-Тулгын гурван чулууны нэг нь болох төр өнөөдөр нөгөө хоёр тулгын чулуунаасаа арай өндөр байгаад байх шиг. Төрд ажиллаж буй хүний хувьд Ганболд захирал энэ тал дээр юу хэлэх вэ?**

**Б.Г:** -Төр захиргааны эрх мэдэл, хүнд суртал, илүү зардал сүүлийн жилүүдэд жин их дарж байгааг нуух юун. Хэдийгээр би төр түшилцэж яваа ч ийм байдал их ажиглагдаж байна. Тухайлбал, аль ч захиргааны байгууллага зардал нэмүүлэх, нэг хүний ажлыг хоёулаа хийх сонирхолтой болчихжээ. Энэ Засгийн газар үүнийг л хазаарлаж, устгаасай.

Хувийн хэвшилд ажиллагсад олон цаг ажиллачихаад бага цалин хөлс авдаг, төрийнх гэхээр бага цагт их мөнгө авдаг байж болохгүй шүү дээ. Эдийн засагт эерэг хандлага ирж, төсөвт мөнгө нэмэгдэж байгаа энэ үед дээрх байдал улам бүр гаарч байна. Төрийн захиргааныхан төсөв мөнгөө нэмүүлэхийг л хичээдгээс биш зөв зарцуулж чаддаггүй хүмүүс, үнэндээ. Үүний цаана хийх ёстой ажил сул орхигдож байна. Тэр сул мөнгөөр техник, технологи, эрүүл мэнд, соёл боловсролын салбарт ямар нэг юм хийх ёстой. Үүний цаана бас хүний асуудал яригдана. Төрийн алба руу бүгд хошуурч байна. Төрийн байгууллагад олонх нь ажиллачихаар хэн бүтээн байгуулалт, хөдөө, аж ахуй, үйлдвэрлэлийг хийх юм бэ. Монголчууд цөөхүүлээ шүү дээ. Миний хувьд хүн гэдэг хамгийн чухал

капиталаа үргүй газар байршуулаад, дэмий цаг өнгөрүүлээд буй том сул тал ажиглагддаг.

**А.А:** -Ард түмэн намхан байдгийн буруутан нь төр. Ард түмнийг мэдээлэлгүй байлгаж байна. Хөдөөний хүмүүс хотод л амьдрал байна. Хашааныхаа үүдэнд нэг дэлгүүр байгуулаад авбал бүр ч янзтай амьдрах юм байна гэж ойлгож, бүгд хот руу нүүнэ. Хөдөөдөө сайхан амьдарч байсан айл малаа бүгдийг нь зарж, хотын хаа нэгтээ хашаа хатгаж аваад л ядуусын эгнээнд орж байна шүү дээ. Тэгээд ах, дүү танилаа утсаар ярихаар нь нэрэлхүү зандаа хөтлөгдөөд "Өө сайхан байна. Жаргаж байна" гэдэг. Хөдөөнөөс хүн ирэхээр нь байдгаа ломбардад тавьж байгаад л томчуудын уудаг архи, иддэг хоолоор дайлаад явуулдаг. Нөгөөдүүл нь нутаг, сумандаа очоод хотод үнэхээр амьдрал байна. Тийшээ нүүе гээд л хүрч ирж, ядуусын тоог нэмнэ.

Дээрээс нь хүн амдаа ихэдсэн олон их, дээд сургууль. Арав төгссөн хүн болгон тэнэг ч бай ямар ч бай бүгд их, дээд сургуульд орж байна. Ядаж төгсөгчдийн 30 хувь нь их, дээд сургуульд ордог болгомоор байна. Үлдсэн нь коллеж энэ тэрд орж, ажилчин ангийг бүрдүүлж бүтээн байгуулалт хийх хэрэгтэй байна шүү дээ. Гэтэл цаана чинь баахан худлаа дүнтэй, хуурамч төгсөгчид ажилгүйчүүдийн тоог нэмээд л, эцэг, эхээрээ тэжээлгээд, дээд боловсролтой хүн хог шүүрдэж, хоол хийдэггүй юм гээд л хэвтэж байна.

Монголчуудын хүүхдээ эрхийг сурахаар бэрхийг сур гэж сургадаг ухаан хаачсан юм бэ. Монголын хамгийн үнэт капитал чинь хүн. Хамгийн ойрын жишээ гэхэд хууль зүйн мэргэжлээр жилд гурван мянга орчим оюутан төгсөж байна. Гэтэл хууль зүйн салбарт гурван мянган хүн ажилладаг байх жишээтэй. Тэднээс их бодож л жилд 50 орчим ажилчин тэтгэвэрт гарна. Тэгэхээр хууль зүйн чиглэлээр төгссөн тэр олон оюутан ▶

► хаана, ямар ажил хийх вэ. Энэ бүгдийг зохицуулах цаг нь болсон.

**Д.Ж:** -Монгол сэтгэхүй, монгол уламжлалаасаа бид авах юмаа авахгүй байна. Монгол хүүхдүүд хар багаасаа л морь унаж, малаа хариулдаг. Гаднынхан манай дөрвөн настай хүүхэд морь унахыг хараад дуу алдан гайхдаг. Гэтэл бидний хувьд энгийн үзэгдэл. Энэ хэдийгээр энгийн ахуй мэт боловч тэднийг багаас нь амьдралд бэлдэж байгаа хэрэг юм. Тиймээс яг л энэ уламжлалаар хүүхдээ аль болох багаас нь амьдралд бэлтгэх хэрэгтэй. Гэтэл өнөөдөр ямар байна. Бүгд л нэг алга дарам цаасны араас гүйдэг болж. Үнэн хэрэгтээ тэд амьдралд бэлтгэгдсэн үү гэвэл үгүй. Бие дааж амьдрах биш харин ч “паразит” маягын амьдралд бэлтгэгдэж байна.

Дээрээс нь нэг буруу, бугшмал ойлголт яваад байх шиг. Тэр нь өөрсдийгөө эмзэг гээд нэрлэхсэн хэсэг байна. Тэр эмзэг хэсэг нь зүгээр л амаа ангайгаад хэвтчихдэг. Бусад нь эвий, хөөрхий минь гээд л аманд нь хоол хийж өгөөд л. Нөгөө эмзэг хэсэг нь улам давраад одоо бүр хоолоо зажлуулж амандаа хийлгэх янзтай. Үүнийг нь улстөрчид ашиглаж, бэлэн мөнгө тараагаад л. Хариуд нь намайг сонгоорой гэнэ. Эрт дээр үед тухайлбал, Богд хаант төрийн үед 10 хоньтой хүн ч улсдаа жил бүр алба гувчуур төлдөг байжээ. Учир нь, Та бусадтай адил эрх эдэлж, үүрэг хүлээх учиртай.

Харин өнөөдөр 10 хоньтой бол эмзэг гэгдэж, Азийн хөгжлийн банктай хамтраад жаахан юм өгчихье гэх болжээ. Нөгөөдүүл нь бас авах гээд л хүлээгээд л хэвтэж байдаг. Энэ нь Монгол сэтгэхүй биш. Миний хувьд л таньдаг сэтгэхүй биш.

**-Өнөөдөр бид эдийн засгийн хямрал гэж их ярих болж. Гэтэл хамгийн чухал зүйл болох монгол хүн, монгол хүний сэтгэхүйн хямралыг ярихгүй байх шиг. Үүнийгээ мэдэхгүй байх нь өөрөө маш том хямрал юм гэдгийг хүмүүс хэлдэг. Тэгвэл чухам монгол хүн гэж хэн бэ. Мөн Монгол төр улс гэж юу вэ?**

**Д.Ж:** -Бид төр, төрийн оролцоо гээд их ярьдаг. Гэтэл яг суурь ойлголт нь юу вэ гэдгээ мэддэггүй. Адгийн



*Б.Ганболд:Нээлттэй нийгмээр дамжуулж ард иргэд, улстөрчдийн сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй.*

наад зах нь стратегийн орд гэж их ярьдаг. Тэгвэл стратеги гэдэг үгийг хайгаад үзэхээр зорилгодоо хүрэх урт хугацааны төлөвлөгөө гэсэн утгатай байдаг. Гэтэл стратегийн орд гэхээр зорилгодоо хүрэх урт хугацааны төлөвлөлтийн орд газар болж байгаа юм. Яг л үүнтэй адилхан монгол хүн, монгол төр гэж юуг хэлээд байгаагаа мэдэхгүй байна.

Гэхдээ өөдрөг зүйл бас байна аа. Монгол Улстай хөгжлийн гараагаа зэрэг эхэлсэн олон орон бий. АНУ бол 300 гаруй жилийн өмнөөс эдийн засаг нь хөгжиж эхэлсэн. Харин бид 20 гаруй жилийн өмнөөс л зах зээлийн эдийн засагт шилжсэн. Тиймээс хийсэн бүтээсэн зүйл их улстай өөрсдийгөө харьцуулах нь нэг талаар өрөөсгөл юм. Харин нэг гараанаас

цуг гарсан бусад оронтой харьцуулах нь илүү бодитой байх. 1990-ээд оны үед Киргиз мэтийн улс монголчуудтай дүүтэйгээ харилцаж байгаа юм шиг ханддаг байсан бол өнөөдөр ах нар шигээ хүндэлдэг болжээ. Энэ нь нэг талаар монголчуудын бахархал юм. Тиймээс бид монгол төр гэдгээ мэдэхийн тулд бусдаас давуу талаа олж харах хэрэгтэй.

Эрс тэс уур амьсгалаас хамаатай монгол хүний нэг чадвар нь ямар ч нөхцөлд түргэн зохицох чадвар. Энэ нь бидэнд илүү боломж бүрдүүлж өгөөд байх шиг. Үүнийгээ улам хөгжүүлэх хэрэгтэй. Манай ард түмэн өнөөдөр нар гарсан ч маргааш орох бороог урьдчилан мэдээд бэлтгэлээ базаадаг. Тэр ч бүү хэл тэрний дараагийн өдөр шуурах шуурганаас ►

## Улс төрийн жижиг сажиг шуурганд Монгол төр л ганхаж болохгүй

▶ хүртэл урьдчилан хамгаалсан байдаг шүү дээ. Тиймээс өнөөдрийн сонгож авсан энэ нийгэмдээ дасан зохицож, ирээдүйд учрах тэр эрсдэлээс зугатах л хэрэгтэй. Монголчуудад ийм чадвар бий. Чухам энэ л монгол хүн болов уу.

**А.А:** -Монгол хүнийг загварчлаад үзвэл бие мах бодийн болоод сэтгэхүйн хувьд бусдаас шал өөр. Тиймээс тэр онцлогт л зохицуулж бодлого, хууль дүрэм тэр ч бүү хэл эдийн засгийн загварчлалаа гаргах хэрэгтэй. Өнөөдөр монголчуудыг харахаар эдийн сонирхолтой юм шиг харагддаг. Ядуу хүн гэхэд л жийп машины үнэтэй тэнцэх хөөрөг зөрүүлж тамхилдаг. Гэхдээ энэ нь эдийн шуналтайдаа биш монгол хүний төрөлх мөн чанар буюу нэр төрөө дээдэлдэгтэй холбоотой. Би Хэвлэлийн хүрээлэнд ажиллаж байхдаа гаднын нэг төслийн хүрээнд Эрдэнэтолгой руу ядуу айлд очихоор болсон юм. Гаднаасаа бол хашаа хороогүй ядуувтар айл. Гэтэл гэрийн эзэгтэй гар утсаар ярьж байна. Охин нь бас өөр нэг гар утсаар мэссэж бичээд л. Нөгөө гаднынхан чинь гайхаад энэ айлд дундаж амьдралтай айлын хэрэглэдэг бүх зүйл байна шүү дээ. Ядуу өрх биш байна гэсэн. Яг үнэндээ монгол хүн нэр төрөө, өөрийгөө хүндэлдэг учраас өөртөө зориулж хэрэгтэй зүйлээ авч бий болгож чаддаг юм. Өнөөдөр захын нэг малчин Монгол Улсын Ерөнхийлөгчийн өмссөн дээлийн торгоор хүүгийнхээ хуриман дээр дээл хийж өмсөнө өө гээд цээж тэнэгэр сууж чаддаг. Энэ чинь л монгол хүн. Тиймээс энэ мэт монгол араншиндаа тулгуурлаж л бодлого тодорхойлогчид ажиллах хэрэгтэй.

**-Ганболд захирлаас асуухад, Та саяхан Израйлийн хөгжлийн түүхийн тухай ном орчуулсан байна. Өнөөдрийн асуудалтай холбогдуулаад ярихад израиль хүний сэтгэлгээ ямар байдаг юм бол. Тус орны хөгжлийн нууц юу байсан бэ?**

-Энэ номыг орчуулж байхад манайхтай адилхан зүйл их ажиглагдсан. Тэд бидэнтэй адилхан цөөхөн хүн амтай. Тиймээс ч бусдаас илүү шаргуу хөдөлмөрлөдөг. Учир нь олон хүн амтай улс хөгжихийн тулд өдөр шөнөгүй ажиллаж байгаа өнөө үед манайх шиг жижиг улсын нэг хүн, гаднын хоёр хүний хөдөлмөрийг ганцаараа хийх шаардлага гарч байна. Тэгэж чадахгүй бол тухайн

---

**Хувийн хэвшилд  
ажиллагсад олон цаг  
ажиллачихаад бага  
цалин хөлс авдаг,  
төрийнх гэхээр бага цагт  
их мөнгө авдаг байж  
болохгүй шүү дээ**

---

үндэстэн бусдадаа уусаад л алга болно. Энэ шаардлагын улмаас Израйль улсын жирийн иргэд, улстөрчид, бизнесмэнүүд маш хөдөлмөрч, ажилсаг. Тэд шинэлэг зүйлийг бусдаас түрүүлж сурахыг эрмэлздэг болохоос бусдын хийснийг ашигладаггүй. Хүний хараагүйг харах зарчмын дагуу ажилладаг. Тэр тусмаа өнөөгийн энэ нийгэмд бэлэн, үнэгүй зүйл гэж байхгүй. Өндөр хариуцлагатай хөдөлмөр чухал гэдгийг үнэн сэтгэлээсээ ухамсар-

ласан ард түмэн бол израильчууд. Монголчууд ч ялгаагүй ийм л ард түмэн. Өнөөдөр яах вэ, түр зуурын зүйлс яваад байна л даа. Хий хоосон амлалт, хэрэглээ тал дээр хэт анхаарах, бэлэнчлэх гэх мэт.

Монголчуудын төрөлх мөн чанар бол “Эрхийг сурахаар, Бэрхийг сур” шүү дээ. Зарим залуус зурагтаар гардаг гаднын нэг орны иргэд шиг амар хялбар аргаар сайхан амьдрах гэж зүтгэдэг. Харин тэр улсын ард иргэд тэр зурагтаар гардаг амьдралыг бүтээхийн тулд ямар их хөдөлмөрлөснийг тэр бүр мэддэггүй.

**Д.Ж:** -Түүхэнд хоёр үндэстэн маш муухайгаар мөхсөн байдаг. Эхнийх нь Манж үндэстэн. Тэд өөрсдийгөө тэнгэрийн хүү мэтээр төсөөлж, нийгмээс тусгаарлаад хаячихсан. Ард түмэн нь Та бол ноён, юу ч битгий хий гээд. Эцэст нь Манж үндэстэн мөхсөн.

Нөгөө үндэстэн нь америкын индианчууд. Өмнө нь америкчууд индианчуудтай дайтаж, газар нутгийг нь булааж авсан гэхэд болно. Тэр гэмээ цайруулахаар америкчууд өдгөө сар бүр тэдэнд бэлэн мөнгө ихээр өгдөг. 2000 оны үед сард 700 орчим ам.доллар тэдэнд зүгээр өгдөг байсан. Гэтэл гэмээ цайруулах гэсэн уг оролдлого индианчуудыг жинхэнэ сүйрэл рүү түлхсэн байна. Хөлсөө дуслуулж олоогүй мөнгө яагаад ч үнэ цэнэтэй байж чадахгүй. Тиймээс зүгээр суугаад сар бүр цалин авдаг хүмүүс муу зүйлд орохдоо амархан болдог байна. Индианчууд архи уух, хар тамхи зөөхөөс эхлээд муу зүг рүү амархан яваад өгсөн байдаг. Товчхондоо ямар ч хөдөлмөрлөх сонирхолгүй болсон байна. Тэр хирээрээ хүн мөхдөг. Тэгэхээр манай төр, засаг энэ тал дээр анхаарч, ард түмнээ хөдөлмөрлөдөг, тэмцдэг болгох хэрэгтэй. Өнөөдрөөс л энэ тал дээр анхаарахгүй бол ирээдүйд дэлхийн түүхэнд гурван үндэстэн их муухай мөхөж алга болсон юм гээд Монголын талаар ярих вий дээ. Өнөөдрийн ийм байдал муу жишээний ▶

► нэг болж магадгүй болоод байна. 21 мянган төгрөг, хувьцаа гээд л ард түмэн зүгээр сууж байгаад л баяжих ухааны юм ярьдаг боллоо. Үүнийг зогсоох хэрэгтэй. Харин ч бүгд улсдаа татвар төлдөг больё.

**Б.Г:** -Энэ мэт савалгаа бол улс төр юм. Харин бид төр улс гэдгээ мэдэхгүй байна. Улс төр нь Монгол ухаан биш. Өнөөдрийн энэ мэт жижиг сажиг улс төрийн шуурганд Монгол төр ганхаж л болохгүй. Тиймээс монгол хүн бүр хариуцлагатай байх хэрэгтэй. Монгол Улс ганцаараа дэлхий дээр байсан бол яах вэ. Гэтэл бидний эргэн тойронд өөрийн ард түмнээ сайхан амьдруулах, ашиг сонирхлоо биелүүлэх гэсэн хэдэн зуун улс үндэстэн байна шүү дээ.

**Д.Ж:** -Ганболд захирлын хэлсэнчлэн бидний эргэн тойронд өөр өөрийн ашиг сонирхол бүхий орнууд бий. Гэхдээ бид монгол ухаанаар буюу тулгын гурван чулуу гэдгээр нь авч үзвэл бидний мөнхийн хоёр хөрш, мөн гурав дахь хөршийн харьцааг энэ тэнцүү байлгах хэрэгтэй. Дан ганц гурав дахь хөрш гэж хошуураад байвал тулгын гурван чулууны нэг нь хэт овойгоод тогоо тогтохгүй шүү дээ.

**-Гадаад бодлогын тулгын гурван чулууны талаар Та юу хэлэх вэ?**

**Б.Г:** -Манай улс өдгөө хүртэл оршин тогтносон нь гаднын орнуудтай эв зүйгээ олж чаддаг байсны баталгаа. Энэ уламжлалаа цаашдаа авч явах ёстой. Мөн Жаргалсайхан захирлын хэлсэнчлэн хөрш орнуудтайгаа зөв бодлого явуулах хэрэгтэй. Хамгийн гол нь тэнцвэртэй, идэвхтэй байх нь чухал. Улс төрийн хувьд их мэдрэмжтэй ханддаг байх ёстой. Дотооддоо л бужигналдаад байж болохгүй. Гадаад ертөнцөд юу болж байгааг сайн мэдэх хэрэгтэй. Дээрээс нь тууштай байх нь чухал юм даа.

**-УИХ-ын сонгууль болж өнгөрлөө. Тиймээс улстөрчдөд хандаж юу хэлэх вэ?**

**Д.Ж:** -Өнөөдөр манай улстөрчид нэг л далд, нууцлагдмал байдлаар хууль баталчихдаг болж. Баталсан хуулиар нь нийгмийн ямар нэг харилцаа зохицуулагддаг. Тиймээс олон нийтийн эрх ашигт нийцсэн байх хэрэгтэй. Гэтэл хууль бүрингэжнийцэж чадаж байна уу гэдэгт анхаарал хандуулаасай. Нийцүүлэхийн тулд

яах вэ гэвэл ил тод нээлттэй байх учиртай юм. Хууль, дүрэм батлахдаа олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг хийдэг байгаасай. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэдэг.

Засгийн газар аль болох ил тод нээлттэй болох нь чухал байна. Өнөөдөр манай УИХ-ын гишүүд нэг л их урт нэртэй хуулиуд санаачилдаг. Нэрийг нь хэлэхэд ч бэрх. Харин гаднын оронд нэг сайхан зүйл байна. Тухайн хуулийг санаачилсан хүнийх нь нэрээр нэрлэдэг. Хэрвээ сайн хууль санаачилбал нэр нь сайнаар дуурсагдана. Харин муу хууль бол санаачилсан гишүүнийхээ нэрээр мөнхөрдөг. Нэр төрдөө хайртай хүн

сайн хууль батална шүү дээ. Тиймээс энэ мэт зүйлийг гаднаас авах нь юуны буруу байх билээ.

**А.А:** -Ямар ард түмэн байна тийм л төр улс байдаг гэдэг дээ. Өнөөдөр манай ард түмэн жаахан бэлэн юманд дуртай байгаа учраас л улстөрчид уг үзэл бодол дээр тоглож, амлалт өгөөд байна. Тиймээс эхлээд ард түмэн боловсролтой, мэдлэгтэй болох хэрэгтэй. Тэгж байж л улс төр эрүүлжих байх. Бурхан гарч ирээд хүн бүрийг мундаг болгож чадахгүйгээс хойш, цаг хугацаа л өнөөгийн улстөрчдийн ухамсаргүй байдлыг засах байх.

**Б.Г:** -Улстөрчдийг ухамсартай болгох гол арга нь нээлттэй нийгэм ►



Урьд нь улс төрийн аргаар уусгах бодлого барьдаг байсан бол өнөөдөр эдийн засгаар нь эзлэн түрэмгийлэх бодлого явуулж байна.

## Ирээдүйд дэлхийн түүхэнд гурван үндэстэн их муухай мөхөж алга болсон гээд Монголын талаар ярих вий дээ

► юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үнэн бодит мэдээллийг ил тод өгч чадах л юм бол ард түмэн, улстөрчид боловсордог жамтай. Бодит мэдээллийг ард түмэнд хүргэж чадвал тэд зөв сонголт хийнэ. Нээлттэй нийгмээр дамжуулж ард иргэд, улстөрчдийн сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй. Адаглаад танай сэтгүүлээс үлгэр жишээ авч, монгол сэтгэлгээний талаар бичдэг болмоор байна.

**А.А:** -Өнөөдөр ард түмэн бас ч ухаалаг сонголт хийчих шиг боллоо. Ардчилсан нам яагаад туг тойрсон гэхээр ард түмэнд авлига гээч зүйлийг алга болгоно гэж амласан. Энэ амлалт л ард, иргэдэд таалагдах шиг болсон. Авлига өгснийг нь биш авсныг нь шийтгэх тогтолцоо ухаалаг амлалт байж чадсан юм болов уу. Өгөөд байгаа хүн хэзээ нэгэн цагт илчлэгдэж л таараа шүү дээ. Харин аваад байгаа хүн авсан гэж хэзээ ч хэлэхгүй. Тиймээс энэ удаа Ардчилсан нам зөв зорилго, түүндээ хүрэх зөв арга замыг олсон. Мөн УИХ-ын гишүүдийн цалин мөнгө, орлого зарлагыг нээлттэй болгоно гэсэн. Энэ нь үнэхээр зөв. Хэрвээ нэг сайд мундаг том жийп машин аваад уначихвал ямар мөнгөөр авч унасан нь ил тод байж л дээ. Дээрээс нь тендерийг ил тод болгох хэрэгтэй. Аль нэг том даргын хадам, хамаатан садан тендер аваад байна уу, үгүй юу. Үүнийг л бид мэддэг баймаар байна. Ардчилсан нам энэ мэт байдлыг ил болгох амлалт өгсөн учраас ард түмэн тэднийг сонгосон. Одоо амлалтаа хэрхэн биелүүлэхийг нь харах л үлдлээ.

**-Гаднын туршлага гэж бид их ярьдаг. Аль улсын хөгжлийг өөрийн орны хөрсөнд буулгах вэ гэж дээр дооргүй ярьж байна. Гэвч дорвитой хэрэгжсэн арга хэмжээ алга. Ер нь аль улсын хөгжлийн загвар бидэнд илүү ойр байх бол?**

**Д.Ж:** -Яг Монголтой адилхан улс гэж байхгүй. Тиймээс бид Монгол Улсын хөгжлийн загварыг монгол сэтгэхүйгээр л бий болгоно.

Манайхаас өөр хаана нүүдэлчин соёлтой, ийм том газар нутагтай, хүн ам нь сийрэг суурьшсан ард түмэн байна. Биднээс өөр их газрын, энэ том хоёр хөршийн дунд оршин тогтнодог улс хаана байна. Тиймээс өөрсдөө л хөгжлийн загварыг бий болгох хэрэгтэй. Гэхдээ зарим нэг харилцааг зохицуулахад гаднын туршлагыг авах нь зүйн хэрэг. Тухайлбал, хувьцаат компанийн тухай янз бүрийн зүйлийг гаднын туршлагаас авах л учиртай. Монголоороо байна гээд манайд энэ төрлийн ойлголт байхгүй гээд суугаад байж болохгүй. Энэ чинь хүн төрөлхтний ололт байхгүй юу.

**А.А:** -Өөр хаана ч байхгүй жинхэнэ улстөрчид Монголд байсан юм болов уу гэж хувьдаа боддог. Мөхвөл мөхөхөөр болсон ш дээ, монгол үндэстэн. Удирдагчид нь ухаантай байсан тулдаа л өнөөдөр Монгол Улс байж байна. Байлдуулахыг нь байлдуулаад, алдахаа алдаад, онохоо оносон. Гэхдээ л улс гүрнээ аварч үлдэж чадсан. Харин өнөөдөр бидний өмнө шинэ цагийн Монголоо аврах тийм шаардлага гарч ирээд байна. Урьд нь улс төрийн аргаар уусгах бодлого барьдаг байсан бол өнөөдөр эдийн засгаар нь эзлэн түрэмгийлэх бодлого явуулж байна. Тиймээс улстөрчид их л ухаантай байхгүй бол чимээгүй явж байгаад л Монгол Улс үгүй болчих вий дээ.

**Д.Ж:** -Улс орны хөгжил нь ард иргэдийн хүсэл сонирхол дээр тогтох учиртай. Ард иргэдийн дунд судалгаа хиймээр байна. Залуучууд нь юу мөрөөддөг, хөгшчүүл нь юу хүсэж байна гээд л. Бүр тал бүрээс нь судлаад, дараа нь юу хэрэгтэй вэ, юу нь болохгүй байна вэ гэдгийг шийдэх хэрэгтэй. Америкчууд баруун солгойгүй судалгаа хийдэг юм билээ. Дундаж амьдралтай америк хүний мөрөөдөл юу вэ гээд л. Тэгээд л ёстой доллар центээр нь тооцоод гаргаад ирнэ. Орост хүртэл шинэ орос хүн гэж хэн бэ гэдэг судалгаа хийдэг.

**-Өнөөдөр бид магадгүй хөгжлийн шинэ сэдвээр ярилцлаа. Их**

**сонирхолтой сайхан хэлэлцүүлэг болж өнгөрлөө. Ингээд Та бүгдийн сэтгэгдийг сонсоод хэлэлцүүлгээ өндөрлөе.**

**Б.Г:** -Бэлэнчлэх сэтгэлгээ ойлголтыг халах хэрэгтэй байна. Дээрээс нь бид дээр доргүй хариуцлагатай байх хэрэгтэй. Юм их нарийн болж байна шүү дээ. Сонгууль хүртэл их нарийн хууль, заалттай болсон байна. Тиймээс хаа хаанаа өндөр хариуцлагатай байцгаая гэж хэлмээр байна.

**А.А:** -Дараах гурван зүйлийг шинэ засаг хийгээсэй гэж хүсэж байна. Нэгдүгээрт, УИХ-аас хууль баталж байгаад ч хамаагүй энэ олон их, дээд сургуулийг цөөлөөсэй. Дунд сургууль төгсөгчдийн 30 хувь нь их дээд сургуульд ордог, бусад нь өөр мэргэжлээр ажилладаг болоосой. **Хоёрдугаарт**, Монголын ногоон тал экологийн сүйрэлд орох дөхлөө. Тиймээс энэ олон ямааг цөөлөх хэрэгтэй байна. Сахарын цөл уг нь Нил мөрний сав дагуух их үржил шимтэй газар байх ёстой юм. Гэтэл тэнд ямаа их өсгөсний улмаас Сахарын цөл үүссэн гэдэг. Манай уламжлалд малын 10 хувиас ихгүй нь ямаа байсан байдаг. Энэ уламжлалаа сэргээх хэрэгтэй. **Гуравдугаарт**, улс төрөө, улстөрчдөө аврахын тулд бүгдийг ил тод болгомоор байна. Төрийн толгойд очсон хүн бүрийн үйл хөдлөл олны өмнө ил тод байх тогтолцоог бий болгох хэрэгтэй. Бүр гэр бүл нь хүртэл ил тод. Энэ гурвыг л яаралтай хиймээр байх юм.

**Д.Ж:** УИХ-ын гишүүд бүрэн эрхийнхээ үүднээс гэж их ярьдаг. Тэгвэл хаана ч гэсэн эрхийг дагаж үүрэг хариуцлага яддаг. Энэ хоёрын харьцаа алдагдахаар сүйрэл ирдэг. Тиймээс бүрэн эрх гэж байдаг бол гишүүд бүрэн дүүрэн хариуцлагаа ухамсарлах хэрэгтэй. Сэтгүүлчид та бүхэн УИХ-ын гишүүдээс бүрэн хариуцлагыг нэхэх хэрэгтэй. "Mongolian Economy" сэтгүүл том зүйлийн эхлэлийг тавьлаа гэж бодож байна. ■

Ч.ОТГОЧУЛУУГИЙН БУЛАН

## ШИНЭ ЗАСГИЙН ГАЗРЫГ ЯМАР ОРЧИН ХҮЛЭЭЖ БАЙНА ВЭ?

Тэд засгийн нээлттэй бодлого, нам инфляци, улс төрийн тогтвортой орчныг хүсч байна. Бас авлига, хүнд суртлаас ангид байх эрх чөлөөг хүсч байгаа нь олон судалгаанаас харагдаж байна.



2012 оны сонгуулийн дүнд байгуулагдсан УИХ бүрдээд удаагүй байна. Ямартаа ч эвслийн Засгийн газар бүрдэх нь тодорхой. Тэгвэл шинэ ЗГ-ыг ямар орчин хүлээж байна вэ?

Тангаргаа өргөсөн гишүүд болон намуудын авсан суудлын харьцааг үзвэл эрээвэр хураавар танхимтай боллоо. Сайдын суудлын төлөө нам, бүлэг хоорондын тэмцэлтэй жилүүд ирэх магадлал өндөр. Товчхондоо хэлэхэд тогтворгүй орчин хүлээж байна.

Макро эдийн засгийн хувьд ч тогтворгүй гэхэд багадаа харьцааг үзвэл эрээвэр хураавар танхимтай боллоо. Сайдын суудлын төлөө нам, бүлэг хоорондын тэмцэлтэй жилүүд ирэх магадлал өндөр. Товчхондоо хэлэхэд тогтворгүй орчин хүлээж байна.

Макро эдийн засгийн хувьд ч тогтворгүй гэхэд багадаа харьцааг үзвэл эрээвэр хураавар танхимтай боллоо. Сайдын суудлын төлөө нам, бүлэг хоорондын тэмцэлтэй жилүүд ирэх магадлал өндөр. Товчхондоо хэлэхэд тогтворгүй орчин хүлээж байна.

Төсвийн алдагдал 405 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд улмаар цаашид ч өсч, нийт эдийн засгийн дөрвөөс таван хувьд хүрч очих магадлалтай. Эхний таван сарын байдлаар гадаад худалдааны алдагдал 1.2 их наяд төгрөгийг давжээ. Эдийн засгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний энэ алдагдал өсч, өнгөрсөн жилийн дээд амжилтыг эвдэх шинжтэй боллоо. Төсвийн болон гадаад худалдааны хос алдагдал нь төгрөгийн ханшид сөргөөр нөлөөлөх нь тодорхой.

Гадаад орчин ч эрсдэлтэй хэвээр. Европын өрийн хямрал дэлхий нийтэд нөлөөлж, ялангуяа манай түүхий эдийн гол худалдан авагч Хятадын эдийн засгийн өсөлт саарах нь Монгол Улсын экспортод ч сөргөөр нөлөөлнө. Манай экспортын орлогын 91 хувь нь зэс нүүрс хоёроос бүрдэх болж, 2008 онтой харьцуулахад нэг худалдан авагчаас хараат байдал эрс өсчээ.

Ямар ч засаг гарсан их л хүнд төсөв, эдийн засаг

хүлээж авч байна. Шинэ засгийн газар ийнхүү өмнөх засгийн газруудынхаа сонгууль угтсан төсөв, мөнгөний хэт тэлэх бодлогоос үүдэлтэй инфляцитай тэмцэх, мөн Хятадын эдийн засгийн болзошгүй хөрөлтөөс үүсч болох экспортын уналтаас хамааран бүсээ ихээхэн чангалах шаардлагатай тулж болзошгүй.

Макро орчны дээрх гажуудлуудыг засахаас гадна уул уурхайн бус салбарт ажлын байрыг олноор бий болгох шаардлагатай. Гэхдээ эдгээр ажлын байр нь өмнөх Засгийн газруудынх шиг нэг удаагийн кампанит арга хэмжээгээр биш, харин хувийн хэвшлийнхний урт хугацаат хөрөнгө оруулалтын үр дүнд бий болж байж тогтвортой байх болно. Хувийн хэвшлийнхэн шинэ Засгийн газраас юу хүсч байна вэ? Тэд засгийн нээлттэй бодлого, нам инфляци, улс төрийн тогтвортой орчныг хүсч байна. Бас авлига, хүнд суртлаас ангид байх эрх чөлөөг хүсч байгаа нь олон судалгаанаас харагдаж байна. Бизнесийн таатай орчны үзүүлэлтээр бид 2005 оны хэмжилтээр дэлхийн улс орнуудаас эхний 41-д байсан бол 2010 онд 72-р байр руу гулчсээ. Харин хамгийн сүүлийн байдлаар дахин ухарч 86-д орчихсон явна.

Авлигын үзүүлэлтээр 2005 онд 85-д байснаа 2010 онд 116-д орох болсон. Одоо дахиж ухраад 120-д орчихсон л байна. Төрийн хүнд суртал, авлига ихэссэн учир Монгол Улс эдийн засгийн эрх чөлөөгөөр долоон жилийн өмнө 43-т ордог байсан бол 2010 онд 88 болж ухарчээ. Хувийнханд учирч буй өөр нэг бэрхшээл нь зээлийн олдоц хомс байгаатай холбоотой юм. Өдийд ихэнх бизнес зээлээ авч, хөрөнгө оруулалтаа хийчихсэн байдаг. Гэтэл сонгуулийн амлалт-төсвийн хэт тэлэлт-өндөр инфляци-бодлогын өндөр хүү гэсэн гинжин цагиргаас болж, банкууд зээл олголтоо сааруулж байна.

Уул уурхайн бус салбарынханд учирч буй өөр нэг бэрхшээл нь авьяаслаг хүмүүсээ баян уул уурхайн компаниудад алдахгүйн тулд цалингаа эрс өсгөх ▶▶

## АСУУДАЛ

## ДАЛД ЭДИЙН ЗАСАГ 76-Д Ч ХАМААТАЙ

“Далд эдийн засгийг бууруулахын төлөө, авлига, хүнд суртлын эсрэг төр, төрд ажиллаж буй хүмүүс баттай зогсох итгэл үнэмшилтэй байх учиртай” хэмээн Улсын дээд шүүхийн судалгааны төвийн ахлах шинжээч Б.Айбек хэллээ.


## Б.АЛТАЙ

Төр түмнийхээ төлөө андгай, тангараг өргөсөн гишүүд эдийн засгийн өсөлтийг онцлохоос гадна далд эдийн засагт ч хяналт тавих ёстой. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өндөр өсөлт, хөгжлийн хурдаа манайх цаашид хадгалж үлдэхийн тулд далд эдийн засаг буюу сүүдрийн эдийн засагт анхаарал хандуулах цаг болсныг “Далд эдийн засгийг ил болгох, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх” улсын зөвлөлгөөний оролцогчид хэлж байлаа. Дэлхийн улс орнууд сүүдрийн эдийн засгийн хохирлыг өнгөрсөн хугацаанд чамгүй хүртсэн төдийгүй эдийн засгийн гэмт хэрэгтэй өнөөг хүртэл тэмцсээр ирсэн. Тухайлбал, Япон улс 1980-аад оны үеийн санхүүгийн зах зээлийн хууль бус үйл ажиллагааны улмаас 500 тэрбум ам.долларын алдагдал хүлээсэн нь бий. Тэгвэл АНУ 160 тэрбум ам.долларын алдагдал хүлээж, эдийн засагтаа сэвтэй үлджээ.

Далд эдийн засгаас хамгаалах хууль эрх зүйн орчин тухайн үед сул хөгжсөн, хувийн ашиг сонирхол давамгайлсан учраас дээрх улсууд гар мухардсан нь энэ. Манай улсын хувьд сүүдрийн эдийн засгийн нөлөөг багасгах, хууль эрх зүйн орчинг сайжруулах зүй ёсны шаардлагатай нүүр тулж байна. Тиймээс УИХ-ын гишүүд эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх, далд эдийн засгийн эсрэг хууль эрх зүйн орчныг бататгахад анхаарах цаг болжээ. Энэ хүрээнд “Далд эдийн засгийг ил болгох, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний

дунд хугацааны стратегийн бодлогын баримт бичиг” боловсруулах үндэсний дунд хугацааны төлөвлөгөөг УИХ-ын тогтоолоор батлах хэрэгтэй гэж улсын зөвлөлгөөний үеэр тэмдэглэж байв.

Манай улсын хувьд дээр өгүүлсэн ихээхэн хэмжээний алдагдал хүлээж, эдийн засагтаа толбо суулгаагүй ч далд эдийн засгийн чанартай гэмт хэрэг хэд хэд бүртгэгджээ. Тодруулбал “Татварын байгууллагын нэхэмжлэлтэй нийт өрийн 94 хувийг өндөр үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичиг эзэлж байна” гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга, хурандаа Х.Энхбаатар ярилаа. Тэрээр “Төлбөр төлөгч хуулийн этгээд нь он удаан жил үйл ажиллагаа явуулаагүй, төлбөрт гаргуулах эд хөрөнгөгүй, төлбөрийн чадваргүй, төлбөр төлөхөөс санаатайгаар зайлсхийх, эд хөрөнгөө бусдад барьцаалах, шилжүүлэх, битүүмжилсэн эд хөрөнгийг гүрэгдүүлэх, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн харилцах дансны талаарх мэдээллийг арилжааны банк ирүүлэхгүй байх, татвар төлөгч хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлгүй, үүсгэн байгуулагч /захирал/ нар гэрийн хаягаар хуулийн этгээд үүсгэсэн, оршин суух тодорхой хаяггүй, зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хуульд заасан албадлагын арга хэмжээ зохих үр дүнд хүрэхгүй байна” гэж тайлбарласан юм. ▶



▶ шаардлагатай болж байна. Бензин, дизель гэх зэрэг нь ч уул уурхайн огцом эрэлтийн ачаар “үнэд орж” байна. Бензиний үнийн өсөлт бусад бараа, үйлчилгээний үнийг өсгөж байна. Өөрөөр хэлбэл, ханшийн өндөр хэлбэлзэл, хүний нөөцийн шилжилт гэх зэргээр Голланд өвчинд нэрвэгдэж буй эдийн засгийг шинэ засаг хүлээн авч байна.

Чөлөөт зах зээлийн тогтолцоог бэхжүүлэхийн зэрэгцээ, баян хоосны ялгааг арилгах, дундаж давхаргыг дэмжих замаар иргэний нийгмийг байгуулах гэсэн урт хугацааны зорилгод хүрэхийн тулд боловсрол, дэд бүтцэд хөрөнгө оруулалтыг зэгсэн нэмэгдүүлэх шаардлагатай. Ийм учир шинэ Засгийн газар тулга тойрсон хэрүүл, бүлэг фракциудад эрх мэдэл хуваарилах гэсэн аар саар зүйлтэй ноцолдсоор хугацаа алдах ёсгүй. Учир нь сонгуулиар өвчилж, уул уурхайгаар халуурсан эдийн засгийн өнөөгийн согог улам даамжирвал Монголын ирээдүйд маш ноцтой хохирол учрах болно. Эдгээр сорилт, бэрхшээлээс гадна уул уурхайгаас орох орлогыг зөв удирдахын зэрэгцээ, уул уурхайн бус салбаруудад эдийн засгийн эрх чөлөөг олгож чадвал эдийн засгийн бодитой, тогтвортой хөгжлийн суурийг тавих түүхэн боломж байна. ■

## ► Гэнэт цадах гэдсэнд халтай

Дэлхийн улс орнуудын тухайн эдийн засагт эзлэх далд эдийн засгийн хэмжээг 1999-2006 болон 2007 оны байдлаар тооцон гаргажээ. Манай улсын хувьд ДНБ-д эзлэх далд эдийн засаг дунджаар 17.9 хувьтай гарчээ. 1999 онд 18.2 хувьтай байсан энэ үзүүлэлт 17.9 хувь болж буурсан харагдаж байна. Гэхдээ далд эдийн засаг манай улсад бага хувь эзэлдэг гэж ойлгож болохгүй юм. Тоон үзүүлэлт бага байх тусмаа эрсдэлтэй талаар эдийн засагчид ярьдаг. Гаалийн татвараас зайлсхийх, орлогоо нуух, хүнд суртал гаргах, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах, хувийн эрх ашиг сонирхолдоо хөтлөгдөн олон нийтийн өмчийг шамшигдуулах, бусдыг хохироох нь далд эдийн засагт багтдаг ойлголтууд. “Эдийн засгийн гэмт хэргийг дотор нь цагаан захтны болон цэнхэр захтны гэмт хэрэг гэж хоёр ангилдаг. Цагаан захтны гэмт хэргийг нийгмийн дээд зиндаанд хамаарах, өндөр зэрэглэлийн албан тушаал, эрх мэдэл бүхий цагаан захтай цамц өссөн баян чинээлэг хүмүүс үйлддэг бөгөөд энэ нэр томъёог 1939 онд АНУ-ын социологич Эдвин Сюдэрланд гаргаж ирсэн” хэмээн Хууль зүйн үндэсний Хүрээлэнгийн хуульч Б.Одонгэрэл хэллээ.

Далд буюу сүүдрийн эдийн засгийг албан бус, нуугдмал, сүүдрийн, паралель, саарал, хар гэх мэт олон янзаар нэрлэдэг. Эдгээрээс хамгийн түгээмэл нь далд эдийн засаг гэсэн ойлголт гэж Б.Одонгэрэл тайлбарласан. Монголчууд далд эдийн засаг гэсэн нэр томъёог нь түгээмэл хэрэглэсээр иржээ. Италийн мафи Америкийн эдийн засагт нэвтэрч, хүрээгээ тэлж эхэлсэн 1930-аад оны үед далд эдийн засаг гэсэн ойлголт анх гарч ирсэн бөгөөд энэ үеэс улс орны хэмжээний эдийн засгийн асуудал болон хувирч, 1970 оноос эдийн засагчдын анхааралд өртөх болжээ. Энэхүү нэр томъёо «Schattenwirtschaft» гэдэг Герман үгнээс гаралтай өргөн хэмжээний ойлголт төдийгүй албан ёсны бүртгэл тооцоонд ороогүй, хууль журмаас гадуур, хууль ёсыг хөсөрдүүлсэн эдийн засгийн бүхий л харилцааг багтаадаг байна. Мөн дотоодын нийт бүтээгдэхүүний тооцонд хамрагдаагүй хэсгийг бүртгэгдээгүй эдийн засаг буюу далд эдийн засаг гэж тодорхойлдог аж.

Далд эдийн засгийн хэлбэрүүд нь үйлдвэр аж ахуйн газрыг нуух /тодорхой аж ахуйг бүртгэлгүйгээр зохион байгуулж эрхлэх/, аж ахуйн үйл ажиллагааг нуух /эдгээр үйл ажиллагааг гэрээ болон тайландаа тусгахгүй байх/, ажиллах хүчийг хөлсөлснөө нуух /хөдөлмөрийн гэрээгүйгээр хүн хөлслөн ажиллуулах/, ашиг орлогоо нуух /татвараас зайлсхийх/ зэрэг ордог юм байна.

## Төр баттай зогсох уу

“Далд эдийн засгийг бууруулахын төлөө, авлига, хүнд суртлын эсрэг төр, төрд ажиллаж буй хүмүүс баттай зогсох итгэл үнэмшилтэй байх учиртай” хэмээн Улсын дээд шүүхийн судалгааны төвийн ахлах шинжээч Б.Айбек хэллээ. Далд эдийн засгийг бууруулахаар бизнесийн орчныг сайжруулах, эрх зүйн болон аж ахуй эрхлэлтийн нөхцлийг боловсронгуй болгох, татварын бодлого, эдийн



Шоо зурагийг А.Амарсайхан

засгийн гадаад хамтын ажиллагаа зэргийг эргэж харах, хууль хэрэгжүүлэх заавар, журам, дүрмийг боловсронгуй болгох, тоог цөөрүүлэх, иргэд, аж ахуй бизнес эрхлэгчдийг хуулийн хүрээнд бизнес эрхэлж байгаа эсэхэд нийгмийн хяналтыг сайжруулах зэрэг асуудлыг хамруулахыг Татварын ерөнхий газрын дарга Б.Баттөмөр учирласан. Далд эдийн засагтай тэмцэх нь тус газрын үүрэг гэж хэлж болно. Учир нь далд эдийн засгийг хэмжих, түүнийг хянах эрх үүрэг тэдэнд олгогджээ.

ТЕГ-аас олон нийтэд үзүүлэх үйлчилгээг татвар төлөгчдийг хууль дүрмээ биелүүлэх, нийт ард иргэдэд татвараа сайн дураараа төлөх, үүрэг хариуцлагаа ухамсарлан биелүүлэх нь сайн иргэн хүний шинж чанар гэж ойлгуулахад чиглэсэн үйл ажиллагааг улам эрчимжүүлэх шаардлагатай байгааг ТЕГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга О.Тэнгис онцоллоо. Тэрбээр “Татварын албаны далд эдийн засгийн үйл ажиллагааг таслан зогсоход чиглэсэн гол арга зам бол хариуцлагыг чангатгах, өндөр торгууль, төлбөр төлөх механизмыг бүрдүүлэх шаардлага тулгарч байна” гэсэн юм.

ТЕГ далд эдийн засагтай тэмцэх, татвараас зайлсхийх оролдлогыг олж илрүүлэх, хууль сахиулах үйл ажиллагааг дэмжих, татварын ажилтнуудын боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, тухайн хууль бус үйлдэл хэргийг сонгож илрүүлэх чадвартай чадварлаг ажиллах хүчийг бүрдүүлэхээр ажиллаж байгаа аж.

Мөн далд эдийн засагт үйл ажиллагаа явуулж, төрийн хяналтаас зугтаж, хуулийн дагуу үүрэг хариуцлагаа биелүүлэхээс зайлсхийж байгаа хүмүүсийг тодорхойлох, тэднийг олж илрүүлэх үр дүнтэй үйл ажиллагаанд төрийн бүх байгууллагыг татан оролцуулж, тусгайлсан хөтөлбөр боловсруулахаар болжээ.

Тус хөтөлбөртөө үндэслэлгүй хөрөнгөжих, илт тансаг хэрэглээг илрүүлэх, хяналт тавих, татвар төлөгчийн төлдөг татварын хэмжээ болон тэдний үрэлгэн хэрэглээ, амьдралын боломжтой харьцуулах, татварт бүрэн хамруулах арга хэмжээ авахаар төлөвлөсөн байна. Тухайн иргэний эзэмшиж буй хөрөнгийн хэмжээг татварын орлогын мэдүүлэгтэй нь хэр нийцэж байгааг тодруулан шалгах мэдээллийн цогц системийг бүрдүүлнэ хэмээн татварынхан онцолж байв. ►►

### ▶ Ц.ДАШДОРЖ

*/Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн зөвлөх/*

-Татварын хууль тогтоомж хэчнээн олон төрөл байна, хэчнээн нарийн төвөгтэй болох тусам түүнийг ойлгож, дагаж биелүүлэх хүний тоо цөөрдөг. Европын холбооноос хийсэн судалгаанаас үзэхэд татвар төлөх дарамт нь төлж байгаа мөнгөнөөсөө илүүтэйгээр тухайн татварыг төлөхийн төлөө татвар төлөгчөөс гарч буй зардал, цаг хугацаа, сэтгэлзүй, бусад бэрхшээлийг дагуулдаг гэж үздэг юм билээ. Энэ нь эргээд далд эдийн засаг хөгжих, татвараа төлөхөөс зайлсхийх, орлогоо нуух шалтгаан болж байгаа. Жижиг татвар төлөгчийн хувьд том татвар төлөгчтэй харьцуулахад маш их дарамт мэдэрдэг гэсэн дүгнэлт гаргасан байна билээ. Жижиг татвар төлөгчид хувьд төлж буй татварынхаа 40 орчим хувьтай тэнцэхүйц зардал гаргадаг гэсэн албан бус тоо бий. Тиймээс татварын орчин өөрөө далд эдийн засаг цэцэглэх хөрс болж болохгүй.

### Б.БАТТӨМӨР

*/Татварын ерөнхий газрын дарга/*

-Татвар төлөгчдийн татварын зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, татварын үйлчилгээ, сургалт, сурталчилгаа, татварын мэдээллийн сангийн бүрдэлт, баяжилт, ашиглалт, төлөвлөлт, ногдуулалт, хураалтын чиглэлээр зорилт тавьсан. Монгол Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх боллоцоот эх үүсвэрийг бүрэн дайчлах, далд эдийн засгийн нөлөөллийг багасгах, судлах чиглэлээр 2012 оны эхнээс Татварын ерөнхий газарт далд эдийн засгийг бууруулах үйл ажиллагааг томоохон цогц хэлбэрээр хэрэгжүүлэх тусгай ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

### Б.ДОЛГОРСҮРЭН

*/Санхүүгийн зохицуулах хорооны Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлтсийн дарга/*

-Өндөр татварын дарамт, эдийн засгийн үйл ажиллагааны нарийвчилсан төрийн зохицуулалт, эдийн засаг дахь төрийн өмчийн салбарын хувь хэмжээ хэт өндөр байх, эдийн засагт үндэстэн дамнасан болон даяарчлагдаж байгаа нь далд эдийн засгийг үүсгэгч хүчин зүйлс болдог. Тиймээс манайх далд эдийн засагтай тэмцэх эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай. Нийгэм эдийн засгийн талаар баримталж буй бодлогод өөрчлөлт оруулах/аядуу зөөлөн бодлого баримтлах/, санхүүгийн тайлагналыг үнэн зөв гаргаж өгөх сэтгэл зүйг бий болгох /урамшууллын механизмыг бий болгох/, Татварын шатлалын хувийг эргэн харах, Татварын өршөөлийн асуудал /татварын өршөөлд хамрагдсан эх үүсвэрийг санхүүгийн

салбарт оруулах боломж/-д анхаарал хандуулах цаг болжээ.

Цаашид далд эдийн засгийн бодит байдлыг тодорхойлох, бодитоор хэмжих судалгаа хийх нь зүйтэй. Үндэсний тооцооны тэнцвэрт бус байдлыг арилгах, эдийн засгийг бүрэн хэмжээгээр тодорхойлж чадахуйц тоон мэдээлэлтэй болох нь чухал. Төрийн бодлогод нөлөөлөх хүчин зүйлийг тогтоох, эдийн засгийн нөөцийг хуваарилах, ашиглах, хэмжих, дүгнэх арга аргачлалыг боловсруулах хэрэгтэй.

### Б.ОДОНГЭРЭЛ

*/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хуульч/*

-Цагаан захтны гэмт хэрэгт залилан, татвараас зайлсхийх, авлига, хээл хахууль өгөх, өмч хөрөнгө ашиглан шамшигдуулах, компьютерийн гэмт хэрэг, зохиогчийн эрхийг хууль бусаар ашиглах, мөнгө угаах, таних тэмдэг болон лого хулгайлах, баримт бичиг хууль бусаар хуулбарлах, хөрөнгийн зах зээл, үнэт цаасны залилан, дотоод мэдээллийг худалдах, зах зээлийг төөрөгдүүлэх зэрэг гэмт хэрэг хамаардаг.

### Б.ЛХАГВАЖАВ

*/Монгол Улсын Ерөнхий сайдын*

*Эдийн засгийн сайдын зөвлөх/*


-Манай улсын хувьд далд эдийн засгаа ил болгохоос гадна ил эдийн засгаа нээлттэй, ил тод болгох нь чухал байна. Учир нь уул уурхайн баялаг, түүнийг дагасан хөрөнгө оруулалтын дүнд том эдийн засагтай болох хэтийн ирээдүй манай улсад бий. Тиймээс өнөөг хүртэл ажиллаж ирсэн, ашиглаж байгаа арга, барилаа үндсээр нь өөрчлөх хэрэгтэй. Тэгж байж л эдийн засаг ил болно. 2008 оны Татварын өршөөлийн тухай хуулийн дараа дөрвөн тэрбум ам.доллартай тэнцэх орлогоо 2870 компани ил болгожээ. Тухайн үедээ 2.4 жилийн улсын төсөвтэй тэнцэх хэмжээний мөнгөн далдлал ил болсон юм. 1992-2008 он хүртэл явж ирсэн татварын арга барил, татварын бодлого, татвар авч байгаа хэлбэр, түүнийг хянаж буй эдийн засгийн цагдаагийн алба, авлигатай тэмцэх газар, шүүх зөв ажиллаж чадсан уу гэсэн асуулт гарч ирнэ. Өнөөдөр татварын орлого нэмэгдэж байгаа нь эдийн засгийн амжилт. Гэхдээ орлого олдог л бол татвар төлөх системд шилжих хэрэгтэй. Үүнийг 2013 оноос эрчимтэй хэрэгжүүлэх ёстой. Мөн төртэй холбоотой тендерийн асуудал араасаа маргаан, далд эдийн засгийн шинжийг дагуулдаг. Тендерийг татварын системээр хянана. Энэ бүхэнд шинэчлэл хийх нь зөв. Далд эдийн засаг мөнгөний урсгалыг, өмчийг, эрх мэдэлтэй нөхрийг л дагадаг. Түүнээс гутал тосолж буй хүнийг дагаад байдаг эд биш юм аа. ■

## ТООНЫ ХЭЛЭЭР

Их 20-ын улсуудын албан ёсны ДНБ-нд эзлэх далд эдийн засгийн тооцсон хэмжээ

	2002 он	2003 он	2004 он	2005 он	2006 он	2007 он	Улсын дундаж
АНУ	8.6	8.7	8.8	8.9	8.9	9	8.8
Япон	11.1	11.2	11.5	11.7	12	12.1	11.4
Англи	12.8	12.9	13	13	13.1	13.2	12.9
Хятад	13.3	13.4	13.6	13.7	14	14.3	13.5
Австрали	14.4	14.7	14.8	14.8	14.9	15	14.6
Франц	15.3	15.4	15.5	15.6	15.6	15.7	15.4
Герман	16	15.8	15.9	16	16.4	16.7	16
Канад	16.2	16.3	16.4	16.5	16.6	16.6	16.3
Саудын Араб	17.5	18.5	19.1	19.4	19.5	20	18.7
Индонези	19.5	19.7	20	20.2	20.5	20.9	19.9
Энэтхэг	23.6	24	24.2	24.5	25	25.6	24
Аргентин	23.3	24.4	25.3	26.1	27	27.8	25.5
Итали	27.4	27.2	27.2	27.1	27.3	27.4	27.2
Өмнөд Солонгос	28.1	28.2	28.5	28.7	29	29.4	28.2
Мексик	29.9	29.7	30.1	30.3	31	31.3	30.2
Турк	31.8	32.4	33.2	34.2	34.7	35.2	33
Бразил	39.7	40	40.9	41.1	41.8	43	40.5
Орос	47.8	48.8	49.5	50.1	50.8	52	48.6

Далд эдийн засгийн дундаж хэмжээ




Баруун орнуудын далд эдийн засгийн ДНБ-нд эзлэх хувь




Монгол Улсын хөгжлийн өнөөгийн түвшин



Латин Америкийн орнуудаас далд эдийн засгийн хэмжээ хамгийн их орнууд



Азийн орнуудын далд эдийн засгийн ДНБ-нд эзлэх хувь



Эдийн засгийн өсөлтийн гол үзүүлэлтүүд

	006	2007	2008	2009	2010	2011
ДНБ, тэрбум төгрөг	4,027.6	4,956.6	6,555.6	6,590.6	8,414.5	10,829.7
Эдийн засгийн бодит өсөлт	8.6	10.2	8.9	-1.3	6.4	17.3
Ашигт малтмалын салбарын өсөлт	5.3	1.1	-1.6	5.8	3.6	8.7
Ашигт малтмалын бус салбарын өсөлт	9.4	12.6	11.3	-2.7	7.0	19.1
Нэг хүнд ногдох ДНБ, ам.доллар	1324.2	1,619.5	2,108.3	1,688.1	2,264.4	3,073.0

Эх сурвалж: Татварийн ерөнхий газар,  
Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо

## МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ҮГ

Магадгүй ирэх есдүгээр сард улсын төсөвт тодотгол хийнэ байх. Дөнгөж байгуулагдаж буй Засгийн газар, УИХ амлалт биелүүлэхээс илүүтэй хариуцлага бодож, төсөвт тодотгол оруулна гэж харж байна. Зарлагаа нэмнэ гэхээсээ илүүтэй, танасан байдлаар төсөвт хандах болов уу.



## Ц.БАТСҮХ: ӨРХИЙН ТӨСӨВТ ХЭТ АНХААРВАЛ УЛСЫН ТӨСӨВТЭЙГЭЭ ХАМТ “ШОРООДНО” ШҮҮ

### Б.ТОГТОХ

*СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч Ц.Батсүхтэй ярилцлаа.*

**-Эдийн засгийн хөгжлийг залах шинэ Засгийн газар ирэх дөрвөн жилд ямар бэрхшээлтэй нүүр тулах бол. Ер нь манай улсын эдийн засгийн эрүүл мэнд ямар байна вэ?**

-Монголд макро эдийн засгийн тогтвортой бодлого алга. Бодлого байхгүй учраас л эдийн засгийг эрүүл гэж оношлоход хүндрэлтэй. Нэг үгээр хэлбэл, бодлогогүй эдийн засаг урагшаа мөлхөж байна. Намууд өнгөрсөн 2008 оны сонгуулиар өгсөн амлалтаа биелүүлэхийн тулд эдийн засгийн өчүүхэн амжилтаа тавиад туучихлаа. Хэлбэр талаасаа сонгуулийн амлалт биелсэн. Гэхдээ, үр өгөөжтэй, бодитой эдийн засгийн өсөлт байсангүй. Өнөөдөр амлалтаа биелүүлсэн мэт өнгөн дээрээ харагдавч асар их өрийг хойч үедээ, дараагийн Засгийн газарт, Монголын эдийн засагт үлдээлээ. Магадгүй, улстөрчид өөрсдийнхөө юу хийснээ,

юуг үгүйсгэн байж үр дүнд нь эдийн засагт ямар том хохирол авчирсан болохоо хожим ойлгох болов уу. Мэдээж, үлдэж буй өрийг нь татвар төлөгч бид л төлнө.

**-Өнгөрсөн онд гарсан эдийн засгийн өсөлтөө энэ оны төгсгөлд хадгалж чадах болов уу?**

-Сонгуулийн өмнө бодит эдийн засгийн үйлдвэрлэл ахицтай байдаггүй. Ер нь сонгууль болсон тухайн жилийн эдийн засгийн нөхцөл байдлыг харахаар өсөлт нь өндөр бус харин ч эсрэгээрээ. Бодит үйлдвэрлэл буурдаг тул төсөвт орж ирэх мөнгөний хэмжээ багасдаг. Шинэ Засгийн газрын хувьд нэлээд хүнд төсвийг хүлээж авах болов уу. Шинэ Засгийн газар баяр наадам, намар гэж хойшлуулахгүйгээр мөрийн хөтөлбөрөө тодотгож, эдийн засгаа засахад анхаарч ажиллаж эхлэх шаардлагатай. Нэг үгээр хэлбэл, Засгийн газар эдийн засгийн өсөлтөө хамгаалж, төсвийн орлогоо бүрдүүлэхийн тулд амрах эрхгүй ажиллах хэрэгтэй. Сонгуулийн

дараа эдийн засгийн өсөлт буурсан байдаг. Тиймээс нийлүүлэлтийн талын бодлогыг дэмжих хэрэгтэй. Өнгөрсөн хугацаанд нийлүүлэлтийн бодлогыг орхигдуулсан шүү дээ. Жишээ нь, ирэх дөрвөн жилд дөрвөн томоохон үйлдвэр шинээр барих хэрэгтэй. Тэр үйлдвэрт нь 400 хүн ажилд орвол энэ бодит өсөлт болно. Мөн сангийн үр ашигтай, үр дүнтэй бодлого үгүйлэгдэж байна. Тиймээс уул уурхайгаас орох татварын орлогоо тодорхой санд хуримтлуулж, түүгээрээ бусад үйлдвэрлэлийн салбартаа хөрөнгө оруулж, дэмжих хэрэгтэй байна.

**-Өнөөдөр тооцож үзээгүй ямар эрсдэл байна вэ?**

-Инфляцийн одоогийн түвшин, эдийн засгийн халалтыг үзэхээр манай эдийн засаг бат бөх суурьгүй юм байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн оны эдийн засгийн өсөлт бодитой бус, чанаргүй тоон өсөлт байсан гэж хэлж болно. Үнэхээр бодитой, баталгаатай байсан бол өдийд бид ▶

## Инфляцийг үндэс суурьтай нь устгая гэвэл...

▶ тэвдэхгүй шүү дээ. Нэг ёсондоо бат суурьгүй, өнгөц төдий өсөлт байсан нь өнөөдөр батлагдаж байна. Цаашдаа энэ байдал макро эдийн засгийн бодлогод асар том нөлөө үзүүлнэ. Эдийн засагт их эрсдэлийг дагуулах шинж ч харагдаж байна.

### -Тухайлбал, макро эдийн засагт ямар нөлөө үзүүлэх бол?

-Төсвийн орлого багасахаар одоогийн хэрэгжиж буй татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах байх. Уг нь татварын нэг шатлалт тогтолцоо хамгийн зөв зүйл рүү биднийг хөтөлсөн гэж боддог. Нийт татвар төлөгчдийг ямар ч ялгаварлалгүй болгож, тэгш татварын тогтолцоо үйлчилсэн. Гэтэл одоо их орлоготойгоос нь их татвар, бага орлоготойгоос нь бага татвар авна гэсэн шатлал бүхий ялгааг гаргаж ирэхээр ярьж байгаа нь макро эдийн засагт нөлөөлнө.

Өнгөрсөн үед орлогын хэмжээгээр шатлалтай өсөн нэмэгдэх татвар тогтоосноос болоод аж ахуй нэгжүүд жижгэрсэн. Ихэнх том аж ахуй нэгж бага татвар төлөх гэж нэг компани л гэхэд 10 жижиг аж ахуй нэгж болон хувирсан. Нэг талаасаа энэ нь аж ахуйн нэгжийн хүчийг сулруулсан бодлого болсон.

Харин өнөөдөр адилхан том жижиг гэлтгүй ижил түвшний татвар ногдуулж байна. Бүгдэд нь 10 хувийн орлогын татвар тавихад бага орлоготой иргэний татвар бага л байна гэсэн үг. Их орлоготой их нь их төлнө. Гэтэл одоогийн яриад буй их, багын татвар эцэстээ эдийн засагт далд эдийн засаг хөгжих үндсэн шалтаг бодлогыг үгүйсгэх аргагүй. Мэдээж, төсвийн орлоготой болоод ирэхээр хуульд өөрчлөлт оруулж мэднэ. Энэ нь эдийн засгийн суурийг ганхуулахад том нөлөө болно.

### -Тэгвэл эдийн засгийн эрсдэл нь юу вэ?

-Бид "Их өр" гэдэг шиг их өртэй болж хувирлаа. Энэ өрийг бид л төлж таарна. Улсын эрсдэл гэж байдаг. Засгийн газрын өрийн тодорхой хувь нэмэгдэж байна. Энэ утгаар нь авч үзвэл, олон улсын рейтинг тогтоодог компаниуд манай улсын эрсдэлийн түвшинг буулгах мэдээ хийж

болзошгүй. Нэг үгээр хэлбэл, Монгол Улсын зээлжих эрхийг буулгаж мэднэ. Буулгасан тохиолдолд эрсдэл гарна. Энэ нь олон улсын зах зээлд бонд гаргаж хөрөнгө босгох Хөгжлийн банкны зорилтыг үгүй хийж ч болох юм.

### -Магадгүй, манай улсын үнэлэмжийг бууруулсан тохиолдолд Хөгжлийн банкны бондыг худалданавах хөрөнгө оруулагчдын сонирхол хэрхэх бол?

-Эрэлт багасна гэсэн үг. Засгийн газар асар их итгэлтэй байж олон улсын санхүүгийн зах зээлд өөрийн улсын бондоо амжилттай худалдаж хөрөнгө босгоно шүү дээ. Манайд ийм итгэл алга. Одоо гаргалаа гэхэд эрсдэлтэй болчихлоо. Эдийн засгийн нөхцөл байдлыг одоо бид дүгнэх бус олон улсын түншүүд ажиглаж суугаа шүү дээ. Тэд мэдээж, эрсдэлээ тооцно. Хөгжлийн банк 10 жилийн хугацаатай бонд гаргалаа гэхэд хүмүүсийн худалдан авах эрэлт хамаагүй багасна. Учир нь Монголын эдийн засгийн өрсөлдөх чадварыг хөрөнгө оруулагчид аль эрт тооцоод үзчихсэн байгаа.

### -Монгол Улс дотоод эдийн засгийн хямралтай байх нь гэсэн дүгнэлт хийж болох уу?

-Дүгнэлт хийхэд эрт байна. Гэхдээ гадаад эдийн засагт хүчтэй сэргэлт гарахгүй бол манайх дотооддоо тодорхой хэмжээний хямралын шинж тээнэ.

### -Цаашид бат суурьтай, эдийн засгийн өсөлттэй болохын тулд шинэ Засгийн газар, Монголбанк ямар бодлого хэрэгжүүлбэл урьдынхаас илүү амжилттай байх бол?

-Бат суурьтай эдийн засгийг хөгжүүлэхийн тулд үйлдвэрлэлийн том суурьтай эдийн засагтай байх ёстой. Ямар ч нөхцөлд хөдөлгөөн багатай, бодит агуулгатай, тогтсон тодорхой бодлоготой байснаар урт хугацаандаа манайх тогтвортой хөгжинэ. Тиймээс тодорхой хэмжээний үйлдвэржилт явуулах хэрэгтэй. Ингэж байж бат суурьтай эдийн засагтай болно. Тиймээс үйлдвэржүүлэлтийн эдийн засгийн бодлого руу Засгийн газар


үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөө чиглүүлэх нь зүйтэй. Одоогийн байдлаар манайд Голланд өвчинтэй эдийн засгийн ерөнхий шинж бүрдээд байна. Эдийн засгийн бүх нөөц зөвхөн уул уурхайн салбарт шингэж байна. Энэ нь бусад салбарт орох хөрөнгө оруулалтыг шахаад гаргачихаж байна гэсэн үг. Нэг талаасаа, хөрөнгө оруулагчид аль болох ашигтай салбарт л хөрөнгө оруулахыг хүснэ. Тэр нь өнөөдөр манайд шинжлэх ухаан, мөн үйлдвэрлэлийн дэд бүтцэд бус уул уурхайн салбар болж байна. Үндсэндээ боловсруулах үйлдвэрийн салбар устаж байна гэсэн үг. Боловсруулах үйлдвэрийн салбар хоёр нөлөөгөөр шахагдаж байна. Нэгдүгээрт, дотоодод эдийн засагт үүссэн өгөөжит салбарт гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт шууд шилжиж байна. Хоёрдугаарт, боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гадаад зах зээлтэй өрсөлдөж чадахгүй, импортын бараанд шахагдах болсон. Энэ байдлаараа явбал 2-3 жилийн дараа боловсруулах үйлдвэр гэж байх юм уу даа. Осолдохгүй дулааны цахилгаан станц, эрчим хүч нь үлдэнэ байх. Бусад нь мэдэхгүй.

### -Шинэ Засгийн газар боловсруулах үйлдвэрийн салбарт дорвитой хөрөнгө оруулж, бодит үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай юм байна гэж ойлгож болох уу?

-Болно. Ийм зорилгын төлөө л шинэ Засгийн газар тууштай ажиллах хэрэгтэй. Түүнээс иргэдийн халаас руу өнгийсөн халамжийн бодлогоор улс хөгжихгүй гэдгийг өнгөрсөн хугацаанд хангалттай харлаа шүү дээ. Нэг үгээр хэлбэл, төр нь төр шиг л байх хэрэгтэй. Түүнээс өрхийн төсөвт хэт анхаарал хандуулаад байвал улсын төсөвтэйгээ хамт өрхийн төсөв нь "шороодно" шүү гэдгийг анхааруулмаар байна.

### -Монголбанк нэгэнт халсан эдийн засгаа хөргөхийн тулд ямар сөрсөн бодлого хэрэгжүүлбэл үр дүнтэй байх вэ?

-Монголбанкны мөнгөний бодлогоо чангалж байгаа нь өөрийнх нь ▶



Шог зургийг А.Амарсайхан

зорилготой л холбоотой. Үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах чадварыг буулгахгүй, ямар нэгэн аргаар барьж байх үүрэгтэй. Инфляцийг аль болох бага түвшинд барих. Нөгөө талд нь тэлэх бодлого явуулж буй нөхцөлд эдийн засгийг тоормослуулахын тулд Монголбанк бүхий л аргыг хэрэглэх ёстой. Үнэндээ өнгөрсөн хугацаанд Монголбанк сайн ажилласан. Хэрэв муу ажилласан бол бэлэн мөнгөнд живсэн эдийн засаг тун тааруухан байх байлаа. Магадгүй, одоогийн түвшинд байхгүй байсан биз. Инфляцийг тодорхой түвшинд хадгалж чадлаа.

Гэхдээ Монголбанк заримдаа өөрийнхөө бодлогыг сөрсөн алхам хийж байгааг нь хараад гайхдаг. Тэр нь Засгийн газарт зээл олгож, зах зээлд нийлүүлэх бэлэн мөнгөний амьг нээсэн явдал. Мөнгөний нийлүүлэлтийг сууриар нь ихэсгэх үндсэн шалтгаан нь энэ. Бэлэн мөнгийг гүйлгээнд гаргах хоёр арга бий. Нэг нь Засгийн газар зээл өгч гаргадаг, нөгөө нь Төвбанк алт худалдаж аваад, худалдаж авсан алтаа мөнгөжсөн алт гэж бүртгээд түүнийхээ оронд тийм хэмжээтэй дүйцэхүйц мөнгийг гүйлгээнд гаргадаг. Үүнийг дагаж бодитой гүйж буй цаасан мөнгөний хэмжээ нэмэгдэж байдаг. Тэр нь хадгаламжаар дамжаад банкны үржүүлэгчээр мөнгө өсөх ийм л зам байгаа.

Төвбанк Засгийн газарт мөнгө

зээлж байгаа бол мөнгөний нийлүүлэлтийг сууриар нь ихэсгэж байна гэсэн үг. Нэг талаасаа хумих бодлого явуулаад байгаа боловч цаанаа магадгүй дэмжих бодлого байгааг үгүйсгэх аргагүй. Энэ тохиолдолд Төвбанк үнэхээр хатуу байр суурьтай байвал Засгийн газарт зээл олгох ёсгүй. Өөрөөр хэлбэл, нэг гараараа могой барьж болохгүй юм аа.

**-Инфляци 17.5+... гэсэн хүлээлт байна. Гэхдээ инфляцийг аль хэдийнэ 20 давсан хэмээн зарим эдийн засагч хэлэх болсон. Тэгвэл бат суурьгүй эдийн засагт 20 давсан инфляци хэрхэн нөлөөлөх вэ?**

-Манайд эрэлтийн хэт тэлэлт, түүнийг дагасан нийлүүлэлтийн хомсдлоор далимдуулсан өндөр инфляци бий болж байна. Улирлаар нь аваад үзэхэд инфляци ирэх сард Улаанбаатарт буурсан үзүүлэлттэй гарч мэднэ. Инфляцийг бууруулах хоёр төрлийн арга бий. Нэгдүгээрт, гал унтраах арга. Энэ нь эрэлтийг хязгаарлаж, бараг хүнийг мөнгөгүйжүүлж байгаад инфляцийг бууруулж тогтоон барих. Энэ талын аргыг Монголбанк мөнгөний нийлүүлэлтийг хумих, бодлогын хүүгээ нэмэх байдлаар авч ирлээ. Олон улсын валютын сангаас гал унтраах чиглэлийн заавар их ирдэг. Тиймээс ОУВС-гийнхныг чинь галт унтраагчид гэж нэрлэдэг. Инфляци буурахгүй өсөөд байхаар нь эрэлтийг

хааж байгаад унтраадаг гэсэн үг л дээ. Үүний цаана буй инфляцийн эх сурвалжийг устгаж байна гэвэл үгүй.

Инфляцийг унтраахад чиглэсэн цацсан ус нь эдийн засгийг нийтэд нь унтраах эрсдэлтэй. Инфляцийг ул суурьтай нь устгая гэвэл Монгол Улс эдийн засагтаа бүтцийн томоохон өөрчлөлт хийх шаардлагатай. Нэг үгээр хэлбэл, нийлүүлэлтийн тэлэлтийг бий болгосноор инфляци эх сурвалжаараа алга болно. Энэ нь тийм ч амар хийх ажил биш. Харин гал унтраах арга бол хурдан. Гэтэл бүтцийн өөрчлөлт хийнэ гэдэг урт хугацааны асуудал. Бүтцийн өөрчлөлтийг хэрхэн хийх чиглэлээр үндэсний сайн төлөвлөгөө байх ёстой. Түүнийгээ хэрэгжүүлсэн тохиолдолд бодит инфляцийн түвшин буурна.

**-Хамгийн өндөр зарлагатай данхайсан төсвийг хуучин УИХ баталсан. Гэтэл төсвийн орлого нь алдагдалтай хэвээр ирэх намрыг угтах нь. Тиймээс одоогийн Засгийн газар, УИХ төсвийн орлогыг хэрхэн бүрдүүлэх бол?**

-Магадгүй ирэх есдүгээр сард улсын төсөвт тодотгол хийнэ байх. Дөнгөж байгуулагдаж буй Засгийн газар, УИХ амлалт биелүүлэхээс илүүтэй хариуцлага бодож, төсөвт тодотгол оруулна гэж харж байна. Зарлагаа нэмнэ гэхээсээ илүүтэй, танасан байдлаар төсөвт хандах болов уу.

**-Махны, орон сууцны үнэ ▶**

## Манайх дундаж давхаргаа ядуу болгох сэтгэлгээ рүү хөтөлсөн

► **өсөхөөр... дагаад эдийн засаг хөдлөнө. Ийм л хүлээлтээр эдийн засгийг удирдаад байна уу, эсвэл их хүлээлт эдийн засгийн эрх чөлөөг эвдээд байна уу. Та энэ талаар юу хэлэх вэ?**

-Эдийн засгийн үйл хөдлөл бол хүмүүсийн бодож байгаа бодол дээр л тулгуурлаж хийдэг зүйл. Бодол нь нөхцөл байдлыг дүгнээд хүмүүсийн хийж байгаа үйл хөдлөл болно. Түүнийг л бид эдийн засгийн онолд хүлээлт гэж нэрлэдэг. Эдийн засаг өндөр хувиар өснө. Орлого нэмэгдэнэ, эдийн засаг өсөлттэй харагдаж байгаа бол хүмүүсийн хүлээлт хувь хүнд эерэг нөлөөтэй. Харин эдийн засаг асар том дарамттай. Энэ нөхцлийг манайх сөргөөр ашиглаж, үнэ нэмэх суурь нөхцөл болгон ашиглаж байгаа нь эргээд амьжиргааны түвшин буурах, ядуурал нэмэгдэх, инфляци өсөх, улсын хөгжил удааширах хэтийн нөлөө үзүүлж байна.

Хамгийн харамсалтай нь хэт их ашгийн төлөө үнийг шалтгаангүйгээр нэмж байгаа нь монголчуудын амьдралын түвшин мөддөөс айжрахгүй нь гэсэн дүгнэлтэд хүрч, олон хүний итгэл найдварыг бөхөөж байна. Олуулаа хөгжихийн тулд зохистой бодлого, хэмжээтэй үнийн өсөлт байх ёстой. Эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй, гадаад орчин таагүй байвал хүлээлт сөрөг гарч, хүмүүсийн хүлээлт эсрэгээрээ эргэдэг. Хүлээлт эргэсэн тохиолдолд зарим нэг хүмүүс нөөцлөлтийн сэтгэхүйтэй ч болж магадгүй. Гурил, будаагаа худалдаж аваад хадгалах. Энэ нь худалдаа хийж буй хүмүүст үнэ нэмэх өөр нэг шалтгаан болдог.

**-Үнийг манайх яаж тогтоогоод байна вэ. Бүтээгдэхүүний өөрийн өртөг нэмэгдээгүй байхад үнэ өсөж л байдаг тийм баян орон манайх мөн үү?**

-Эдийн засгийн агуулгаараа үнэ гэдэг хоёр зүйлийн хооронд тогтож байдаг эд. Нэг талаасаа хүмүүсийн тухайн бараа бүтээгдэхүүнд хандаж байгаа үнэлэмж буюу цэвэр сэтгэлзүйн асуудал. Хүмүүс бараа бүтээгдэхүүнийг худалдан авахын

төлөө хэдий хэмжээний мөнгө төлөх хүсэлтэй байна гэсэн ийм ойлголтоос тухайн бүтээгдэхүүний үнэ тогтож байдаг. Хүмүүсийн орлогыг нэмээд өгвөл гар нь суларч, орлогын нэмэгдэл нь тухайн бараа бүтээгдэхүүний төлөө мөнгөө төлөх хүслийг нь нэмэгдүүлдэг. Тэгвэл, үнийг дороос хязгаарлаж байдаг зүйл бол үйлдвэрлэлийн зардал буюу өртөг.

Нэг талаас нийлүүлэгчээс гарч ирдэг өртөг зардал, нөгөө талаас тухайн бараанд хүмүүсийн хандаж байгаа үнэлэмж хоёрын дундаас үнэ тогтдог гэж хэлж болно. Бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх өртөг нэмэгдсэн үед үүнийг нийлүүлэлтийн инфляци буюу зардлын инфляци ч гэж нэрлэдэг. Энэ бол үнийн бодит өсөлт. Гэтэл манайд үнийг эрэлтийн инфляци хөтөлж яваад байна. Хүмүүсийн төлөхөд бэлэн байгаа мөнгөний хэмжээ нэмэгдсэн учраас үнийг хөөрөгддөг. Бид эрэлтийн инфляциар удирдагдаж байна. Эдийн засагт цалин өснө, тэтгэвэр нэмэгдэнэ, бэлэн мөнгө тараана гэхээр хүмүүсийн бараа бүтээгдэхүүний төлөө төлөх мөнгөний хэмжээ нэмэгдэж байдаг. Гэтэл үүнийг нь далимдуулж, эрэлт нийлүүлэлтийн заагаар үнэ тогтох атал эрэлттэй тулгуурлаж наймаачид үнийг тогтоогоод байна.

Уг нь хэрэглэгч, нийлүүлэгч хоёр тэнцүү байснаар зах зээлийн үнэ тогтох учиртай. Гэтэл өнөөдөр хэрэглэгч олонтой, үйлдвэрлэгч цөөтэй гажуудалтай зах зээлд үнийг зөвхөн хэдхэн үйлдвэрлэгч л тогтоож байна. Хэрэглэгчийн төлөхөд бэлэн байгаа мөнгөний хэмжээнд тултал нь үнийг тогтоож байна. Гэтэл хэрэглэгч хожоогүй, үйлдвэрлэгчид асар их хожоотой үнийн өсөлтийг бий болголоо. Зах зээлийн үнээр 50, 50 хувиар үнийг тогтоох ёстой. Тултал тогтоосон үнэ эргээд өрхийн эдийн засгийг хямраадаг.

**-Өндөр инфляци хэнд илүү мэдрэгдэх вэ. Сүүлийн үед инфляцийн татвар ч гэж нэрлэх боллоо?**

-Инфляцийн татвар гэдэг нь инфляци татвартай адилхан гэсэн ойлголт л доо. Би урьд нь 1000 төгрөгөөр авдаг байсан зүйлээ өнөөдөр 1200 төгрөгөөр худалдаж авна. Түүний 200 төгрөг нь надаас авч буй инфляцийн татвар гэсэн үг. Миний орлого хэвэндээ бол инфляцийн татвар нэмэгдээд л байна. Уг нь орлого маань түүнтэй адил өссөн бол миний бодит амьжиргааны түвшинд бараг нөлөөлөхгүй. Инфляцийн татвар хэнд илүү нөлөөлөх вэ гэхээр орлого нь хурдацтай өсдөггүй хүнд инфляцийн татвар шууд нөлөөлдөг. Үнийн өсөлтийн хурдаас орлого нь удаан хүмүүс л инфляцийн татварыг мэдрэдэг.

Зарим хүмүүсийн орлогын өсөлт үнийн өсөлтөөс хурдтай өсөж байгаа бол тэр хүн инфляцийн татварыг шууд мэдрэдэггүй өнгөрчихдөг тохиолдол зөндөө бий. Хэн инфляцийн татварыг мэдрэдэггүй вэ гэхээр бизнес эрхлэгчид. Гэхдээ гаргаж буй бүтээгдэхүүний худалдан авалт тодорхой хэмжээгээр буурч, орлогод дам нөлөөлөх үзэгдэл бий. Бүтээгдэхүүний үнэ өснө, компанийн орлого дагаад өснө. Тогтмол орлоготой, орлогын өсөлт муутай хүмүүсийг л төр хамгаалах ёстой. Тогтмол орлоготой, тэтгэвэрийн хүмүүст л инфляцийн татвар хүнд тусаж ирсэн.

**-Монгол Улс дундаж давхаргагүй болж байна гэсэн судалгааг Монгол-банкнаас хийсэн байна билээ. Та үүнтэй санал нийлэх үү?**

-Манай иргэдийн орлогын түвшин элсэн цаг шиг байдалтай байна. Дундаа нарийсаад хоёр тийшээ өргөссөн гэсэн үг. Уг нь дундаа өргөн, хоёр тийшээ нарийхан байх учиртай. Орлогын ийм зөрүүгээс болоод өнөөдөр дундаж давхаргагүй болж байгаа нь үнэн. Түүнийгээ улстөрчид мэдрээд нийгмийн өндөр орлоготой хүмүүсээс өндөр татвар авдаг, бага татвартай иргэдээс бага татвар авах ийм татварын орчинг бүрдүүлэхээр чармайж байна. Сүүлийн үед эдийн засгийн хүртээмжтэй өсөлт гэсэн ойлголт ярих болсон. Энэ нь өсөлт ►

## Хүн бодлоороо мөнгө олдог болохоос мөнгөөр бодол олдоггүй

► хүн дээрээ очиж бууж байх ёстой гэсэн үг юм. Үнэхээр бууж буйг нь харахын тулд хүмүүсийг орлогоор нь багаас нь их рүү жагсаахаар доод талын 20 хувьд өсөлт хүрч байна уу, тэдний орлого нэмэгдэж байна уу гэдэгт л өсөлтийн үр өгөөж оршино. Иргэдийн орлогын өсөлт нь ДНБ-ий өсөлтөөс хурдтай байвал нийгмийн доод давхарга дээшээ босоод ирнэ. Их, багын зөрүү ойртоно гэсэн үг.

### **-Тэгвэл өнөөдөр иргэдийн амьдралын түвшин улам холдоод л байх шиг?**

-Хэмжилт хийгээд үзэхээр эдийн засгийн өсөлтийн хувиас ядуучуудын орлогын өсөлт нь доогуур байна. Өөрөөрхэлбэл, ядуурлын гүнзгийрэлт манайд бий болж байна гэсэн үг. Энэ нь ядуурлынхаа шугамаас бүр уруудаж, туйлаас давсан гэсэн хэлж болно. Өнгөрсөн дөрвөн жилд мөнгө тарааж ядуурлыг бууруулах бус улам ч дэврээлээ. Одоо дахиад иргэдэд бэлэн мөнгө тараавал улсаараа дампуурна. Хот, хөдөөд ялгаагүй Хүний хөгжил сангийн 21 мянган төгрөгөөр иргэд амьдарч байлаа шүү дээ. Бүхэл бүтэн айл амьдарч байсан сарын тогтмол орлогыг одоо эцэс болголоо.

Цаашдаа яах вэ гэвэл иргэдээ байнгын орлоготой тогтмол ажлын байраар хангах шаардлагатай. Үүнээс өөр ядуурлыг бууруулах зэвсэг байхгүй. Эцэстээ ажлын байртай, тогтмол орлоготой байснаар дундаж давхаргыг бүрдүүлнэ. Өнгөрсөн хугацаанд бид үүний эсрэг явсан. Манайх дундаж давхаргаа ядуу болгох сэтгэлгээ рүү хөтөлсөн. Тиймээс өнөөдөр орлогын ядуурал, сэтгэлгээний ядуурал хоёр зэрэг "хөгжлөө".

### **-Дундаж давхарга нийгмийн ихэнх хэсгийг бүрдүүлсэнээрээ төрд ямар ашигтай вэ?**

-Дундаж давхарга нийгмийн ихэнх хувийг эзэлж байвал төрд ашигтай. Төр зөвхөн амьдрах орчныг бүрдүүлэхэд л дундаж давхаргынхан нэг их олон зүйл хүсэхгүй. Тэд хэнээс ч хараат бус амьдарч чадна. Улсаас мөнгө тараагаад ч нэмэргүй. Дундаж

давхарга чинь нийгмийг чирж явдаг зүтгүүр хүч юм. Манайх нийгмийн зүтгүүр болсон дундаж давхаргагүй учраас хөгжихгүй байна. Үнэндээ хөтлөх, хөдөлгөх хүч алга. Хөдөлгөж байгаа хүч нь зөвхөн ашгийн төлөө л зүтгээд байгаа учраас алгаа тосоод ч нэмэргүй.

### **-Эдийн засгийн өгөөжтэй, хүртээмжтэй, тэнцвэртэй өсөлт гэж ярих боллоо.**

-Хүртээмжтэй өсөлт нь эдийн засгийн өсөлт ядуу хэсгийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх ойлголт юм. Уг нь нийгмийн эмзэг хэсэгт л өсөлт мэдрэгдэх ёстой. Өсөлтийг мэдэрсэн хэсэг нь дээшээ гарах учиртай. Гэтэл, манайх таг дүлий хэвээр байна. Магадгүй, хүртээмжтэй, өгөөжтэй, тэнцвэртэй өсөлт гэдэг орчуулгыг эргэж харах хэрэгтэй байх. Хамгийн гол нь ажлын байртай, тогтмол орлоготой байснаар иргэд эдийн засгийн өсөлтийн шимийг хүртэнэ.

### **-Сэтгэлгээний ядуурлаас салахын тулд орлогын ядуурлаас эхэлж гарах ёстой юу. Эсвэл сэтгэлгээний ядуурлаас ангижрах хэрэгтэй юү?**

-Хүмүүсийн сэтгэлгээнд өөрчлөлт орсноор орлогын ядуурал нь арилдаг. Ядуурал өөрөө аль алиных нь учир шалтгаан, үр дагавар. Хөгжсөн орнуудын түүхийг харахаар хүмүүсийн сэтгэлгээнд өөрчлөлт гарснаар орлогын ядуурал нь арилдаг юм байна. Хүн чинь угаасаа тархиараа үйл хөдлөлөө хийж байгаа шүү дээ. Сэтгэлгээнд өөрчлөлт гарах ёстой. Сэтгэлгээнд өөрчлөлт гарснаар хүн ажил хийх хүсэл төрнө, хийж буй ажилдаа амжилт гаргахын төлөө хичээнэ. Нэг үгээр хэлбэл, өөрийнхөө төлөө тэмцэж хоёр ядуурлаас зөв гарна. Манай улсад өнөөдөр бараг ажил хийж байгаа хүн нь алдагдалд ордог ийм сонин үзэгдэл бий боллоо шүү дээ. Гэтэл төр рүү бүх хүн зүтгээд эхэллээ. Үнэндээ төр нийгмийн сайн сайхан, хөгжлийн төлөө ажил хийж байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Сүүлдээ 76 компанитай бүхий УИХ-тай болоод байх шиг. Магадгүй төрд

буй хүмүүс сайхан амьдарч харагдаад байгаа болохоор л хүмүүс тийш хошуурч байгаа байх. Манайд зарим нэг хүмүүсийн сайхан амьдрах нэг хэрэгсэл нь төр ч байж магадгүй юм.

### **-Мөнгө гэж юу вэ?**

-Мөнгө гэдэг зүйлийг хүмүүс хөрөнгө гэдэг утгаар нь ойлгож байна. Амьдрал гэдгийг хөрөнгөтэй байна гэж ухамсарлах болсон. Энэ утгаар нь аваад үзэхээр амьдрал мөнгөн дээр тогтдог гэж хүмүүс хэлэх байх л даа.

Хүний сайн сайхан амьдрал нь тухайн хүний баялгийн багцаас хамаардаг. Баялаг нь хөрөнгө зоорь, эрдэм мэдлэг, найз нөхөд, гэр бүл олон зүйлийн нэгдэл юм. Баялгийг зөвхөн бодит хөрөнгө, мөнгө гэж ойлгох нь их явцуу ойлголт. Энэ утгаараа уг нь амьдрал хүн, түүний буй болгосон баялаг дээр л тогтох ёстой. Тэгэхийн бол мөнгө гэдэг чинь юу ч биш шүү дээ.

Мөнгө нь зүгээр л хүний зохиосон солилцооны хэрэгсэл. Хүмүүс хоорондоо солилцоо хийхийн тулд, хүндрэлтэй асуудлаа арилгахаар энгийн болгосон зүйлийг л мөнгө гэж нэрлээд байгаа юм. Мөнгө нь тухайн хүнд байгаа баялгийн өчүүхэн хэсэг.

Хүн хамгийн гол нь мөнгөний боол болж болохгүй. Харин мөнгийг өөрийнхөө боол болгох тийм л хэмжээнд амьдарч чаддаг байх хэрэгтэй. Хүн ямар нэгэн сайн сайхан зүйлийн төлөө, нийгэмд тустай баялаг бүтээхийн төлөө яваад тэр дундаа мөнгийг хэрэглэгдэхүүн болгож ашиглах нь л хамгийн чухал.

Мөнгө үнэндээ хэрэгтэй юм шиг боловч яг өнөөдрийн байдлаар мөнгө надад тийм ч үнэ цэнэтэй зүйл биш. Хамгийн гол нь надад юу үнэ цэнэтэй байдаг вэ гэхээр миний эргэн тойрны орчин, надтай харилцаж байгаа хүмүүс тэр бүгд надад мөнгөнөөс үнэ цэнэтэй. Хүн бодлоороо мөнгө олдог болохоос мөнгөөр бодол олдоггүй.

Хүний амьдрал тухайн хүний бодол дээр л тогтож байдаг. Хүний бодолд л амьдрах хүч нь байдаг болохоос зөвхөн мөнгөтэй байлаа гээд сайн сайхан амьдралыг бүрдүүлнэ гэвэл эндүүрэл болно. ■



АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

## ГЕРМАНЫ КОМПАНИУДЫН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ТАНИЛЦЛАА

Германы эдийн засгийн хөгжлийн нууц нь юу вэ? Тэгвэл тогтвортой хөгжлийн замналыг сонгосон хариуцлагатай аж ахуйн нэгжүүд нь байгаль орчноо хайрлан хамгаалж, нийгмийн сайн сайхны төлөө зүтгэхийн зэрэгцээ бизнесийн ашиг орлоготой ажиллаж байгаа нь тус орны хөгжлийн нууц нь гэж хэлж болно.

Х.ХУЛАН

**М**онголын уул уурхайн салбарын төлөөлөгчид хариуцлагаа ухамсарласан Германы томоохон компаниудын туршлагатай танилцаад ирлээ. ГОУХАН-ийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага” хөтөлбөрөөс зохион байгуулсан энэхүү аялалд “Багануур”, “Монполимет”, “Эрдэнэс Таван Толгой”, “Пийбоду Энержи”, “Сентерра гоулд”, “Аспайр майнинг”, “Хүннү коал”, “Професи коал”, “Лэйтон”, “МоЭнКо” компанийн ажилтнууд хамрагдсан бөгөөд “Mongolian Economy” сэтгүүлийн баг сурвалжилсан юм.

Та Герман улсыг хэрхэн төсөөлдөг вэ? Таны нүдэнд ямар дүр зураг

харагддаг бол? Эдгээр асуултад хариулах олон хүний төсөөлөлд хамгийн түрүүнд их зохиолч Гёте, сонгодог хөгжим, хөл бөмбөг, шар айраг буух болов уу. Хөгжлийн урт удаан хугацааны түүхийг туулсан Герман соёл урлаг төдийгүй шинжлэх ухаан, техник технологи, эдийн засгаараа дэлхийд тэргүүлэгч байр суурьтай явдаг. “Германд үйлдвэрлэв” буюу “Made in Germany” брэндийг дэлхий даяар андахгүй. Германы эдийн засгийн хөгжлийн нууц нь юу юм бол? Тогтвортой хөгжлийн замналыг сонгосон хариуцлагатай аж ахуйн нэгжүүд нь байгаль орчноо хайрлан хамгаалж, нийгмийн сайн сайхны төлөө зүтгэхийн зэрэгцээ бизнесийн ашиг орлоготой ажиллаж

байгаа нь тус орны хөгжлийн нууц нь гэж хэлж болно.

НҮБ-ын Байгаль орчин, хөгжлийн зөвлөлөөс тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг анх 1980-аад оны эхээр боловсруулж эхэлжээ. Энэ үзэл баримтлал байгалийн нөөц боллоцоог хүн төрөлхтөнд тулгарч буй нийгэм, эдийн засгийн бэрхшээлтэй нягт уялдуулан авч үзсэн байна. Уг Зөвлөлөөс тогтвортой хөгжлийн “Байгалийн баялгийн ашиглалт, хөрөнгө оруулалтын чиглэл, технологийн хөгжлийн баримжаа, бүтцийн өөрчлөлт хоорондоо зохицолтой байх үйл явцыг хэлнэ” хэмээн тодорхойлжээ.

Компанийн нийгмийн хариуцлагын туршлага судлах бидний аяллын ►

▶ хөтөлбөрийн хүрээнд Германы Парламент, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Үйлдвэрчний эвлэл, Германы эрчим хүчний ЭрВэЭ концерн, төмрийн ТюссенКрупп үйлдвэр, Даймлер /Мерседес Бенц/, Сийменс, мэдээлэл технологийн АйБиЭм компани, Бертельсманн сан, Роберт Бош сан, Штуттгарт болон Карлсруэ хотын Худалдаа аж үйлдвэрийн танхим, Карлсруэ хотын Технологийн институт, Дойче банкны нийгмийн хариуцлагын үйл ажиллагаатай нь танилцсан билээ.

Эрдэс баялгийн арвин нөөцтэй манай улсын уул уурхайн салбарт компанийн хариуцлагын сайн бодлого, туршлага зайлшгүй хэрэгтэй. Тиймээс энэхүү аялал цагаа олсон арга хэмжээ байсан юм. ГОУХАН-гийн ЭТИС хөтөлбөрийн дарга Ш.Хансельманн “Манай хөтөлбөр уул уурхайн болон бусад чиглэлийн компаниудтай КНХ-ын асуудал дээр хамтарч ажиллаж байгаа. Өнгөрсөн онд хийсэн судалгааны үр дүнг харахад компаниудад нийгмийн хариуцлага хэрхэн хэрэгжүүлэх тухай дадлагад тулгуурласан мэдээлэл ихээхэн хэрэгцээтэй байгаа нь ажиглагдсан. Иймд Германы компаниудын хариуцлагын туршлага судлах аялалд Монголын уул уурхайн компанийн төлөөлөгчдийг оролцууллаа. Нүдээр үзэж харуулах нь зөвхөн онол уншсанаас илүү их үр өгөөжтэй гэдэгт бид итгэж байна” гэв.



Бундестагийн танхим



Эрчим хүчний ЭрВэЭ концерн

## Бундестаг- эко ордон

Манай аялал Германы Парламент Бундестаг болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас гараагаа эхэлсэн. Германы нийслэл Берлин хотод Ногоон нам, эвслийн хөдөлгөөний үйл ажиллагаа 1980-аад оноос идэвхжсэн гэдэг. Бундестагийн чанх урд талд /манайхаар бол Сүхбаатарын талбай/ торгон ногоон зүлэгтэй бөгөөд бутнууд тарьсан харагдана. Зүлгэн дээр дугуйтай аялагч, жуулчин, хүүхдээ салхинд гаргаж буй гээд хэн дуртай хүн сууж ногоон орчинд алжаалаа тайлна. Парламентын хажуугаар дугуй унасан, бэлтгэлийн хувцастай ▶



Бундестагийн чанх урд талд /манайхаар бол Сүхбаатарын талбай/

► гүйх хүн тасрахгүй. Германы Бундестагийг үзэхээр дэлхийн өнцөг бүрээс жилд гурван сая гаруй хүн Берлин хотноо ирдэг. Сонирхуулахад, Парламентын ордон доторх цахилгаан шат, давхруудын ихэнх хэсгийг нэвт харагдах шилээр хийсэн нь учиртай. Энэ нь төрийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод явах ёстойг архитектурын аргаар ийнхүү илтгэжээ. Нийт 620 гишүүний суудалтай Парламентын танхимын дээд хэсгийг өвөрмөц загвараар бүтээсэн байна. Аварга том шилэн бөмбөлөг дотроос Бундестагийн гишүүдийн хуралдахыг харж болох бөгөөд дээшээ өгсөж, Рейхстагийн орой дээр гарч болохоор хийжээ. Бөмбөлгийн гол хэсэгт конусан хэлбэртэй гэрэл ойлгогч байрлах бөгөөд түүнд суурилуулсан 360 толь нь ордны эрчим хүчийг үр ашигтайгаар гаргаж авдаг технологитой аж. Ногоон эдийн засгийг дэмждэг орны Төрийн ордон нь ч өөрөө ногоон хөгжлийн хамгийн том сонгодог жишээ болж байна.

## Германы Засгийн газрын бодлогод- КНХ

Компанийн нийгмийн хариуцлагын үйл явцыг улс төрийн зүгээс дэмждэгийн илэрхийлэл нь “Герман дахь КНХ” нэртэй үндэсний үйл ажиллаганы төлөвлөгөө. Тус төлөвлөгөөг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас гардан хэрэгжүүлдэг. Үүнд хариуцлагаа ухамсарласан аж ахуйн нэгжийг урамшуулах, Германы эдийн засгийн цөм болсон жижиг дунд үйлдвэрүүд, түүнчлэн төрийн удирдлага болон бизнест КНХ-ыг хэрэгжүүлэх үйл явцыг сайжруулах стратегийн чиглэлүүд ордог байна.

Бундестагийн гишүүн хатагтай Уте Кумпф компаниудад зориулж боловсруулсан КНХ-ын шалгуур үзүүлэлтүүдийг яамд, төрийн байгууллагуудад ч мөн адил биелүүлэх үүрэгтэйг Парламентын ордонд болсон уулзалтын үеэр онцлон тэмдэглэсэн юм. Тэрбээр компанийн нийгмийн харуцлагын талаар илтгэл тавьсан бөгөөд Монголд элэгтэй нэгэн ажээ. Тиймдээ ч бидэнтэй хамт компаниудаараа зочилж, мэдээлэл авахын зэрэгцээ нийгмийн хариуцлагын чиглэлээр зөвөлгөө, нэмэлт мэдээлэл өгч явсан нь бидэнд ч ихээхэн ач холбогдолтой байв.

Германы Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас “Үндэсний компанийн нийгмийн хариуцлагын форум”-ыг гурван жилийн өмнө зохион байгуулжээ. Эдийн засаг, үйлдвэрчний эвлэл, улс төр, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 40 гаруй мэргэжилтэн уг чуулганд оролцож, КНХ-ын талаар санал бодлоо солилцож хэлэлцсэний эцэст форумаас гарсан саналыг нэгтгэж, Засгийн газартаа хүргүүлсэн байна. Гэтэл тэдний саналын 80-аад хувийг нь Засгийн газар хүлээж авч, бодлого, чиглэлдээ тусгаснаар Герман улс үндэсний компанийн нийгмийн хариуцлагын стратегийн суурийг тавьжээ.

КНХ нь тухайн бизнесийн гол үйл ажиллагааг тогтвортой явуулахад чиглэсэн, компанийн стратегид тусгасан үйл ажиллагааг хэлнэ. Германд КНХ-ыг хэрэгжүүлэх үйл явцад тухайн компаниас гадна иргэний нийгэм, улс төр, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн

холбоод болон төрийн бус байгууллагын төлөөлөл өргөнөөр, маш идэвхтэй оролцдог. Засгийн газраас нь КНХ-ыг жижиг, дунд үйлдвэрүүдэд нэвтрүүлэхэд гол анхаарлаа хандуулж, нийтдээ 36 сая еврог энэхүү үйл ажиллагаанд төлөвлөөд байгаа аж. Уг төсвийн хөрөнгийг жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд нийгмийн хариуцлагын талаар сургалт, зөвөлгөө өгөхөд зарцуулдаг байна. Дашрамд дурдахад, КНХ-ын дээрх асуудалд үндэсний форумаас өмнө Германы төрөөс, хувийн хэвшил ийм үйл ажиллагаанд ихэд анхаарч, энэ чиглэлээр тодорхой бодлого явуулдаг байсан туршлагатай юм.

## Шилдэг компаниудын хариуцлагын туршлагаас

Германы нийт аж ахуйн нэгжийн 99.7 хувийг жижиг, дунд үйлдвэр эзэлдэг. Тус улсын эдийн засаг эдгээр аж ахуйн нэгжийн нуруун дээр тогтдог гэж хэлж болно. Европын Холбооноос гаргасан жижиг, дунд аж ахуйн нэгжийн тодорхойлолтын дагуу 250 хүртэлх ажилтантай, 50 сая еврогийн борлуулалттай аж ахуйн нэгж жижиг, дунд бизнесийн ангилалд багтдаг. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны КНХ-ын асуудал хариуцсан ажилтан Антье Бремерийн хэлснээр, Германы ихэнх жижиг, дунд бизнес нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байна гэж зарладаггүй ч боловсрол, нийгмийн чиглэлд ихээхэн хувь нэмэр оруулдаг аж. Бундестагийн гишүүн Уте Кумпф, КНХ нь тухайн компанийн маркетингийн арга хэрэгсэл байж яавч болохгүйг тэмдэглэсэн юм. Тэгвэл манайд тухайн компанийн маркетингийн гол арга, сурталчилгааны нэг хэсэг болоод явж байгаа шүү дээ.

Тогтвортой үйл ажиллагаатай компанийн гол үзүүлэлтэд:

- Ажиллагсадаа шударга хандах
- Байгалийн баялгийг арвилан хэмнэж, үр өгөөжтэй зарцуулна
- Хариуцлагатай ханган нийлүүлэлт
- Хүний эрх болон Олон улсын хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын үндсэн нормыг дагах
- Ил тод байдал зэрэг арга механизм багтдаг байна.

Герман компаниуд нийгэм, байгаль орчин, эдийн засаг гэсэн гурван үндсэн суурь дээр тулгуурлаж хариуцлагаа биелүүлж байна. Энэхүү асуудлыг сүүлийн арваад жилийн турш Германд идэвхтэйгээр хөгжүүлж ирсэн ч анхны суурь нь тэртээх аж үйлдвэржилтийн эрин үед тавигджээ. Германы зохион бүтээгч, “Бош” компанийг үүсгэн байгуулагч Роберт Бош 1906 онд ажлын найман цагийг нэвтрүүлсэн анхны ажил олгогч юм. Бош нийгмийн хариуцлагад ихээхэн анхаардаг байжээ. Тэрбээр ажилчдаа бямба гаригт хагас өдөр ажиллуулахаас гадна ээлжийн амралтыг нь тогтмол олгодог байв. Байгууллагын сонин “Бош- Цюндер” нь “Нийгмийн энх тайван”, “Эдийн засгийн хямралаас сэргийлэх нь” хэмээх сэдвүүдээр /1919 онд/ бичдэг байжээ.

Ажилчдын дундаж цалин зах зээл дээр 1,341 марк байх үед тэрбээр өөрийн ажилчдад дунджаар сард 2,000 маркийн цалин өгдөг байв. Шударга бизнес ►►

▶ тогтвортой бөгөөд ямагт ашигтай байх болно гэдэг зарчмыг баримталдаг байсан Роберт Бош өөрийн сангаа байгуулсан. Түүний сан эдүгээ нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулдаг ач холбогдол бүхий томоохон байгууллагуудын нэг болсон байна. “Бош сан” эрүүл мэнд, шинжлэх ухаан, боловсрол, соёл, нийгэм, олон улсын харилцааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажээ.

## Эрчим хүчний ЭрВЭЭ /RWE/ концерн

Аяллын хамгийн сонирхолтой хэсгийн нэг нь Эссен хотод байрлах эрчим хүчний ЭрВЭЭ концерн байлаа. Манай уул уурхайн компанийн төлөөлөгчид Германы хүрэн нүүрсний ил уурхай дээр газар дээр нь очиж үзэхээс гадна уурхай компанийн хариуцлагаа хэрхэн хэрэгжүүлдэг туршлагаас судлав.

ЭрВЭЭ концерн нь Европын томоохон таван эрчим хүч, газ нийлүүлэгчийн нэг бөгөөд Германдаа нэгд ордог үйлдвэр. Хүрэн нүүрсний ил уурхай, дулааны болон цахилгаан станц, гурван шахмал түлшний үйлдвэртэй. Райнландын хүрэн нүүрсний ил уурхай нийт 20 тэрбум тонн хүрэн нүүрсний нөөцтэй нь тогтоогдсон. Гэтэл 3.5 тэрбум тонныг 2045 он хүртэл ашиглах лицензийг л тус үйлдвэр авсан байна. Үлдсэн нөөцийг хойч үедээ үлдээх шийдвэрийг компани, орон нутгийн хамт гаргажээ. Гайхалтай байгаа биз. Үнэхээр улс орноо, ард иргэдээ, ирээдүйгээ бодсон, хатуу бөгөөд байгальд ээлтэй шийдвэр ажээ.

Компанийн зүгээс эхлээд ашиглая, дараа нь нөхөн сэргээлтээ хийе гэхгүйгээр нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хэдийнэ боловсруулсан байна. Хүрэн нүүрсний олборлолт 2045 онд дууссаны дараа нөхөн сэргээлтийг 180 метрийн гүнтэй, 23 ам.метр нуур байгуулах аж. Райнландын ил уурхай Гарцвайлер, Линден, Хамбах гэсэн гурван хэсэгтэй. Тус уурхайнууд зуны улиралд нийтдээ нэг зуун сая тонн хүрэн нүүрс олборлох хүчин чадалтай. Өнгөрсөн онд 91 сая тонныг олборлож, 70 терра ватт цаг эрчим хүч гаргаж авсан байна. Нойрат дүүрэгт А 1,000 мегаваттын хүчин чадалтай хоёр цахилгаан станц барьжээ. Цахилгаан станцын техникийн шинэчлэл нь хариуцлагын бас нэг хэлбэр болдог аж.

### ЭрВЭЭ нь КНХ-ийн стратегидаа

1. Уур амьсгалын хамгаалал
2. Эрчим хүчний үр өгөөжтэй байдал
3. Техникийн шинэчлэл
4. Ханган нийлүүлэлтийн баталгаа
5. Түгээлтийн сүлжээ
6. Эрчим хүчний үнийн асуудал
7. Хүн амын насжилт
8. Ажлын аюулгүй байдал, эрүүл мэнд
9. Байгаль орчин
10. Нийгмийн хариуцлага зэргийг тусгаж ажилладаг ажээ.

Германд уурхайн үйл ажиллагаа явуулахад олон тооны зөвшөөрлийн бичиг, лиценз авдаг. Жишээ нь тухайн үйл ажиллагааг явуулах зайлшгүй шаардлагатайг

харуулсан эдийн засгийн үндэслэл, байгаль орчны иж бүрэн судалгаа, эмиссын хамгаалалт, нөхөн сэргээх аргачлал, газар хөдлөлтийн судалгаа, олборлолт явуулах газар эртний түүх, дурсгалын өв байгаа эсэхийг шалгасан бичиг зэрэг холбогдох баримтыг бүрдүүлэх ёстой.

“Сүүлийн арваад жилийн турш ХБНГУ-д байгаль орчны асуудалд түлхүү анхаардаг болсон” гэж “ЭрВЭЭ” компанийн Байгаль орчин хариуцсан инженер Др. Бернхард Гойманн хэлэв. Райнландын уурхайн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн хэсэгт амьдардаг ховор төрлийн сарьсан багваахай, тоншуулыг нүүлгэн шилжүүлэхийн тулд компани хувь хүнээс газар худалдаж аваад парк болгон өөрчилж, амьтдыг нүүлгэн шилжүүлсэн байна. Үйлдвэрийн үйл ажиллагаа чухал боловч Герман улс байгаль орчноо нэгдүгээрт авч үздэгийн тод жишээ юм. Мөн ажилчдаа тогтвортой ажиллуулахын тулд тэдний эрүүл мэнд, ажлын аюулгүй байдалд ихээхэн анхаардаг. Сонирхуулахад, Герман Улс 2020 он гэхэд цөмийн эрчим хүчнээс бүрмөсөн татгалзаж, сэргээгдэх эрчим хүчийг түлхүү хөгжүүлэхээр зорьж байгаа аж.

## ТюссенКрупп төмрийн үйлдвэр

Дуисбург хотын иж бүрэн төмөрлөгийн томоохон үйлдвэр бидний сонирхлыг ихэд татсан юм. Үйлдвэрийн ажилчны хувцас өмсөж, хамгаалалтын нүдний шил зүүснээр, ган үйлдвэрлэх явцтай танилцсан юм. Германы аж үйлдвэрийн “зүрх” гэж нэрлэж болохоор энэхүү үйлдвэрийн орчин үнэхээр анхаарал татам. Эргэн тойронд нь мод, том хоолойнууд дунд ногоон орчин бүрджээ. Үйлдвэрийн талбай дунд туулай гүйж яваа нь автобусны цонхоор харагдлаа. Гангийн үйлдвэрийн байрны гадна талд ажилчдынхаа зургийг өлгөжээ. Үйлдвэр гэхлээр уур, утаа униар савссан байх гэж бодсон миний төсөөллөөс ангид орчин угтсан билээ.

Фридрих Крупп анх 1811 онд Эссен хотод төмрийн үйлдвэрийн суурийг тавьснаар тус компанийн түүх эхэлдэг. ТюссенКрупп Стийл нь жилдээ 12-30 сая тонн төмөрлөгийн бүтээгдэхүүн /цахилгаан шат, үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологи, усан онгоцны систем/ үйлдвэрлэж олон улсын тавцанд нийлүүлдэг. Компани дэлхийн 80-аад улс оронд нийт 180.000 ажиллагсадтай.

Тогтвортой байдал гэдэг ойлголт ТюссенКруппын хувьд шинэ ойлголт биш, хоёр зуугаад жилийн улбаатай. 1870 онд үйлдвэр өөрийн эмнэлэгтэй болж, ажилчдынхаа эрүүл мэндэд анхаарч байсан. Үйлдвэр тогтвортой байдлын уламжлалт удирдлагын аргыг өнөөг хүртэл ашиглаж байна. Энэ нь оролцогч талуудтай хамтарч, улс төр, зах зээлийн судалгаа шинжилгээн дээр тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг гэсэн үг. ТюссенКрупп нийгмийн, байгаль орчин ба эдийн засгийг зөв хослуулах нь чухал гэж үздэг. “Бид нэмүү өртгийн сүлжээний нэг хэсэг гэдгээ ухамсарласан бөгөөд бүтээгдэхүүнээ стандартын өндөр түвшинд байлгах зарчмыг баримталдаг” гэж Байгаль орчин, тогтвортой байдлын хэлтсийн дэд ерөнхийлөгч Д. Ханс-Йорн Веддиге хэлсэн. Өөрөөр хэлбэл, чанараа сайн байлгаж байж бизнес тогтвортой байна гэж ойлгох нь. ▶

► **Компанийн баримталдаг есөн зарчим:**

-Харилцагчдад хандсан тогтвортой шийдэл. Дуисбург хотод төмрийн шинэ технологи үйлдвэрлэхээс гадна үйлчлүүлэгчдээ бүтээгдэхүүнээ хэрхэн үр ашигтай хэрэглэхийг зөвлөдөг. Ингэснээр бүтээгдэхүүнийг эдэлгээг уртасгаж, байгаль орчинд хувь нэмэр оруулж байна.

-Германы гол түүхий эд бол мэдлэг гэж тооцдог. Иймд авъястай, чадварлаг боловсон хүчнийг үйлдвэртээ татах нь чухал.

-Байгууллагын соёл, үнэт чанарыг эрхэмлэх

-Эрчим хүч, түүхий эдэд ээлтэй үйлдвэрлэл явуулах

-Эрүүл мэнд, аюулгүй байдлын өндөр стандарт

-Компанийн засаглал, хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулах

-Тогтвортой ханган нилүүлэлтийн систем

-Орон нутгийн оролцоо

-Ил тод байдал

Тогтвортой байдал гэдгийг хүрээлэн буй орчин, нийгэмдээ халгүй байх гэж үздэг байна. ТюссенКрупп үйлдвэр байгаль орчны асуудалд жилд нэг тэрбум евро зарцуулдаг аж. Үйлдвэрийн усны хэрэглээний талаар Түүхий эд хариуцсан захирал Клаус Поттхофоос лавлахад: “Төмрийн үйлдвэрийн усны хэрэглээ өдөрт гурван сая литр шоо метр. Олон жил үйлдвэрийн үр өгөөжтэй байдлыг дээшлүүлэх үйл явцын ачаар ашигласан усныхаа 96 хувийг дахин боловсруулдаг болсондоо бид баяртай байна. Цаашид 97 хувь болгох гэж ажиллаж байгаа” гэж хариулав. Төмрийн үйлдвэр гэхлээр хүмүүс байгаль орчныг бохирдуулдаг, хаа нэгтээ цөлийн ойролцоо байдаг байх гэсэн ойлголттой байдаг. Гэтэл ногоон орчинд, тэр дундаа дархан цаазат газартай хил залгаа оршиж, ашигтай бизнесийн үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрийн тод жишээ бол ТюссенКрупп. Дэлхийд тоосжилтын системийг нэвтрүүлэн ашиглаж байгаа цорын ганц үйлдвэр. Шинэчлэлт технологийг шийдлээ болгосон компанийн жишээ юм. ►►



Хүрэн нүүрсний ил уурхай



Төмрийн ТюссенКрупп үйлдвэр. Ган үйлдвэрлэх явц



Төмрийн ТюссенКрупп үйлдвэрийн нүүрс коксжуулах явцтай танилцсан нь

► **Штуттгарт хотын Худалдаа, аж үйлдвэрийн танхимаар зочилсон нь**



*Штуттгартын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч Херберт Мюллер*

Бид аяллынхаа хүрээнд Германы хоёр дахь том танхим буюу Штуттгарт хотын Худалдаа, аж үйлдвэрийн танхим дээр очсон юм. Тус танхим 150 мянган гишүүн компанитай. Эдгээр нь Баден-Вюртемберг мужийн нийслэл Штуттгарт хот болон түүний ойролцоох орон нутагт үйл ажиллагаагаа явуулдаг ажээ. 19-р зууны Европын олон дайн дажингийн ард гарсан тус мужийн хүн амын орлогын түвшин доогуур байсан. Харин Шорндорфын инженер Готтлиб Даймлер “Загвар зохион бүтээлийн хаан” Вильхельм Мэйбахтай хамтарч, анхны мотортой дугуйг 1885 онд, удаах онд анхны автомашиныг зохион бүтээснээр мужийн эдийн засаг цэцэглэж эхэлсэн түүхтэй.

Штуттгарт хотын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч, ноён Херберт Мюллер бидний сонирхсон асуултад хариулж, аяллын оролцогчидтой Монгол-Германы эдийн засгийн өнөөгийн байдлын талаар яриа өрнүүлсэн.

**-КНХ-ыг хэрэгжүүлэх алхмыг юунаас эхлүүлэх хэрэгтэй гэж Та үзэж байна?**

-КНХ-ыг хүний нөөцийн тууштай бодлогоос эхлүүлэх хэрэгтэй. Учир нь хүний нөөц бол компанийн хариуцлагын түлхүүр нь болдог. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг ижил түвшинд авч үзэх нь мөн чухал. Бид нар гишүүн компаниуддаа юу гэж зөвлөдөг вэ гэвэл, олсон ашгаа компанийн өмч хэлбэрээр хадгалаач ээ гэдэг. Компани тодорхой хэмжээний хөрөнгөгүй бол банкнаас хамааралтай болж, зах зээл дээр оршин тогтноход бэрх. Мөн судалгаа шинжилгээг байнга явуулах

шаардлагатай. Германы компаниуд 2008, 2009 оны санхүүгийн хямралаар ажилчдаа халаагүй. Хямралын үед хүний нөөцөө авч үлдэх нь маш чухал байсан. Ханган нийлүүлэгч компаниудтайгаа сүлжээ үүсгэх ач холбогдолтой гэж зөвлөж байна. Германд нийт 4-5 сая жижиг, дунд үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг. “Даймлер”, “Сийменс” гэхчлэн томоохон компаниудад жижиг ханган нийлүүлэгчид ихээхэн хэрэгцээтэй байдаг. Мөн манай гишүүн компаниуд арван жилийн сургуулиудаар явж, хүүхдүүдэд ирээдүйд мэргэжлээ зөв сонгоход нь түлхэц болох тал дээр их ажилладаг.

**-Германд КНХ-ын талаар хэзээнээс эхэлж ярих болсон бэ?**

-КНХ-ын ойлголт одоогоос арваад жилийн өмнөөс хөгжиж эхэлсэн. Томоохон хөрөнгө оруулагчид үйл ажиллагаагаа тогтвортой байлгах үүднээс хариуцлагын бодлого боловсруулсан. Тэд КНХ-ыг хэрэгжүүлж эхэлсэн. Тэд жил бүр энэ чиглэлээрээ тайлан бичиж, хийсэн ажлаа олон нийтэд тайлагнадаг. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд тэдгээрээс суралцаж, өөрийн компанийн стратегитэй болцгоосон. Гэхдээ тэдэнд зааварчилгаа, сургалт семинар зайлшгүй шаардлагатай.

**Германы эдийн засгийн амжилтад нөлөөлсөн макро-эдийн засаг болон улс төрийн хүчин зүйл:**

1. Сайн боловсролын тогтолцоо
2. Дотоод бүтэц
3. Найдвартай хуулийн орчин
4. Авлига
5. Зохистой татварын бодлого
6. Дотоодын төдийгүй гадаад зах зээл, олон улсын кластер
7. Залуучуудыг аж ахуйтан, хувийн компанитай болоход нь туслах.
8. Эрчим хүчний хангамж
9. Банкны тогтолцоо. Үйлчлүүлдэг банкаа ойр ойрхон солихгүй, урт хугацаанд банктай хамтарч ажиллах.
10. Аж үйлдвэр, ажлын байр бий болгохыг дэмждэг улстөрчид хэрэгтэй. Эдийн засаг бизнесгүйгээр оршин тогтнохгүй. Төр нь аж үйлдвэрээ дэмжих нь чухал үүрэгтэй.

Ийнхүү Германы компаниуд нь нийгмийн хариуцлагыг нэн тэргүүнд тавьж, аль болох байгальд ээлтэй бизнесийн үйл ажиллагаа явуулахыг зорьдог нь алхам тутамд мэдрэгдэж байлаа. Тиймдээ ч дэлхийн ногоон улсаар удаа дараалан шалгардаг биз ээ. Ард иргэд нь ногоон сэтгэхүйтэй, төр засаг нь ногоон бодлого баримталж, хувийн хэвшлийнхэн нь ч хариуцлагаа ухамсарлахаар ногоон хөгжил, тайван амьдрал аяндаа өөрөө бүрэлддэг ажээ.

*“Дойче Банк”, “АйБиЭм”, “Сийменс” компанийн нийгмийн хариуцлагын тухай дараагийн дугаараас уншина уу. ■*

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

## ГУРВАЛСАН ТҮНШЛЭЛ

Компанийн нийгмийн хариуцлагын талаар хүмүүс хэсэгчилсэн ойлголттой байгаа нь тийм ч гайхах зүйл биш. Компанийн нийгмийн хариуцлага нь 5-7 элементээс бүрдсэн цогц ойлголт. Өнөөдөр та дэлхийн хаана ч очсон эдгээр элементийн талаар өөр өөр өнцгөөс авч үзсэнийг харна.



Х.БУЛГАН

*Германы “Компанийн нийгмийн хариуцлагын төв” нь ГОУХАН-ийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага” хөтөлбөрийн даалгавраар Монголын уул уурхайн салбар дахь компаниудын нийгмийн хариуцлагын хэрэгжилтийн талаар судалгаа хийсэн билээ. Энэ талаар Германы “Компанийн нийгмийн хариуцлагын төв”-ийн гүйцэтгэх захирал Сузан Лангтай ярилцлаа.*

**-Та “Компанийн нийгмийн хариуцлага” судалгааныхаа ерөнхий үзэл баримтлалыг танилцуулна уу?**

-Бид Монголд өнөөдөр юу болж байгаа талаар гадна талаас мэдээлэл бэлтгэхийг хүссэн. Энэхүү судалгааг гаргахдаа дотоодын 25 шийдвэр гаргагч болон мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагыг ашигласан. Үндсэндээ уг судалгаа нь Монгол дахь компанийн нийгмийн хариуцлагын талаарх ойлголт, түүний хэрэгжилт, бизнес, иргэний

нийгэм ба Засгийн газрын тухай иргэдийн санал бодол дээр тулгуурласан гэж хэлж болно. Тэгэхээр Монголын компаниудын байдал ямар байгаа талаар ерөнхий дүр зургийг өгнө гэдэгт найдаж байна.

**-Судалгааны дүгнэлтээс харахад уул уурхайн компаниудын дунд компанийн нийгмийн хариуцлагын талаар ойлголт дутмаг байгаа тухай өгүүлсэн байна. Тэгвэл уул уурхайн компаниуд нь компанийн нийгмийн хариуцлагыг хэрхэн ойлгох ёстой вэ? ▶**

► -Ерөнхийдөө компанийн нийгмийн хариуцлагын талаар хүмүүс хэсэгчилсэн ойлголттой байгаа нь тийм ч гайхах зүйл биш. Компанийн нийгмийн хариуцлага нь 5-7 элементээс бүрдсэн цогц ойлголт. Өнөөдөр та дэлхийн хаана ч очсон эдгээр элементийн талаар өөр өөр өнцгөөс авч үзсэнийг харна. Монголын хувьд ч мөн адил өөрийн гэсэн онцлогтой шинж чанар их буйг бид олж харлаа. Гэхдээ энэ нь зөвхөн Монголд хамааралтай нэгдсэн ойлголт бүрдүүлсэн гэж ойлгож болохгүй. Харин компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх анхны алхмыг хийлээ гэсэн үг. Уялдаа холбоог бий болгоход мэдээлэл, бодит дадлага, мөн хувийн компанийн зүгээс манлайлал, оролцогч талаас олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийх хэрэгтэй болно. Бидний олж мэдсэнээр Монголын бизнесийн салбарт бусад компани, салбарынхныгуриалан, Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагуудыг энэхүү үйл хэрэгт татан оролцуулах манлайлагчид байна.

**-Та 2001 оноос хойш улс төрийн зөвлөхөөр ажиллаж иржээ. Таны ажлын гол чиглэл иргэний оролцоог судлах явдал юм байна. Төрийн бус байгууллага болон иргэний нийгэм нь бизнесийн ертөнцөд хэрхэн үүрэгтэй вэ?**

-Иргэний нийгмийн байгууллага хүчээ авсан газарт компанийн нийгмийн хариуцлагын хоёр чухал үүргийг харж болно. Эхнийх нь компани ямар буйг ажиглан, үүргээ дутуу биелүүлж яваа компаниудыг буруутган шүүмжлэх. Энэ нь эрсдэлийн менежментийн асуудлыг хөндөж байгаа учир нэг талаар эдийн засгийн хөшүүрэг болдог. Төрийн бус байгууллагууд нь хоточ нохойны үүргийг сайн биелүүлж байна гэсэн үг. Нөгөө талаар төрийн бус байгууллагууд нь компаниудын байгаль орчноо хамгаалах, орон нутгийн оролцоо, хүний эрхийн хамгааллыг дэмжих зэрэг өөрсдийн стратегийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Иргэний нийгэм нь хоточ нохой болон компанийн түншийн үүргийг давхар биелүүлдэг. Тиймээс төрийн бус байгууллага нь компаниудтай

түншлэх бүрэн чадвартай гэдгийг компанийн зүгээс мэдэх нь хамгийн чухал.

**-Төрийн бус байгууллагуудын чадавхи бүтцийг дээшлүүлэхэд төрөөс ямар механизм авч хэрэгжүүлэх хэрэгтэй вэ?**

-Энэ нь нэлээд хэцүү сэдэв. Иргэний нийгмийн чадавхийг дээшлүүлэх нь ганц төрөөс хэрэгжүүлэх асуудал биш юм. Мэдээж төрөөс тэдэнд найдвартай хуулийн үндэс суурийг тавьж өгөх үүрэгтэй. Тодорхой бус нөхцөл нь иргэний нийгмийн байгууллагуудад бэрхшээл л авчирна.

Нөгөө талаас Засгийн газрын өөр нэг үүрэг нь иргэний зарим нэг үйлчилгээг төрийн бус байгууллагуудад даатган, үүний хариуд төлбөр төлж татаас үзүүлэх боломжтой. Үүгээрээ тэднийг зөвхөн санхүүжүүлээд зогсохгүй энэ үйлчилгээг үзүүлэхүйц нарийн мэргэжлийн боловсон хүчинтэй болох боломжтой. Миний ойлгосноор Монголын хувьд энэ талд хийсэн зүйл хараахан байхгүй боловч ийм чиглэлд хандах зарим нэг санаа гарч байгааг хэлэх хэрэгтэй. Гуравдугаарт, Засгийн газар нь иргэдээ үг хэлэх, эсэргүүцэх, эвлэлдэн нийлэх мөн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг хамгаалах учиртай. Төр, засаг нь эдгээр эрхийг батлан даах ёстой.

**-Монголын олонхи төрийн бус байгууллага нь санхүүжилтийн асуудалтай тулгардаг. Үүнийг хэрхэн шийдэх боломжтой вэ?**

-Санхүүгийн асуудал нь дэлхийн өнцөг булан бүрт тохиолддог л доо. Чинээлэг гэж нэрлэгдээд буй орноос ядуу буурай улсад ч элбэг тохиолддог асуудал. Гэхдээ зарим нэг арга бий. Жишээ нь гишүүнчлэлтэй болох. Орон нутгийн байгууллага нь гишүүддээ ашиг тустай байж, үүний төлөө хүмүүс мөнгөө сэтгэл хангалуун төлөх гишүүнчлэлийн татаасыг бий болгох хэрэгтэй. Өмнө нь Засгийн газар болон компаниудын жишээн дээр дурдсанчлан төлбөртэй үйлчилгээ үзүүлэх боломж бий. Мөн хувийн бизнес эрхэлдэг загварын дагуу зах зээл бизнестэй холбоотой боломжийг нээн нийгмийн хэрэгцээг хангаж болно. Түүнээс гадна олон улсын

хандивлагчдын тусламжтайгаар төсөл хэрэгжүүлэн төрийн бус байгууллагуудыг дэмжиж болох юм.

**Германы Засгийн газраас компанийн нийгмийн хариуцлагыг хэрхэн хэрэгжүүлдэг туршлагаас ярьж өгнө үү?**

Засгийн газраас компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд дэмжиж болох хэд хэдэн чиглэлүүд бий. Жишээ нь Германы Байгаль орчны хуулийн өндөр стандарт нь Германы компаниудад байгаль орчны стандартыг сайтар дагахад хүргэсэн. Европын улс орнууд үндэсний түвшиндөө хэрэгжүүлэх стратегийг боловсруулж гаргасан. Энэхүү стратегид компанийн нийгмийн хариуцлага улс орны хувьд ямар ач холбогдолтой, компаниудыг энэ тал дээр хэрхэн дэмжих гэхчлэн бодлогыг оруулсан. Тус стратегийг Германд нэг жилийн хугацаанд олон талын оролцогчдын төлөөлөлтэйгээр хамтарч боловсруулсан. Компанийн нийгмийн хариуцлагын бүхий л тусгалыг олон нийттэй хэлэцсэний үндсэн дээр эдгээрийг нэгтгэж, Засгийн газрын бодлогын түвшинд хэрэгжүүлж эхэлсэн.

Миний бие Германд ажлын байрны эрүүл мэнд ба аюулгүй байдал чиглэлээр хяналтын албанд ажиллаж байсан. Дүрэм журмаа биелүүлээгүй компанийг шийтгэдэг л хүмүүс энд ажилладаг байх гэж би урд нь боддог байсан. Гэтэл тэд хяналтын ажлаас гадна компаниудтай тулж ажиллаж, тэдэнд тусалдаг байсныг олж мэдсэн юм. Дүрэмд заасан олон заалтыг биелүүлэх амаргүй байдаг учир мэргэжилтнүүдийн тусламж ихээхэн шаардлагатай байдаг.

Төрийн албаныхны хувьд тэд тухайн компанид ирж хаана тусламж дэмжлэг хэрэгтэй байгааг шийддэг, эсвэл үүргээ биелүүлээгүй компанийг шахааж шаарддаг. Хяналтын албанынханд техникийн ур чадвар ихээхэн шаардагддаг. Тэд гаргасан дүрэм журмаа сайн мэдэж байж компаниуд дүрмээ хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгаж, шаардаж ажиллана. Үүгээрээ ажлын байран дахь аюулгүй байдлын стандартыг хөгжүүлж урагшуулдаг юм. ■

ЭРҮҮЛ МЭНД

## ЧИМЭЭГҮЙ МӨХӨЛ

### Б.ЭНХМАРТ

Хавдар. Энэ үг ДОХ гэдэг үнээс ч илүү айдас дагуулдаг болжээ. Ямар янзын эс, вирүсээс үүсч, хавдар хэмээх өвчин болоод байгааг одоо хэр нь судалж байна. Дэлхийн нийтийг сүүлийн арван жилд сандаргаж, олноор нь хоморголон устгаж буй ганц өвчин энэ л болоод байна. ДЭМБ-аас “Хортой хоргүй хавдрын улмаас жилд дэлхийн 11 сая гаруй хүн хорвоог орхиж байна. Түүний 3000 гаруй нь Монгол Улсын иргэн” хэмээн өнгөрсөн нэгдүгээр сарын тайландаа дурджээ. Хавдар өвчний улмаас таалал төгсөж буй хүмүүсийн нэгдүгээрт, элэгний хорт хавдар орж байна. Энэ нь амьдралын буруу хэвшил, архи, тамхины хэрэглээнээс шууд хамааралтайг эрдэмтэн, судлаач, эмч, мэргэжилтнүүд хэчнээн учирлаад ч нэмэр алга. Өдөр ирэх тусам энэ төрлийн өвчтэй хүний тоо нэмэгдсээр. Үүний дараа уушгины, умайн хүзүүний, хөхний, улаан хоолойн, шулуун гэдэсний хорт хавдар зонхиж байгаа аж.

### Мөнгө төлвөл өнөөдөр, үгүй бол сарын дараа хэзээ үхэхээ мэдэж болно

Хавдар судлалын үндэсний төвийн ачаалал хэд дахин нэмэгдэж, үүдээр нь “Арай ч хавдартай болчихоогүй байлгүй дээ” гэх горьдлогын харцтай, хүмүүс эмчид үзүүлэх ээлжээ хүлээн сууна. Харамсалтай нь эмч нарын хүрэлцээ муутайгаас өвчтөнүүдийн ихэнх нь 14-30 хоногийн дараа анхан шатны үзлэгт орж байна. Гэхдээ тус эмнэлэгт очсон бүхэн дээрх шиг олон хоног хүлээхгүй байж бас болдог гэх. Дугаар, дарааллын мөнгө болох 10 мянган төгрөг, түүний дээр илүү цагаар үзүүлэх 15 мянган төгрөг, үүнийг нь найрч өгч байгаа эмч, сувилагч, дараалал хуваариллагчид хэдэн төгрөг атгуулчихвал хэдхэн цагийн дотор үзлэгт орж болно. Эхнээсээ төлбөртэй явчихсан хойно эмч болгонд 10-15 мянган төгрөгийн үзлэгийн төлбөр төлнө. Хэдэн ч эмчээр орж, оношоо тодруулж болно. Ходоодын хорт хавдартай хүний хөл, гарын шуу, хамрыг ч үзэж болно. Нэгнээсээ нөгөө рүү бичиг хийгээд л явуулаад байна. Өвдсөн хүн ингэх л ёстой юм байлгүй гээд төлбөрөө төлж, үзүүлнэ. Эцэст нь хавдаргүй, ядаргаанаас үүдэлтэй өвчтэй болоод гараад ирэх нь ч бий. Зарим нэгэнд тус үйлчилгээ зол болж, хорт хавдрын эхэн үе дээрээ оношлуулж, эмчилгээ хийлгэдэг ч энэ нь өдрийн од мэт цөөхөн байдаг нь нууц биш. Үнэндээ үнэхээр хавдартай, өвдөж, зовсон хүмүүст тэр их мөнгө байхгүй учраас дарааллаа хүлээдэг. Энэ хугацаанд зарим нь амиа алдаж, заримынх нь өвчин сэдэрч, үхэх сэхэхийн заагт очиж байна. Энэ бол өнөөгийн манай нийгмийн үнэн дүр төрх.

Монголд жилд 4500 орчим хүн шинээр хортой болон

хоргүй хавдартай хэмээн оношлуулж, тэдний 40 орчим хувь нь эмнэлгийн тусламж авч чадахгүй нас барж байна. Харин дэлхийд жилд 15 сая гаруй хүн тус өвчнөөр шинээр өвчилж, 11 сая орчим нь таалал төгсдөг тухай Дэлхийн хорт хавдрын судалгааны агентлагаас мэдээлж байна.

### Эдийн засагт хамгийн хохиролтой өвчин

Хавдар нь үхэлд заавал хүргэдгээс гадна эдийн засагт хамгийн их хохиролтой өвчин юм. Хумхаа, ДОХ зэрэг хүн төрөлхтөний ихэд айдаг өвчнүүдээс илүүтэйгээр хөдөлмөрийн бүтээмжгүй болгож, эдийн засгийн болоод нийгмийн харилцаа, сэтгэл зүйн уналтад оруулдаг аж. Энэ талаар Дэлхийн хорт хавдрын судалгааны агентлаг нэгэн судалгаа хийжээ. Тэд 2011 онд хорт хавдраас болж дэлхийн эдийн засагт 987 тэрбум ам.долларын алдагдал үүссэн нь дэлхийн нийт бүтээгдэхүүний 1.5 хувьтай тэнцэж байна гэж үзжээ. Гэхдээ энэ нь судалгааны тоо бөгөөд үүний цаана ганцхан хоног ч болтугай үр хүүхдэдээ харагдах гээд халаасаа тэмтэрч, байгаагаа үрэн таран хийж суугаа хэчнээн хүн байгаа нь тодорхойгүй. Түүнчлэн энэ жил дэлхийн хэмжээнд хорт хавдраар нас барж байгаа хүний тоо зүрхний өвчнөөс болж нас барж буй хүмүүсийн тооноос илүү гарах төлөвтэйг тооцоолжээ.

Олон зуун эрдэмтэн, судлаач хортой, хоргүй хавдрын бүрэн арилгах эмийн жор, эмчилгээний аргыг олох гэж толгой өөд татах завгүй ажиллаж байна. Тэд сар бүр хавдрын эсрэг эмчилгээнд зориулсан хэдэн сая эмчилгээний арга, эм, бэлдмэлийг ДЭМБ-ын Хавдартай тэмцэх тасгийн эрдэм шинжилгээний газарт хүргүүлж байгаа ч тусыг эс олж байна. Туршилтаар үр дүнтэй нь батлагдаж, өвчнийг удаашруулах зориулалттай вакцин, эм бэлдмэлүүд эмийн худалдааны салбарт тэргүүлэх байр эзэлж, үйлдвэрлэл нь эрэлтээ дийлэхгүйд хүртээд байна.

### Хэн сайн дураараа хавдартай болдог вэ

Дэлхийн хорт хавдрын судалгааны агентлагийн мэргэжилтнүүд 184 оронд 2008 оноос хойш явуулсан судалгаагаар амьдрал нь чинээлэг хүмүүс хорт хавдраар илүү өвчилж нас бардгийг нотолжээ. Хэрвээ хүн төрөлхтөн хэт ядуу, хэт баян зүй тогтол бүхий хэв маягаа өөрчлөхгүй бол 2030 он гэхэд хорт хавдартай хүний тоо одоогийнхоос 90 хувиар, хорт хавдрын гаралт даруй 80 хувиар өсөх тухай тооцоолон гаргажээ. Энэ нь дэлхийн хүн амын бараг гуравны нэг нь хорт хавдраар өвчилнэ гэсэн үг юм. ▶

Гэхдээ ямар ч өвчин хэлж биш хийсэж ирдгийн адилаар баян, ядуугаар нь ялгахгүй. Тиймээс зөвхөн хавдраас ч бус ямар нэг өвчнөөс өөрийгөө болон бусдыгаа хамгаалах үүрэг хүн бүхний өмнө тулгарч байна.

ДЭМБ-аас Хавдар үүсэхэд хамгийн ихээр нөлөөлдөг зарим хүнсний зүйлийг нэрлэжээ. Үүнд, Өөх тостой, шарсан хуурсан бүтээгдэхүүн, шарсан төмс, давс хэтрүүлэн хэрэглэх, чипс, архи, тамхи, хийжүүлсэн ундаа, бэлэн гоймон, консерватив агуулсан хүнсний бүтээгдэхүүн, жимс, сэргээшийн төрлийн ундаанууд, бүх төрлийн чихэр зэрэг багтжээ. Хорт хавдар үүсгэх хүнсний бүтээгдэхүүн хамгийн ихээр хэрэглэдэг орноор Вьетнам, Хятад, Тайвань, Филиппин, Орос тэргүүлэх байр эзэлдэг аж. Японы эрдэмтдийн баталснаар өдөр тутмын хүнсэндээ лууван, бууцай, улаан перц хэрэглэдэг хүн хорт хавдрын эрсдэлээс 25 хувиар хамгаалж чаддаг аж. Хорт хавдраас сэргийлэхэд Е аминдэм чухал бөгөөд А аминдэм хавдар өвчний явцыг удаашруулах үйлчилгээтэй байдаг гэнэ.

## Хавдар хүн төрөлхтөний шинэ төрөл зүйлийн эхлэл гэв үү

Хүнд хавдар бий болдог шалтгааныг Америкийн эрдэмтэд тун өвөрмөц байдлаар төсөөлж байна. Тэдний үзэж буйгаар уг өвчин нь хүний хувьсалд шинэ төрөл бий болох өөрчлөлт орж байгаагийн нотолгоо, харин хавдартай өвчтнүүд нь шинжлэх ухааны хэлээр өөрчлөгдөн хувирч буй хэлбэрүүд гэнэ.

АНУ-ын Калифорнын их сургуулийн эрдэмтэн Питер Дьюсберг тэргүүтэй эрдэмтэд энэ санааг саяхан “Cell Cycle” сэтгүүлд бичсэн нийтлэлдээ тусгажээ. Тэд “Хавдар бий болох нь шинэ төрөл зүйл бий болох аргуудын нэг юм. Учир нь хорт хавдрын эсүүд зарчмын хувьд тогтвортой тооны хромсом агуулж байгаа гэх тогтвортой шинж тэмдэггүй гэж судлаачид үзэж байна. Хавдар үүсч буй нь гентэй бус, хромсомын гэмтэлтэй холбоотой. Тийм өөрчлөлт нь нэг бус, хэдэн мянган генийг хамардаг. Энэ нь эсийг эрс өөрчилж, шинэ төрөл зүйл бий болоход хүргэж болно. Нөгөө талаар одоо цоо шинэ төрөл зүйл бий болох гэж байна гэж ойлгох хараахан болоогүй. Гэхдээ хувьсах үйл явц эхэлж байж ч мэднэ. Эсийн шилжилтийн тогтворгүй үе дуусах буюу хүн нас барсан ч хавдрын эсүүд амьдрах чадвараа хадгалсан хэвээр байдаг. Хэрвээ энэ үеийг л хүн давах дархлаатай болвол шинэ төрлийн бие махбодь болох боломжтойг үгүйсгэх аргагүй юм. Тийнхүү хувирч өөрчлөгдөх үйл явц хэдэн сая жил ч үргэлжилж болзошгүй учраас хавдартай нэн даруй тэмцэх хэрэгтэй” гэжээ. Дьюсбергийн багийн энэ нээлт онолын төдийгүй практик ач холбогдолтой бөгөөд хорт хавдартай тэмцэх аргыг боловсронгуй болгоход тус болж болох юм хэмээн судлаачид үзэж байна.

Лондонд төвтэй Дэлхийн хавдар судлалын олон улсын сан болон ДЭМБ-ын гаргасан хавдар өвчинтэй холбоотой зарим статистик мэдээг хүргэе.

Түгээмэл тохиолддог хавдрын найман төрлөөр 100 мянган хүнд тохиолдох элэгний хорт хавраар Монгол Улс 94.4 гэсэн үзүүлэлтээр дэлхийд тэргүүлсэн төдийгүй

удаах байрт шалгарсан Гамби улсыг ардаа хол хаяжээ. Хүйсээр ялгаж үзвэл, эрчүүдийн дунд 100 мянган хүнд тохиолдох өвчлөл 116.6, харин эмэгтэйчүүдийн дунд 74.8 гэсэн асар өндөр тоон баримтууд нь Монгол Улс удаах байрт шалгарсан улсуудаас даруй 2-3 дахин өндөр байна.

Байр	Улс орон	100 мянган хүнд тохиолдох элэгний хорт хавдрын өвчлөл (насаар жигнэсэн)
1	Монгол	94.4
2	Гамби	36.1
3	Хятадын Тайпей (Тайвань)	35.7
4	Лаос	33.8
5	Тайланд	29.7

Монголчууд дахин хоёр төрлийн хавдрын өвчлөлөөр дэлхийд тэргүүлж байгаа нь улаан хоолой ба ходоодны хавдар юм. Улаан хоолойн хорт хавдрыг тамхи татах, хүний папиллом вирус, түүнчлэн архидалт, таргалалттай холбоотой хэмээн тайлбарлажээ. Зуун мянган хүнд ногдох үзүүлэлтээр, монгол эрчүүд (21.7) эмэгтэйчүүдээсээ (16.1) илүү өвчилдөг байна.

Байр	Улс орон	100 мянган хүнд тохиолдох улаан хоолойн хорт хавдрын өвчлөл (насаар жигнэсэн)
1	Монгол	18.7
2	Малави	17.4
3	Өмнөд Африкийн БНУ	17.3
4	Хятад	16.7
5	Лезото	14.6

Ходоодны хорт хавдрыг хеликобактер пилори гэгч бактери, Элстейн-Баррын вирус үүсгэдэг. Түүнчлэн бүдүүн болон шулуун гэдэсний хорт хавдраар өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг давсалсан болон давс ихтэй хоол хүнс нь өвчин үүсгэдэг ажээ. Зуун мянган хүнд ногдох үзүүлэлтээр, монгол эрчүүд (48.2) эмэгтэйчүүдийг (22.3) давамгайлж явна.

Байр	Улс орон	100 мянган хүнд тохиолдох ходоодны хорт хавдрын өвчлөл (насаар жигнэсэн)
1	БН Солонгос улс	41.4
2	Монгол	34.0
3	Япон	31.1
4	Хятад	29.9
5	Гондурас	26.6
5	Гватемал	26.6